



НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ГАРЫН АВЛАГА

Үндэсний хэмжээний оролцогч талуудад зориулсан замын
зураглал

2025 оны IV сар

Open
Government
Partnership





Танилцуулга

Гарын авлагын зорилго юу вэ?

Энэхүү гарын авлага нь Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ)-ийн үйл явцад оролцож буй үндэсний оролцогч талуудад зориулсан практиктай, өөрөө ашиглах боломжтой нөөц юм. НЗТ-д оролцох журам, зөвлөмж болон шилдэг туршлагыг танилцуулж, гишүүдэд шаардлага хангасан, нээлттэй засгийн шинэлэг реформыг хэрэгжүүлэхэд нь туслах зорилготой юм.

Гарын авлагын хэсэг бүрд тодорхой дүрэм, гол зөвлөмж болон холбогдох нэмэлт эх сурвалж багтсан. Та төлөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжилтийн бүх шатанд энэхүү гарын авлагыг лавлагаа болон чиглүүлэх хэрэгсэл болгон ашиглаж болно.

Гарын авлагыг хэнд зориулсан бэ?

Энэ гарын авлага нь үндэсний хэмжээнд НЗТ-н үйл ажиллагааг зохион байгуулдаг гол оролцогч талуудад зориулсан юм. Үүнд дараах бүлэг орно:

- Засгийн газрын НЗТ-ийг хариуцсан Ажлын алба (АА) болон тэдгээрийн баг
- НЗТ-ийг зохион байгуулахад оролцдог гол иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)

Гарын авлагын цахим хувилбар



НЗТ-ийн Үндэсний гарын авлагын хамгийн сүүлийн хувилбарыг цахимаар хүлээн авах боломжтой.

www.opengovpartnership.org/national-handbook хаягаар зочилно уу.



Агуулга

Тайлбар толь ба нэр томъёо

5

ТОМ ЗУРАГЛАЛЫГ ОЙЛГОХ НЬ

1. Нээлттэй засгийн суурь үндэс	6
1.1 Үүсгэн байгуулсан зарчмууд	7
1.2 НЗТ-ийн загвар	8
1.3 НЗТ-ийн 2023–2028 оны стратеги	10
2. НЗТ-ийн гишүүнчлэл, засаглал ба үйл ажиллагааны хүрээ	11
2.1 НЗТ-ийн гишүүнчлэл	12
2.1.1 НЗТ-д элсэх	
2.1.2 Үндэсний гишүүдийн үндсэн үүрэг, хариуцлага	
2.1.3 Улс орны гишүүнчлэлийн төлбөр	
2.1.4 НЗТ-ийн хариуцлагын механизм	
2.2 Гол оролцогч талууд	15
2.3 НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ	17
3. НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт	19
НЗТ-ИЙН ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ	
4. Үндэсний түвшинд хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэх нь: Үндэсний зөвлөл (ҮЗ)	23
4.1 ҮЗ-ийн үүрэг, хариуцлага	25
4.2 ҮЗ байгуулахад анхаарах гол хүчин зүйлс	25
5. Мэдээллийн ил тод байдлыг хангах нь	28
5.1 НЗТ-д ашиглах үндэсний цахим хуудас	29
5.2 Цахим баримтын сан	30
6. Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалт боловсруулах	33
6.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үеийн оролцоо, хамтран бүтээх стандартыг хэрэгжүүлэх	34
6.2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний дүрэм, журам	36
6.2.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөний хугацаа	
6.2.2 НЗТ-д илгээх	
6.2.3 Саатах	
6.2.4 Нэмэлт, өөрчлөлт	
6.2.5 Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө	
6.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалт боловсруулах	42
6.3.1 Гол мөчүүд	
6.3.2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга	
6.3.3 Үүрэг амлалтын загвар	

7. Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалтыг хэрэгжүүлэх	49
7.1 Оролцоог тогтворжуулах	50
7.2 Хэрэгжилтийг төлөвлөх	51
7.3 Хэрэгжилт дэх оролцогч талуудын үүрэг	52
7.4 Хяналт, үнэлгээ	52
7.4.1 Өөрийн үнэлгээний тайлан	
8. Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-аар дамжуулан эгэх хариуцлага ба суралцах явцыг хангах нь	53
8.1 ХБТМ гэж юу вэ?	54
8.2 ХБТМ хэрхэн ажилладаг вэ?	55
8.3 ХБТМ шаардлагыг хэрхэн дүгнэдэг вэ?	57
9. Нээлттэй засгийн сорилтоор амжилтаа ахиулах нь	58
9.1 Яагаад сорилтод нэгдэх хэрэгтэй вэ?	59
9.2 Тавигдах шаардлага	59
9.3 Сорилтын үүрэг амлалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал	60
9.4 Хүсэлт илгээх дүрэм	60
10. Засгийн газрын бусад түвшинд оролцоог дэмжих нь	62
10.1 Орон нутгийн засаг захиргаа	63
10.1.1 Орон нутгийн түвшинд НЗТ-ийн гишүүнчлэл	
10.1.2 Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн үүрэг амлалтыг тусгах	
10.1.3 Нээлттэй засгийн сорилтод оролцох	
10.2 Парламент	64
10.2.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох	
10.2.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх	
10.2.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх	
10.3 Шүүх байгууллага	66
10.3.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох	
10.3.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх	
10.3.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх	
10.4 Бие даасан байгууллага	67
10.4.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох	
10.4.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх	
10.4.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх	
11. Нэмэлт материал	68



Тайлбар толь ба Нэр томъёо

НЗТ-ийн **нэр томъёоны тайлбар толь** нь НЗТ-тэй холбоотой нэр томъёоны цорын ганц, албан ёсны эх сурвалж юм. Бүрэн тайлбар болон сэдвийн ангиллыг дараах хэсгээс үзнэ үү.

[Суурь үнэлгээ](#)
[НЗТ-ийн засаглал](#)

[Бодлогын чиглэл](#)
[Үйл явц](#)

Энэ хэсэг гол нэр томъёоны тайлбарыг агуулна.

Үйл ажиллагааны төлөвлөгөө: Тодорхой, хугацаатай, баталгаажих боломжтой үүрэг амлалтыг багтаасан, нээлттэй засгийн шинэтгэлийн зорилготой баримт бичиг юм. Энэхүү баримт бичгийг Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд хамтран боловсруулж, хоёр эсвэл дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлдэг.

Үйл ажиллагааны хүрээ: Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө, Бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө, НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрөөр дамжуулан оролцох, Нээлттэй засгийн сорилт зэрэг олон хэлбэрээр оролцох боломжийг олгодог НЗТ-ийн уян хатан оролцооны бүтэц юм.

Хүсэл зорилго: Ил тод байдал, иргэдийн оролцоо, олон нийтийн хяналтыг хангахын тулд тухайн үүрэг амлалт одоогийн туршлагаас хэр зэрэг давж, бодит бөгөөд институцийн эсвэл системийн өөрчлөлт хийхээр чиглэсэн байдлыг илэрхийлнэ.

Хамтран бүтээх: Засгийн газар, иргэний нийгэм болон бусад оролцогч талууд нээлттэй засгийн үүрэг амлалт, шинэчлэлийг хамтран тодорхойлох үйл явц юм. Энэ нь НЗТ-ийн бүх үе шатанд хамаарах бөгөөд “Оролцоо ба хамтран бүтээх стандарт”-ын дагуу хэрэгжинэ.

Үүрэг амлалт: Хамтран бүтээсэн, хугацаатай, баталгаажих боломжтой мөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан арга хэмжээ юм. Үүрэг амлалт бүр нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэх зорилготой бөгөөд тодорхой алхам, хүрэх үе шатыг агуулж НЗТ-ийн зарчимд нийцсэн байна.

Олон талт оролцогчдын форум буюу Үндэсний зөвлөл (ҮЗ): Үндэсний зөвлөл нь Засгийн газар болон иргэний нийгмийн хооронд байнгын харилцаа, хэлэлцүүлгийн орон зай бий болгох нийтлэг загвар юм. Үүний тулд тогтмол уулзалт зохион байгуулж, олон талт оролцогчдыг хамарсан байх ёстой.

НЗТ-ийн гишүүн: НЗТ-д нэгдсэн үндэсний болон орон нутгийн засаг захиргааны нэгж юм. Засгийн газар шалгуурыг хангаж, Нээлттэй Засгийн Тунхаглалыг дэмжсэнээр гишүүнээр нэгдэнэ. Орон нутгийн засаг захиргаа нь НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрөөр дамжуулан гишүүнээр нэгдэнэ.

НЗТ-ийн үйл явц: Засгийн газар НЗТ-д нэгдсэн цагаас эхлэн хэрэгжих бүтэцтэй оролцооны зам юм. Энэ нь “Оролцоо ба хамтран бүтээх стандарт”-ын удирдамж дор явагдана.

Оролцоо ба хамтран бүтээх стандарт: Засгийн газар, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг НЗТ-ийн бүх үе шатанд чиглүүлдэг таван стандарт юм. Стандарт тус бүрд зайлшгүй биелүүлэх шаардлага байх бөгөөд оролцогч талуудын хүсэл зорилгыг тодорхойлдог.

НЗТ-ийг хариуцсан албан тушаалтан: НЗТ-ийн оролцоог зохион байгуулах, хэлэлцүүлгийн орон зайг удирдах, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан чиглүүлэх, Дэмжих нэгж болон ХБТМ-тай хамтран ажиллах зорилгоор тэргүүлэх яамнаас томилогдсон ахлах зэрэгтэй төрийн албан хаагч юм.

Хараат бус тайлагнах механизм (ХБТМ):

Үйл ажиллагааны төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байгааг хянах, дүн шинжилгээ хийх зорилготой, нотолгоонд суурилсан хараат бус үнэлгээ хийдэг НЗТ-ийн хариуцлагын тогтолцоо юм.

Зайлшгүй биелүүлэх шаардлага: НЗТ-ийн

“Оролцоо ба хамтран бүтээх стандарт”-ын дагуу НЗТ-ийн гишүүд зайлшгүй биелүүлэх ёстой үндсэн шалгуур бөгөөд үүнийг ХБТМ үнэлнэ.

Бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө:

Парламент, шүүх байгууллага эсвэл бие даасан байгууллагаас өөрийн эрх мэдлийн хүрээнд нээлттэй засгийн зорилтуудыг ахиулах зорилготой боловсруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс тусдаа байдаг.



1

Нээлттэй засгийн суурь үндэс

Гол зөвлөмж

- НЗТ нь ил тод байдал, иргэдийн оролцоо, олон нийтийн хяналтын зарчимд тулгуурладаг.
- НЗТ-ийн алсын хараа нь иргэний нийгэм болон ард иргэдтэй түншлэн ажиллаж, нээлттэй засгийн ардчиллыг бэхжүүлэн, нийгмийн үр өгөөжийг сайжруулах явдал юм.
- НЗТ-ийн эрхэм зорилго нь Засгийн газар болон иргэний нийгмээс шинэчлэгч, манлайлагч нараас бүрдсэн, өсөн тэлж буй олон нийтийг урамшуулах, холбох, боломжоор хангах явдал юм.
- НЗТ нь өвөрмөц, тэгш хамруулсан, уян хатан загвараар үйл ажиллагаа явуулдаг.
- НЗТ нь зөвлөлдөх үйл явцаар боловсруулсан **2023–2028 оны стратегийг** одоогоор хэрэгжүүлж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



1.1 Үүсгэн байгуулсан зарчмууд

Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ) нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд иргэдэд илүү хүртээмжтэй, хариу үйлдэлтэй, эгэх хариуцлагатай нээлттэй засгийг хөгжүүлэх, иргэн ба Засгийн газар хоорондын харилцаа сайжрах, урт хугацааны үр өгөөж өгөх зорилготой дэлхий дахины санаачилга юм. Үүсгэн байгуулсан цагаас хойш НЗТ нь нээлттэй засгийг дэмжих дэлхийн хэмжээний хамтын хүчин чармайлт болон өргөжиж, олон арван **улс орон**, зуу гаруй **орон нутгийн нэгж**, мянга мянган иргэний нийгмийн байгууллагыг нэгтгэн хамтран ажиллаж байна.

- **Алсын хараа:** Иргэний нийгэм болон ард иргэдтэй хамтрах, нээлттэй засгийг бий болгох, ардчиллыг бэхжүүлэх, нийгмийн үр дүнг сайжруулах.
- **Эрхэм зорилго:** Засгийн газар болон иргэний нийгмийн шинэчлэгч болон тэмцэгч нарын олон нийтийг урамшуулах, холбох, хамтын үйл хэргийг дэмжих.

НЗТ нь ил тод байдал, иргэдийн оролцоо, олон нийтийн эгэх хариуцлага гэсэн үндсэн зарчмууд дээр суурилдаг.

Ил тод байдал

Ил тод байдал нь “төрийн мэдээлэл (үйл ажиллагаа болон шийдвэрийн талаарх мэдээлэл багтана) нээлттэй, иж бүрэн, хугацаатай, олон нийт чөлөөтэй ашиглах боломжтой, нээлттэй өгөгдлийн стандартыг хангасан (жишээ нь анхдагч өгөгдөл, машинд уншигдах боломжтой) байх”-ыг хэлнэ.

Ил тод байдал нь иргэд өөрийн эрхээ эдлэх, Засгийн газарт эгэх хариуцлага тооцох, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг олгодог.

ЖИШЭЭ:

- Мэдээллийн хүртээмж болон/эсвэл нээлттэй өгөгдлийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах
- Төрийн мэдээллийг урьдчилан (идэвхтэй) эсвэл хүсэлтээр (идэвхгүй) нийтлэх
- Эзэмшигчийн мэдээлэл, төртэй хийсэн гэрээ, лобби байгууллагын тухай мэдээллийн нээлттэй бүртгэл
- Нээлттэй өгөгдлийн стандартын дагуу мэдээлэл нийтлэх
- Мэдээлэл хүлээн авах эрхийг бэхжүүлэх хууль эрх зүйн болон институцийн зохицуулалт

Иргэдийн оролцоо

Иргэдийн оролцоо нь “Засгийн газар иргэдийг олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, санал санаачилга гаргах, улмаар илүү хариу үйлдэлтэй, шинэлэг, үр дүнтэй засаглалыг бий болгоход хувь нэмэр оруулахыг уриалан дуудах”-ыг хэлнэ.

Иргэд идэвхтэй оролцох үед Засгийн газар илүү хариу үйлдэлтэй, шинэлэг, үр дүнтэй болдог.

ЖИШЭЭ:

- Олон нийт шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх боломжийг хангах шинэ эсвэл сайжруулсан процесс, механизм
- Төлөөлөл багатай бүлгийн оролцоог хангах механизм
- Иргэний болон улс төрийн эрхийг баталгаажуулсан эрх зүйн орчин

Суурь үндэс

- Албан ёсны ардчилсан үйл явц (сонгууль, өргөдөл, иргэний санал, санаачилга гэх мэт)-ыг бэхжүүлэх
- Иргэний нийгэм нь олон нийтийн санхүүжилтэд хяналт тавих, ил тод удирдах боломжийг олгодог механизм
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван замаар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчсөн тохиолдолд эрхээ хамгаалах хүртээмжийг сайжруулах.

Олон нийтийн эгэх хариуцлага

Олон нийтийн эгэх хариуцлага нь “төрийн байгууллага өөрийн үйл ажиллагаанд тавигдсан шүүмжлэл, шаардлагад үндэслэн арга хэмжээ авах, хууль болон үүрэг амлалтаа биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээхийг шаардсан дүрэм журам, зохицуулалт, механизм хэрэгжих”-ийг хэлнэ.

Хамгийн чухал нь олон нийтийн эгэх хариуцлага гэдэг нь зөвхөн дотоод механизмаар хязгаарлагдахгүй бөгөөд иргэд өөрсдөө хяналтын механизмыг ашиглах, идэвхжүүлэх боломжтой байхыг хэлдэг.

ЖИШЭЭ:

- Төрийн байгууллагын гүйцэтгэлд иргэний аудит болон иргэдээс санаачилсан шинэ буюу сайжруулсан гомдол, давж заалдах үйл явц өрнөх
- Хууль зүйн туслалцаанд хүрэх боломжийг илүү хямд, хурдан, ашиглахад хялбар механизмаар сайжруулах
- Төрийн гол үйлчилгээ, дэд бүтцэд иргэдийн оролцоотой аудитын механизм нэвтрүүлэх
- Шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх
- Төрийн байгууллагын лоббид ил тод байдал, эгэх хариуцлагын тогтолцоо бий болгох (нийтийн лобби бүртгэл, уулзалтын тэмдэглэл нийтлэх, иргэдээс мэдээлэл хүлээн авах сувгууд гэх мэт)
- Төрийн гол үйлчилгээ, дэд бүтцэд иргэдийн оролцоотой аудитын механизм ажиллах

Мөн түүнчлэн НЗТ нь эдгээр үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй хөндлөн огтлолцож дэмжих элементийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг байна.

- **Тэгш хамралт:** Засгийн газар хүн бүрт, ялангуяа түүхэндээ гадуурхагдаж ирсэн бүлгүүд — хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд, LGBTQIA+ хүмүүс, цөөнхийн бүлгүүд, уугуул иргэд болон хязгаарлагдмал нөөцтэй иргэдэд үйлчлэх ёстой.
- **Шинэчлэл ба технологи:** Засгийн газар иргэдэд технологид нээлттэй хандах боломж олгох, шинэ технологи нь шинэчлэлийг хөтлөх үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрөх мөн иргэдийн технологи ашиглах чадамжийг нэмэгдүүлэхийг эрмэлзэх ёстой.

НЗТ-ийн гишүүн улс орнууд энэхүү түншлэлд нэгдэхдээ **Нээлттэй Засгийн Тунхаглалыг** баталснаар эдгээр зарчмыг хүндэтгэж хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг (“НЗТ-д нэгдэх тухай” хэсгээс үзнэ үү).

1.2 НЗТ-ийн загвар

НЗТ-ийн загвар нь хэлэлцүүлэг, үйл ажиллагаа, эгэх хариуцлага, сургалт гэсэн дөрвөн үндсэн тулгуурт суурилдаг.

Суурь үндэс

Хэлэлцүүлэг: Засгийн газрын бүх түвшин, салбарын төлөөлөгчид болон мянга мянган иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллаж, нээлттэй засгийн шинэчлэлийг хамтран бий болгодог (“Үйл ажиллагааны төлөвлөгөө” болон “Үүрэг амлалт боловсруулах” хэсгээс үзнэ үү). Энэ нь авлигын эсрэг тэмцэл, иргэний орон зай, цахим засаглал, тэгш хүртээмж, төрийн үйлчилгээ зэрэг өргөн сэдвийг хамардаг.

Үйл ажиллагаа: НЗТ нь Засгийн газар өөрийн үндэсний нөхцөл байдалд тохируулан шинэчлэл хийх боломжтой уян хатан бүтцийг бий болгодог. Ингэснээр Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага болон бусад оролцогчид өөрийн онцлогт нийцсэн шинэчлэлийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой болдог.

Эгэх хариуцлага ба суралцах явц: НЗТ-ийн хариуцлагын гол хэрэгсэл бол шинжлэх ухаанд суурилсан үнэлгээг хийдэг Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) юм. Мөн ижил төстэй гишүүд харилцан туршлага солилцож, илүү үр дүнтэй шинэчлэл хийх боломжийг бүрдүүлдэг.

Энэ өвөрмөц загвар нь иргэний нийгмийн байгууллагууд болон/эсвэл иргэдийн шууд оролцоогоор дамжуулан нээлттэй засгийн үйл ажиллагааг боловсруулах, хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг. 2011 оноос хойш дэлхий даяар мянга мянган **үүрэг амлалтыг** хамтран боловсруулан хэрэгжүүлж байна.

НЗТ-ийн загварыг өвөрмөц болгодог зүйлс

Тэнцвэртэй түншлэл

НЗТ-ийн загвар нь Засгийн газар болон иргэний нийгмийн хамтын ажиллагаанд тулгуурласан бөгөөд хамтдаа илүү үр дүнд хүрэхийг зорьдог. Засгийн газар төрийн дээд түвшний манлайлал, хүсэл зорилготой шинэтгэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн албан тушаалтнаар хангаж өгдөг бол иргэний нийгэм тэнцүү түншийн хувиар тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, үйл ажиллагааг хамтран боловсруулах, үр дүнг хянах үйл явцад оролцдог. Энэхүү хамтран манлайлах загвар нь үндэсний болон олон улсын түвшинд адилхан хэрэгждэг бөгөөд удирдлагын бүтцэд Засгийн газар ба иргэний нийгэм хамтран даргалах хэлбэрээр багтдаг.

Хариуцлагад суурилсан үйл ажиллагаа

НЗТ бол тодорхой үүрэг амлалтыг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаатай платформ юм. Гишүүн орнуудын гаргасан эдгээр үүрэг амлалтыг НЗТ-ийн Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) болон бусад хяналтын байгууллага хянадаг. Эдгээр төлөвлөгөө нь үндэсний тэргүүлэх чиглэлүүдэд ахиц гаргахын зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилго, G7-ийн амлалт зэрэг дэлхийн хэмжээнд өгсөн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх хөшүүрэг болдог. Эгэх хариуцлагыг хангахын тулд ХБТМ явцын хяналт болон үнэлгээ хийдэг. Мөн харилцан суралцах бүтэцтэй үйл явц — жишээлбэл, туршлага солилцох, тогтмол үнэлгээ хийх зэрэг нь үүрэг амлалтыг тасралтгүй сайжруулахад тусалдаг байна.

НЗТ-ийн загварыг өвөрмөц болгодог зүйлс

Улс орон өөрөө удирдах эрх

НЗТ нь улс орон болон орон нутгийн нэгжүүдэд өөрсдийн тэргүүлэх чиглэл, бодлогын зорилгоо тодорхойлох эрх мэдлийг олгодог. Үндэсний болон орон нутгийн хэлэлцүүлгийн үеэр оролцогч талууд гол шинэчлэлийн чиглэлийг тодорхойлдог. Энэхүү загвар нь уян хатан бөгөөд улс орнуудын эхлэх цэгийн ялгааг хүлээн зөвшөөрдөг ч, өндөр зорилго тавьж, тухайн орны нөхцөл байдалд нийцсэн утга төгөлдөр өөрчлөлтийг хэрэгжүүлэхийг дэмждэг байна.

Дэлхий дахины олон нийт

НЗТ нь нээлттэй засгийн шинэтгэлийг урагшлуулахад урам зориг, туршлага солилцоо, дэмжлэгийн дэлхий дахины тавцанг бүрдүүлдэг. Гишүүн орнууд бодлогын гол чиглэлд техникийн болон санхүүгийн тэргүүлэх мэргэжилтнүүд, түнш байгууллагуудад хандах, салбар хоорондын хамтын ажиллагаанд оролцох боломжтой болдог. Түүнчлэн, гишүүд НЗТ-ийн харилцаа холбооны хэрэгсэл, шагнал, нөлөө бүхий өөрчлөлтийг харуулсан түүхээр дамжуулан бусдад таниулах боломжийг нэмэгдүүлдэг. Мөн гишүүд НЗТ-ийн дэлхийн болон бүс нутгийн арга хэмжээ (НЗТ-ийн Дээд хэмжээний уулзалт, Бүс нутгийн уулзалт, Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног гэх мэт)-д оролцох замаар холбогдох боломжтой.

НЗТ-ийн Дэмжих нэгж болон Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) нь гишүүн орнууд өөрсдийн нээлттэй засгийн зорилтуудад хүрэх, үнэ цэнээ нэмэгдүүлэхэд нь туслахын тулд зогсолтгүй дэмжлэг үзүүлдэг. НЗТ-ийн Дэмжих нэгж болон ХБТМ-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг [“НЗТ-ийн гол оролцогчид”](#) хэсгээс үзнэ үү.

1.3 НЗТ-ийн 2023–2028 оны стратеги

НЗТ нь **2023–2028 оны стратеги** хэрэгжүүлж байгаа бөгөөд тус стратегийг 1000 гаруй хувь хүн, бүлэг, сүлжээ, НЗТ-ийн гишүүд болон олон талт оролцооны форумас оруулсан хувь нэмрийн үндсэн дээр боловсруулсан юм. Энэхүү стратегийн үр дүнд иргэдийн хүлээлтэд нийцсэн, нээлттэй, ардчилсан Засгийн газрыг бий болгох тодорхой үйл ажиллагаа, шинэлэг санаа, үзэл баримтлалд суурилсан мөн илүү улс төрийн, үнэт зүйлд тулгуурласан түншлэл рүү чиглэсэн НЗТ-ийн шинэчлэгдсэн алсын хараа бий болсон юм.

НЗТ-ийн 2023–2028 оны стратеги нь энэхүү зорилгыг ахиулахын тулд таван гол чиглэлийг агуулсан төлөвлөгөөг боловсруулсан.

- **Хүчирхэг олон нийтийг бий болгох:** НЗТ нь шинэчлэгчдийн дэлхий дахины сүлжээг өргөжүүлж, тэдэнд нээлттэй засгийг дэмжихэд шаардлагатай хэрэгсэл, холбоо, дэмжлэгийг олгоход төвлөрөн ажиллана.
- **Нээлттэй засгийг төрийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгох:** НЗТ нь нээлттэй засгийн зарчмуудыг төрийн бүх түвшин, салбарын бодлого боловсруулах, олон нийтийн үйлчилгээг хүргэх үйл явцад нэгтгэхийг зорино.
- **Иргэний орон зайг хамгаалан тэлэх:** Иргэд нийгмийн амьдралд чөлөөтэй, аюулгүйгээр оролцох боломжгүй бол нээлттэй засаг хөгжих боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, НЗТ нь иргэний нийгэм чөлөөтэй, аюулгүй үйл ажиллагаа явуулах орон зайг хамгаалан өргөжүүлэхэд анхаарна.
- **Нээлттэй засгийн шинэчлэлийг хурдасгах:** НЗТ нь нийт түншлэлийн хүрээнд арван гол бодлогын чиглэлд төвлөрсөн сорилтыг эхлүүлж, бүх гишүүдийг авлигын эсрэг тэмцэх, цахим технологийг хариуцлагатай ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх зэрэг бодит ахиц гаргахыг уриална.
- **Урам зориг өгөх, туршлага хуваалцах төв болох:** НЗТ нь дэлхийн шинэчлэгчдээс гарсан шинэлэг санаа, амжилттай хэрэгжсэн шинэчлэлийн нотолгоо, урам зориг өгөх түүхийг хуваалцдаг төвлөрсөн эх сурвалж болохыг зорино.

НЗТ-ийн 2023–2028 оны стратегийн тухай [эндээс](#) илүү дэлгэрэнгүй танилцана уу.



2 НЗТ-ийн гишүүнчлэл, засаглал, үйл ажиллагааны хүрээ

Гол зөвлөмж

- Засгийн газар НЗТ-ийн гишүүн болохын тулд тодорхой шалгуур хангасан байх бөгөөд НЗТ-ийн Үнэт зүйлийн шалгалтад тэнцэх шаардлагатай.
- НЗТ-ийн гишүүн болсон Засгийн газар тодорхой үүрэг хариуцлагыг биелүүлэх ба гишүүнчлэлийн хяналт-шинжилгээний механизмаар хянагдана.
- НЗТ-ийн гишүүн орон бүрд нээлттэй засгийг ахиулахад дотоод болон олон улсын өргөн хүрээний оролцогч талууд дэмжлэг үзүүлдэг.
- НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь гишүүн оронд Засгийн газрын түвшин, салбар бүрийн оролцоотойгоор олон хэлбэрээр хамтран ажиллах боломж олгодог.
- Үйл ажиллагааны хүрээний гол анхаарал нь иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлдэг НЗТ-ийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан нээлттэй засгийн шинэчлэлийг урагшлуулахад чиглэдэг



2.1 НЗТ-ийн гишүүнчлэл

НЗТ-ийн гишүүн нь шалгуурыг хангаж, нээлттэй засгийн шинэчлэлийг хамтран бүтээж хэрэгжүүлэх замаар ил тод байдал, иргэдийн оролцоо, нийтийн эгэх хариуцлагыг ахиулах албан ёсны үүрэг амлалт өгсөн Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа юм. НЗТ-ийн гишүүд тодорхой гишүүнчлэлийн үүрэг хариуцлагыг биелүүлэх (**“Гишүүнчлэлийн гол үүрэг”** хэсгээс үзнэ үү) ба НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээнд идэвхтэй оролцох ёстой. Гишүүнчлэл нь төрийн байгууллагууд (ихэвчлэн гүйцэтгэх засаглалаар төлөөлүүлдэг боловч бүх шатны болон салбарын оролцоог дэмждэг) болон иргэний нийгмийн байгууллагуудыг хамарсан олон талт оролцогчдыг багтаадаг.

НЗТ-ийн гишүүнчлэл нь Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанд нээлттэй бөгөөд бусад төрийн салбарууд ч олон хэлбэрээр оролцох боломжтой. Парламент, хараат бус байгууллага болон шүүх эрх мэдлийн байгууллага нь үндэсний үйл явцад оролцох, бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах эсвэл **Нээлттэй засгийн сорилтод** нэгдэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг **“Засгийн газрын бусад түвшин болон салбарын оролцоо”** хэсгээс харна уу. Орон нутгийн засаг захиргаа нь Орон нутгийн НЗТ-д гишүүнээр элсэх, үндэсний төлөвлөгөөнд хамтран ажиллах эсвэл Нээлттэй засгийн сорилтоор дамжуулан үүрэг амлалт өгөх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг **“Нээлттэй засгийн сорилтоор үүрэг амлалтыг өргөжүүлэх нь”** хэсгээс үзнэ үү.

2.1.1 НЗТ-д элсэх

Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа хоёулаа НЗТ-д гишүүнээр элсэх боломжтой.

Засгийн газар НЗТ-д гишүүнээр элсэхийн тулд дараах шаардлагыг хангах ёстой:

- **Үндсэн шалгуурт нийцэж, НЗТ-ийн шалгалтыг амжилттай давсан байх:** Үндсэн шалгуур нь гуравдагч этгээдийн мэдээлэл дээр тулгуурлан нээлттэй засгийн дөрвөн гол чиглэлээр (төсвийн ил тод байдал, мэдээллийн хүртээмж, төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлэг, иргэдийн оролцоо) тухайн улсын гүйцэтгэлийг хэмждэг. НЗТ-ийн шалгалт нь V-DEM (Ардчиллын олон төрөл байдлын мэдээллийн сан)-ийн хоёр үзүүлэлт дээр суурилдаг: ИНБ-ын бүртгэл болон үйл ажиллагааг хянах төрийн хяналт мөн ИНБ-д үзүүлэх шахалт дарамт. Энэ шалгалтын зорилго нь шинээр элсэх гишүүн орнууд **Нээлттэй Засгийн Тунхаглалд** тусгасан ардчилсан засаглалын хэм хэмжээ, үнэт зүйлсийг баримтлах эсэхийг баталгаажуулах юм, ялангуяа иргэний нийгмийн орон зайг хамгаалах чиглэлд. Дэлгэрэнгүй мэдээллийг **“Үндсэн шалгуур ба НЗТ-ийн шалгалт”** хэсгээс харна уу.
- **Хариуцах яам эсвэл төрийн байгууллагыг томилох:** Уг яам эсвэл агентлаг нь НЗТ-тэй холбоотой бүх үйл ажиллагаа, зохицуулалтыг хариуцах бөгөөд түншлэлийн албан ёсны холбох цэг болж ажиллана. Үүнээс гадна хоёр түвшний холбогдох албан тушаалтныг томилно. Өндөр түвшний төлөөлөгч нь ихэвчлэн сайдын түвшний албан тушаалтан байдаг ба НЗТ-д төрийг албан ёсоор төлөөлнө. Харин өдөр тутмын хэрэгжилт, зохицуулалтыг хариуцах Ажлын алба нь төрийн захиргааны ахлах албан тушаалтан байх бөгөөд төрийн бүх салбарыг уялдуулан ажиллах чадамжтай байна.
- **Хүсэлтийг захидлаар хүргүүлэх:** Хэрэв тухайн улс Үндсэн шалгуур болон НЗТ-ийн шалгалтыг хангаж, гол яам эсвэл байгууллагыг тодорхойлсон бол НЗТ-д нэгдэх хүсэлтийг албан ёсоор илэрхийлж, захидал илгээх шаардлагатай. Энэхүү захидалд гишүүнээр элсэх шаардлагыг хангасан болохыг баталгаажуулах, Нээлттэй Засгийн Тунхаглалыг албан ёсоор дэмжиж буйгаа илэрхийлэх, өмнө нь хэрэгжүүлсэн нээлттэй засгийн шинэчлэлийн талаар товч танилцуулах, НЗТ-ийн хүрээнд хариуцах яам/байгууллага болон өндөр түвшний төлөөлөгчийн нэрийг заасан байх ёстой. Тус захидал нь сайдын түвшний албан тушаалтан буюу түүнээс дээш түвшний төлөөлөгчөөс **НЗТ-ийн даргалагч** нарт хаяглан info@opengovpartnership.org цахим хаягаар илгээнэ.

- **Иргэний нийгмийн оролцоог хангах:** НЗТ-ийн загвар нь иргэний нийгмийн байгууллагыг төрийн байгууллагууд шиг албан ёсны журмаар элсэхийг шаарддаггүй ч эдгээр байгууллага болон хувь хүмүүс НЗТ-ийн амжилттай үйл явцын салшгүй хэсэг юм. Тиймээс НЗТ-д албан ёсоор нэгдэхээс өмнө Засгийн газар нь өөрийн улсын иргэний нийгмийн байгууллагуудыг НЗТ-ийн үйл явцад идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлж өгөх ёстой.

Засгийн газар НЗТ-д хэрхэн гишүүнээр элсэх болон иргэний нийгмийн байгууллагууд хэрхэн оролцож болох талаар дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-д элсэх тухай**” хуудаснаас авна уу.

Орон нутгийн засаг захиргааны хувьд гишүүнээр элсэхийн тулд “**Орон нутгийн НЗТ**”-д нэгдэх ёстой. Энэ нь сонирхлоо илэрхийлж хариу хүлээн авснаар боломжтой болно. Элсэлтийн уриалгыг НЗТ-ийн Дэмжих нэгж тодорхой хугацаанд зарладаг. Бүх тохиолдолд орон нутгийн засаг захиргаа нь Орон нутгийн тусгай шалгуурыг хангаж, **Орон нутгийн гарын авлага**д заасны дагуу Дэмжлэг хүсэх захидал хүргүүлэх шаардлагатай.

НЗТ-ийн гишүүн улсын аль ч орон нутгийн засаг захиргаа элсэх өргөдөл гаргах боломжтой. Мөн НЗТ-д хараахан оролцоогүй ч элсэх боломжтой орнуудын орон нутгийн засаг захиргаа ч өргөдөл гаргаж болно (Элсэх боломжтой орнуудын жагсаалтыг **эндээс** харна уу).

Орон нутгийн засаг захиргаа НЗТ-д хэрхэн элсэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг “**Орон нутгийн НЗТ**” хуудаснаас үзнэ үү.

2.1.2 Үндэсний гишүүдийн үндсэн үүрэг хариуцлага

НЗТ-ийн гишүүн орнууд гишүүнчлэлийн статусаа хадгалах үүднээс дараах гол үүрэг хариуцлагыг биелүүлэх шаардлагатай. Үүнд:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөг НЗТ-ийн шаардлагын дагуу цаг хугацаанд нь боловсруулж хүргүүлэх (Дэлгэрэнгүй мэдээллийг “**Үйл ажиллагааны төлөвлөгөө, үүрэг амлалтыг боловсруулах**” хэсгээс үзнэ үү).
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран бүтээх үйл явц нь НЗТ-ийн “Оролцоо ба Хамтран бүтээх стандарт”-д заасан зайлшгүй шаардлагыг хангах (Дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-ийн Оролцоо ба Хамтран бүтээх стандарт**” хэсгээс үзнэ үү).
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үүрэг амлалтыг хэрэгжүүлж буй явц, үр дүнг НЗТ-ийн Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-аар үнэлүүлж, ахиц дэвшлийг нотлох (Дэлгэрэнгүй мэдээллийг “**Эгэх хариуцлага ба суралцах явц: Хараат бус тайлагнах механизм**” хэсгээс үзнэ үү).
- **НЗТ**-ийн үндсэн зарчим, үнэт зүйлсийг чанд баримталж, тэдгээрийг зөрчих аливаа үйлдлээс татгалзах.

Гол үүрэг хариуцлагаас гадна НЗТ-ийн гишүүн орнууд дараах зүйлийг хэрэгжүүлдэг.

- Тогтсон хэмжээний дагуу НЗТ-д жил бүр гишүүнчлэлийн төлбөр өгөх (Дэлгэрэнгүй мэдээллийг “**Гишүүнчлэлийн төлбөр**” хэсгээс үзнэ үү).
- НЗТ-ийн засаглалын үйл явцад оролцох, шаардлагатай тохиолдолд Удирдах хорооны сонгуульд оролцох.
- Одоо хэрэгжүүлж буй төрийн үйл ажиллагаанаас давсан, хүсэл зорилготой, шинэлэг үүрэг амлалт гаргах.
- Нээлттэй засгийн чиглэлээр бусад орнуудад дэмжлэг үзүүлэх — үүнд шилдэг туршлага, мэргэжлийн зөвлөгөө, техникийн туслалцаа, технологи болон нөөц хуваалцах зэрэг хамаарна.

- НЗТ-ийн арга хэмжээнд идэвхтэй оролцох — үүнд **НЗТ-ийн Дэлхийн дээд хэмжээний уулзалт**, Бүс нутгийн уулзалт, **Нээлттэй засгийн долоо хоног**, сэдэвчилсэн арга хэмжээ болон туршлага солилцох бүх хэлбэрүүд орно.
- Үйл ажиллагааны хүрээг ашиглан нээлттэй засгийн зорилтуудыг ахиулах чиглэлээр идэвхтэй оролцох — үүнд Нээлттэй засгийн сорилт зэрэг санаачлагууд болон төрийн бусад салбарыг дэмжих, урагшлуулах үйл ажиллагаа багтана (Дэлгэрэнгүй мэдээллийг **“Засгийн газрын бусад түвшин болон салбар”** хэсгээс үзнэ үү).

МНЗТ-ийн мандат болон бодлогын талаар дэлгэрэнгүй мэдээллийг **“Засаглал”** хэсгээс үзнэ үү.

2.1.3 Улс орны гишүүнчлэлийн төлбөр

НЗТ-ийн алсын харааг дэмжиж, энэхүү түншлэл тогтвортой хөгжих боломжоор хангахын тулд бүх гишүүн орнуудаас санхүүгийн хандив буюу гишүүнчлэлийн төлбөр өгөхийг уриалдаг. НЗТ-ийн гишүүнчлэлийн төлбөр нь илүү нээлттэй, ардчилсан засгийг бий болгох, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдлийг иргэний нийгэмтэй хамтран боловсруулах зорилгод үнэнч байх үүрэг амлалтын илэрхийлэл юм. Жил бүрийн улс орны гишүүнчлэлийн төлбөр нь НЗТ-ийн Дэмжих нэгжид хүсэл зорилготой, сэдэвчилсэн чиглэл, орон зайг бүрдүүлэх, төрийн өндөр түвшний оролцоог хангах, хамтран бүтээх үйл явцыг дэмжих, Хараат бус тайлагнах механизмаар (ХБТМ) үнэлгээ хийх, шинэчлэлийн техник туслалцаа үзүүлэх болон бусад дэмжлэг үзүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг.

2023 онд НЗТ-ийн Удирдах хороо улс орны гишүүнчлэлийн төлбөрийн түвшинг дахин үнэлж, 2015 оноос хойш анх удаа бүтэц, тогтолцоог шинэчлэх **шийдвэр гаргасан**. Гишүүнчлэлийн төлбөрийн түвшин нь Дэлхийн банкны улс орнуудын орлогын ангилалд үндэслэж, ДНБ-ний хэмжээг харгалзан, хоёр үе шаттайгаар өссөн.

НЗТ-ийн Дэмжих нэгж жил бүр тухайн улсын төсвийн мөчлөг эхлэхээс өмнө албан захидал болон нэхэмжлэхийг илгээж, тухайн жилийн гишүүнчлэлийн төлбөрийн хэмжээг урьдчилан мэдэгддэг. Иймд гишүүн орнууд жил бүрийн төсөвтөө тусгахыг бид зөвлөдөг.

Улс орны гишүүнчлэлийн төлбөрийн хэмжээ болон өмнөх жилүүдийн мэдээллийг НЗТ-ийн албан ёсны цахим хуудсын **“Улс орны гишүүнчлэлийн төлбөр”** хэсгээс үзнэ үү.

2.1.4 НЗТ-ийн хариуцлагын механизм

Улс орны НЗТ-ийн журмыг сахин биелүүлж буй байдалд үнэлгээ хийх дөрвөн төрлийн хяналтын механизм байдаг. Эдгээрийг НЗТ-ийн гүйцэтгэх шийдвэр гаргах байгууллага болох **НЗТ-ийн Удирдах хороо** хянаж ажиллуулдаг.

- **НЗТ-ийн процедурын хяналт**: Энэ механизм нь үндэсний түвшинд оролцож буй бүх гишүүн орнууд НЗТ-ийн үйл явцын дагуу ажиллах буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг цаг хугацаанд нь хүргүүлэх, **хамтран бүтээх зайлшгүй стандартыг хангах**, үүрэг амлалтын хэрэгжилтэд ахиц дэвшил гаргах эсэхийг баталгаажуулах зорилготой. Хэрэв улс орон дараалан хэд хэдэн мөчлөгт дээрх үйл явцыг зөрчвөл тус улсын оролцоог НЗТ-ийн Удирдах хороо хянаж, үнэлгээ хийнэ.
- **НЗТ-ийн шаардлагыг хангах эсэхийг хянан шалгах**: Хэрэв гишүүн улс орон дараалан хоёр жил үндсэн шалгуураас доогуур үнэлгээ авбал “Шаардлагыг хангах эсэхийг хянан шалгах” горимд автоматаар шилждэг. Энэ үйл явцад тухайн улс оронд шаардлагыг биелүүлэхэд нь туслах зорилго бүхий нэмэлт дэмжлэг үзүүлдэг. Шаардлагыг хангаж эхэлмэгц тухайн улсыг хяналт шалгалтын жагсаалтаас хасдаг. Энэхүү хяналт шалгалт нь дангаараа тухайн улсыг “идэвхгүй” гишүүн гэж ангилах үндэслэл болохгүй ч, хэрэв тухайн улс үйл ажиллагааны төлөвлөгөөг хугацаанд нь хүргүүлэхгүй байх, хамтран бүтээх стандартыг биелүүлэхгүй байх, үүрэг амлалтын хэрэгжилт хангалтгүй байх зэрэг

Гишүүнчлэл

бусад шалгуурыг хангахгүй бол Удирдах хороо тухайн улсыг идэвхгүй гишүүнээр тооцох асуудлыг авч үзнэ.

- **НЗТ-ийн хариу үйлдлийн бодлого:** Энэхүү механизм нь онцгой нөхцөлд хэрэгждэг буюу тухайн гишүүн улс Нээлттэй Засгийн Тунхаглалд туссан үнэт зүйлс, зарчмуудыг бүдүүлгээр зөрчсөн, илтэд үл хүндэтгэсэн, түүгээр ч барахгүй НЗТ-ийн нэр хүндэд ноцтой хохирол учруулах үйлдэл гаргасан тохиолдолд хэрэгжинэ.
- **НЗТ-ийн Шуурхай хариу арга хэмжээ авах протокол:** Энэхүү механизм нь НЗТийн гишүүн орон НЗТ-ийн зарчим, үнэт зүйлсийг ноцтойгоор зөрчсөн нөхцөл байдал үүссэн тохиолдолд яаралтай, шуурхай хариу арга хэмжээ авах боломжийг олгодог. Энэ нь тухайн асуудлыг богино хугацаанд бусад хяналтшинжилгээний болон хариуцлагын механизмаар шийдвэрлэх боломжгүй буюу шийдвэрлэхээр харагдахгүй байгаа үед хэрэгжинэ.

2.2 Гол оролцогч талууд

НЗТ-ийн бүх гишүүн орнууд нь өргөн хүрээтэй, олон талт оролцогчдоос бүрдсэн экосистемийн нэг хэсэг юм. Нэг талаас, эдгээрт тухайн улсын түвшинд НЗТ-ийн үйл ажиллагаанд оролцдог талууд — Засгийн газрын төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад оролцогчид багтана. Мөн дэлхийн түвшинд нээлттэй засгийг дэмждэг олон улсын байгууллагууд багтдаг бөгөөд тэдгээр нь гишүүн орнуудад дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжтой юм. Нөгөө талаас, НЗТ-ийн хүний нөөц болон засаглалын бүтэц дэх оролцогч талууд багтдаг бөгөөд тэд түншлэл дэх оролцоог дэмжихэд гол үүрэгтэй.

Үндэсний түвшин дэх гол оролцогч талууд дараах байдлаар тодорхойлогдоно.

- **Засгийн газрыг төлөөлөх оролцогч талууд:** Гишүүн бүр Засгийн газрын гол яам эсвэл төрийн байгууллага, түүнчлэн өндөр түвшний болон ажлын түвшний холбогдох албан тушаалтанг тус тус томилдог.
 - **Гол яам эсвэл төрийн байгууллага** нь тухайн улсын НЗТ-ийн үйл явц, үйл ажиллагааг зохицуулах гол хариуцагч байх бөгөөд НЗТ-тэй харилцах албан ёсны холбох цэгийн үүргийг гүйцэтгэнэ. Энэхүү байгууллага нь засаглалын сайжруулалт, төрийн удирдлагын шинэчлэлтэй холбоотой асуудлыг хариуцах нь тохиромжтой бөгөөд төрийн яам, агентлаг хоорондын зохицуулалтыг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Засгийн газар нь хоёр түвшний холбогдох албан тушаалтныг томилно.
 - **Өндөр түвшний холбогдох албан тушаалтан** нь ихэвчлэн сайдын түвшний албан тушаалтан байх ба тухайн улс орныг НЗТ-д албан ёсоор, хуулийн хүрээнд төлөөлөх үүрэгтэй.
 - **Ажлын түвшний холбогдох албан тушаалтан** нь төрийн захиргааны ахлах албан тушаалтан бөгөөд төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог тогтоож ажиллах, НЗТ-ийн Дэмжих нэгжтэй өдөр тутмын харилцааг хариуцах үүрэгтэй. Мөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, Үндэсний зөвлөл (эсвэл түүнтэй адил бүтэц)-г удирдах, төрийн байгууллагыг уялдуулах, НЗТ-ийн Дэмжих нэгжтэй харилцах зэрэг үүрэгтэй. Түүнчлэн, тус албан тушаалтан Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-тай хамтран хяналт, үнэлгээний үйл явцад оролцох, НЗТ-ийн арга хэмжээнд оролцох, туршлага солилцооны үйл ажиллагаанд нэгдэн оролцох, зарим тохиолдолд манлайлах үүргийг гүйцэтгэдэг. Холбогдох албан тушаалтны гол үүргийн талаар илүү дэлгэрэнгүй зөвлөмжийг [эндээс](#) үзнэ үү.
- **Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) болон төрийн бус байгууллагын бусад оролцогч талууд (жишээлбэл: академик хүрээлэл, хувийн хэвшил гэх мэт)** нь НЗТ-ийн үйл явц дахь чухал түншүүд бөгөөд хамтран бүтээх, оролцох үйл явцад техникийн мэдлэг, хүний нөөц, хамтран ажиллах чадавх зэргээр хувь нэмэр оруулдаг. Эдгээр

Гишүүнчлэл

оролцогч талууд нь НЗТ-ийн үйл явцыг олон нийтэд таниулах, тодорхой үүрэг амлалт өгөхийг уриалах, шаардлага тавих, хэрэгжилтийг хянах, дэмжих, үндэсний болон орон нутгийн түвшний оролцогч талууд, түүний дотор салбар хоорондын хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

- **Орон нутгийн засаг захиргаа** нь НЗТ-ийн үйл явцад хамтран бүтээх үйл явцад оролцох, үндэсний бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, нээлттэй засгийн зарчмыг олон нийтэд сурталчлах, шинэлэг орон нутгийн санаачлагыг танилцуулах хэлбэрээр оролцож, хувь нэмрээ оруулдаг. Орон нутгийн засаг захиргаа нь НЗТ-ийн үйл явцад хэрхэн үр дүнтэй оролцох талаарх тусгай зааварчилгаа “**Орон нутгийн засаг захиргаа**” хэсэгт байна.
- **Парламент** нь НЗТ-ийн хэлэлцүүлэг, үйл явцад идэвхтэй оролцохыг уриалж, бие даасан төлөвлөгөө боловсруулах эсвэл Нээлттэй засгийн сорилтоор дамжуулан үүрэг амлалт өгөх боломжтой. Парламент Нээлттэй засагтай холбоотой хууль тогтоомж санаачлах, хэлэлцэх, батлах, шинэчлэлд шаардах төсвийг батлах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, Парламентын ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих боломжийг бий болгох, иргэдийн өмнө эгэх хариуцлагатай байх, иргэдийн ашиг сонирхлыг илүү сайн төлөөлөх чиглэлээр санал авах механизм ажиллуулах зэргээр дамжуулан нээлттэй засгийн үнэт зүйлсийг дэмжиж ажиллана. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Парламент**” хэсгээс үзнэ үү.
- **Шүүх эрх мэдлийн байгууллага** нь НЗТ-ийн хэлэлцүүлэг, үйл явцад идэвхтэй оролцохыг уриалж, бие даасан төлөвлөгөө боловсруулах эсвэл Нээлттэй засгийн сорилтоор дамжуулан үүрэг амлалт өгөх боломжтой. Мөн гаргасан үүрэг амлалттай холбоотой эрх зүйн асуудлууд дээр зөвлөмж өгөх, шүүхийн ил тод байдал, шударга ёсны хүртээмж, шүүх байгууллагын шударга байдлыг бэхжүүлэх арга хэмжээнд оролцох, гомдол, буцаан олголтын механизм зэргээр дамжуулан нээлттэй засгийн үнэт зүйлсийг дэмжиж ажиллана. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Шүүх эрх мэдлийн байгууллага**” хэсгээс үзнэ үү.
- **Бие даасан байгууллага** (жишээлбэл: Үндэсний аудитын газар, Омбудсманы байгууллага зэрэг) нь НЗТ-ийн хэлэлцүүлэг, үйл явцад идэвхтэй оролцохыг уриалж, бие даасан төлөвлөгөө боловсруулах эсвэл Нээлттэй засгийн сорилтоор дамжуулан үүрэг амлалт өгөх боломжтой. Мөн хараат бус хяналт тавих, ил тод байдал, хариуцлагыг мандатын хүрээнд дэмжих, өөрийн чиг үүрэгтэй уялдсан үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр дамжуулан нээлттэй засгийн үнэт зүйлсийг дэмжиж ажиллана. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Хараат бус үндэсний байгууллага**” хэсгээс үзнэ үү.
- **Бусад оролцогч тал** (жишээлбэл: олон улсын байгууллага, хөгжлийн донор байгууллага) нь нээлттэй засгийг дэмжих зорилгоор техникийн туслалцаа, мэргэжлийн туршлага, санхүүгийн эх үүсвэр олгодог.

НЗТ-ийн үйл явц болон оролцогч талуудыг дэмждэг олон төрлийн оролцогчид бий. Байгууллага доторх оролцогч талуудыг дараах байдлаар тодорхойлно.

- **Удирдах хороо** нь НЗТ-ийн гүйцэтгэх шийдвэр гаргах байгууллага юм. Энэхүү хороо нь НЗТ-ийн үнэт зүйлс, зарчим, эрх ашгийг хөгжүүлэх, сурталчлах, хамгаалах гол бодлого, зарчим, дүрмийг тогтоодог бөгөөд түншлэлийн үйл ажиллагааг хянаж, удирдан зохион байгуулдаг. Удирдах хороо нь нийт 22 сонгогдсон гишүүнтэй бөгөөд үүнээс 11 нь Засгийн газар, 11 нь иргэний нийгмийн төлөөллөөс бүрдэх ба хоёр талын тэнцвэртэй төлөөллийг хадгалдаг онцлогтой. Удирдах хорооны үйл ажиллагааг дэмжих гурван байнгын дэд хороо ажилладаг: Засаглал ба манлайллын дэд хороо, Шалгуур ба стандартын дэд хороо, Сэдэвчилсэн манлайллын дэд хороо юм. Дэлгэрэнгүй мэдээллийг **энд** дарж уншина уу.
- **Дэмжих нэгж** нь НЗТ-д байнга ажилладаг мэргэжилтний баг бөгөөд Удирдах хороо болон Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-тай нягт хамтран ажилладаг. Энэ нэгж

Гишүүнчлэл

нь НЗТ-ийн үйл явцын ойлголт, хэрэгжилтийг дэмжих чиглэлээр төр болон иргэний нийгмийн оролцогч талуудад тогтмол заавар зөвлөгөө өгдөг. Мөн түншлэлийн хүрээнд туршлага, мэдлэгийн солилцоог идэвхжүүлдэг байна. Үүнээс гадна Дэмжих нэгж нь харилцаа холбоо, судалгаа, сургалт, чадавхжуулах үндсэн чиг үүргийг хариуцдаг.

- **Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)** нь НЗТ-ийн хариуцлагын үндсэн хэрэгсэл бөгөөд гишүүн орнуудын ахиц дэвшлийг хянах гол арга зам юм. ХБТМ нь хараат бус, нотолгоонд тулгуурласан, бодитой тайлан гаргаж, НЗТ-ийн гишүүдийг хариуцлага хүлээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөний мөчлөгийн чухал үе шатуудад зөвлөмж хүргүүлж, нээлттэй засгийн хүчин чармайлтыг нь дэмждэг байна. ХБТМ нь НЗТ-ийн гишүүдэд зориулсан үнэтэй нөөц боломж бөгөөд түншлэлийн нэр хүндийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж, нээлттэй засгийн олон нийт дунд сургалт зохион байгуулах, туршлага солилцох боломжийг бүрдүүлдэг. ХБТМ-ын хараат бус байдлыг хамгаалж, хэрэгжүүлэх аргачлалыг тууштай хянах зорилгоор Олон улсын шинжээчдийн зөвлөл (ОУШЗ) мөн ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.
- **НЗТ-ийн Захирлуудын зөвлөл** нь Дэмжих нэгж болон ХБТМ-ын санхүү, хууль эрх зүйн хяналтыг хэрэгжүүлдэг. Үүнд хоёр байгууллагын үйл ажиллагаанд зориулсан төсвийн баталгаа мөн багтана. Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.
- **НЗТ-ийн Магнайлагчдын сүлжээ** нь элч, тусгай төлөөлөгчдөөс бүрддэг. Энэ сүлжээнд НЗТ-ийн Удирдах хорооны хуучин гишүүд, ахмад маглайлагчид багтдаг ба НЗТ-ийн олон улсын нэр хүндийг өргөх, түншлэлийн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх тавцан болгон сурталчлах, нээлттэй засгийн сэдвийн хүрээнд туршлага, мэдлэг хуваалцах зорилгоор ажилладаг. Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.

2.3 НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ

НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь тодорхой бүтэцтэй боловч уян хатан байдлыг хадгалсан байдаг. Энэ нь гишүүн орнууд болон гол оролцогч талууд нээлттэй засгийн зорилгоо хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг юм. Үйл ажиллагааны хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, бие даасан үүрэг амлалт өгөх, төрийн бүх шат, салбарыг албан ёсоор оролцуулах замаар гишүүн орны хувьд оролцоог хангадаг. Эдгээр оролцооны хэлбэр бүр өөрийн гэсэн хэрэгжилтийн бүтэц болон үнэлгээний механизмтай боловч бүгд яриа хэлэлцээ, үйл ажиллагаа, эгэх хариуцлага, суралцах гэсэн үндсэн зарчмууд дээр тулгуурладаг.

Гишүүн орны хувьд оролцооны хамгийн гол хэлбэр бол үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах юм. Энэ нь тухайн улсын НЗТ-д оролцох төв цөм бөгөөд бүх гишүүд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэгтэй. Эдгээр төлөвлөгөөг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулдаг ба нээлттэй засгийн шинэчлэлийг урагшлуулахын тулд тухайн улсын үндэсний тэргүүлэх чиглэлд анхаарал хандуулахаас гадна ил тод байдал, олон нийтийн эгэх хариуцлага, иргэдийн оролцоог дэмжих НЗТ-ийн зарчимтай уялдуулсан байдаг. Төлөвлөгөөг ихэвчлэн гүйцэтгэх засаглал манлайлдаг боловч НЗТ-ийн хүрээ болох төрийн бүх шат, салбарын оролцоог хангах, [Нээлттэй засгийн сорилтоор](#) дамжуулан тодорхой бодлогын чиглэлийг шийдвэрлэх, нээлттэй засгийн стратегийг боловсруулах зэрэг хамардаг. “[Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг амлалт боловсруулах](#)” хэсгээс дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь бүх нөхцөл байдалд бүрэн уялдсан, цогц хандлагыг хангахгүй байж болохыг хүлээн зөвшөөрч, НЗТ нь оролцооны бусад боломжит хэлбэрийг мөн санал болгодог. Үүнд:

- **НЗТ-Орон нутгийн гишүүнчлэл.** Орон нутгийн засаг захиргаанд НЗТ-д нэгдэх боломж олгодог өрсөлдөөнт үйл явц өрнөх бөгөөд орон нутгийн түвшинд нээлттэй засгийн шинэчлэл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг юм. Дэлгэрэнгүй мэдээллийг “[НЗТ-ийн](#)

Гишүүнчлэл

орон нутгийн гишүүнчлэл” хэсгээс үзнэ үү.

- **Төрийн бусад салбарын бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө:** Парламент, шүүх засаглал, хараат бус байгууллага зэрэг тусгай институцад зориулсан эдгээр төлөвлөгөө нь тухайн байгууллагын хүрээнд нээлттэй засгийн санаачлагыг хэрэгжүүлэхэд зориулсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Засаглалын бусад түвшин ба салбарын оролцоо**” хэсгээс үзнэ үү.
- **Нээлттэй засгийн сорилт:** Нээлттэй засгийн шинэ сорилтуудыг шийдвэрлэх хүсэл зорилготой, шинэлэг үүрэг амлалтыг дэмжих зорилготой санаачилга юм. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Нээлттэй засгийн сорилт**” хэсгээс үзнэ үү.
- **Орон нутгийн нээлттэй засгийг өргөжүүлэх үйл ажиллагаа:** Орон нутгийн түвшинд нээлттэй засгийн зарчмуудыг өргөн хүрээнд хэрэгжүүлэх зорилготой, тухайн улс орноос санаачилсан үйл ажиллагааг дэмжих хүрээ юм. Энэхүү хүрээ нь орон нутгийн засаг захиргаа нээлттэй засгийн зарчмуудыг системтэйгээр нэвтрүүлэх, үр дүнтэй, шинэлэг санаачлагыг ил тод харуулах, үндэсний болон орон нутгийн НЗТ-ийн үйл явцад хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх үүргэгтэй юм. Холбогдох заавар удахгүй нийтлэгдэнэ.
- **Нээлттэй засгийн стратеги:** Нээлттэй засгийн хүчин чармайлтыг тогтвортой болгон өргөжүүлж гүнзгийрүүлэх хүсэлтэй улс орнуудад зориулсан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө баяжуулах стратегийн баримт бичиг юм. НЗТ нь нээлттэй засгийг өргөн хүрээнд ахиулах, хамтран бүтээх, эгэх хариуцлага хүлээх зарчмуудыг гүнзгий нэвтрүүлэх, эдгээр хүчин чармайлтыг баримтжуулан урамшуулах, бусадтай хуваалцах зорилготой юм. Холбогдох заавар удахгүй нийтлэгдэнэ.

НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь түншлэлийн хөгжлийг даган өргөжихийн хэрээр НЗТ нь гишүүдийг илүү үр дүнтэй дэмжих шинэ заавар, үйлчилгээ боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хийх болно.



3 НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт

Гол зөвлөмж

- Засгийн газар, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа нь НЗТ-ийн үйл явцын гол цөм бөгөөд үүнийг “хамтран бүтээх” гэж нэрлэдэг.
- Хүчтэй бөгөөд хүртээмжтэй хамтран бүтээх үйл явц нь сайн боловсруулсан, хүсэл зорилготой үүрэг амлалтуудтай байх хандлагатай байдаг. Шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад хамтын ажиллагаа тасралтгүй үргэлжилснээр тодорхой, үр дүнтэй амжилтад хүрдэг.
- **НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт** нь НЗТ-ийн бүхий л үе шатанд хамтран бүтээх үйл явцыг чиглүүлдэг.
- Бүх НЗТ-ийн гишүүн эдгээр стандартын зайлшгүй шаардлагыг биелүүлэх ёстой. Гэхдээ НЗТ-ийн жинхэнэ зорилго нь зайлшгүй биелүүлэх шаардлагаас давсан үүрэг амлалт өгч, таван стандартын хэрэгжилтийг хангахад оршдог
- Стандарт бүрийн хэрэгжилт болон зайлшгүй биелүүлэх шаардлагыг Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) үнэлдэг.



Стандарт

Засгийн газар, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудын хамтын ажиллагаа нь НЗТ-ийн үйл явцын гол цөм бөгөөд үүнийг “хамтран бүтээх” гэж нэрлэдэг. НЗТ-ийн анхны арван жилийн өгөгдөлд тулгуурласан **судалгаанаас** үзэхэд, хүчтэй бөгөөд хүртээмжтэй хамтран бүтээх үйл явц нь сайн боловсруулсан, хүсэл зорилготой үүрэг амлалтуудтай байх хандлагатай болох нь харагдсан. Мөн энэхүү хамтын ажиллагаа шинэчлэлийн хэрэгжилтийн явцад тогтвортой үргэлжилсэн тохиолдолд илүү үр дүнтэй байгааг судалгаа харуулж байна. Иргэдийн оролцоо нь тухайн үйлчилгээний чанарт эерэг нөлөө үзүүлдэг, ялангуяа хүн бүрийн дуу хоолойг төрийн албан хаагчид сонсож, харгалзан үзэж хариу арга хэмжээ авдаг байна.

НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт нь НЗТ-ийн бүхий л үе шатанд хамтын ажиллагааг чиглүүлж уялдуулдаг. Энэхүү гарын авлагад эдгээр стандарттай холбоотой хэсгийг онцолж оруулсан бөгөөд олон талт оролцогчдоос бүрдсэн үндэсний зөвлөл байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үе шат зэрэг чухал мөчүүдэд стандарт хэрхэн хэрэгждэг талаар тодорхой заасан байдаг. Эдгээр стандарт нь хамтран бүтээх үйл явц, ил тод байдал, эгэх хариуцлагыг НЗТ-ийн бүх гишүүн орны хувьд тууштай, уялдсан байдлаар хэрэгжүүлэхэд чиглэсэн чухал хэрэгсэл юм.

Эдгээр стандарт нь гишүүн орныг зайлшгүй биелүүлэх шаардлагаас гадна түүнээс илүү хүсэл зорилготой, үр нөлөөтэй оролцоо руу тэмүүлэхийг уриалсан бүтэцтэй байдаг. Стандарт бүр нь дараах мэдээллийг агуулдаг.

- Хүсэл зорилго;
- Стандартын хамрах хүрээ;
- Стандартыг хэрэгжүүлэх арга зам;
- Оролцоо ба хамтран бүтээхэд зайлшгүй биелүүлэх шаардлага;
- Стандартын хэрэгжилтийн үнэлгээ.

НЗТ-ийн Процедурын хяналтын бодлого нь тухайн улс НЗТ-ийн үйл явцын дагуу ажиллахгүй байгаа тохиолдолд ямар нөхцөл үүсэж болох мөн тухайн нөхцөлд авч хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон байдаг. Хараат бус тайлагнах механизм (ХБТМ) нь тухайн улс НЗТ-ийн үйл явцын эсрэг үйлдэл хийж байгаа эсэхийг тогтооход ашигладаг гурван шалгуурын хоёр дээр нь үнэлгээ хийдэг (дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-ийн гишүүнчлэлийн хариуцлагын механизм**” хэсгээс үзнэ үү). Нэгдүгээрт, тухайн улс нь НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандартад заасан зайлшгүй биелүүлэх шаардлагыг бүрэн хангах ёстой. Хоёрдугаарт, хэрэв тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан үүрэг амлалтад ахиц дэвшил гараагүй бол тухайн улсыг НЗТийн үйл явцын эсрэг үйлдэл хийж байна гэж үзнэ. Эдгээр шалгуурын дагуу ХБТМ тухайн улс НЗТ-ийн үйл явцын дагуу ажиллахгүй байна гэж дүгнэсэн тохиолдолд НЗТийн Дэмжих нэгжид албан ёсоор мэдэгдэнэ.

Засгийн газар, иргэний нийгэм болон бусад төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны орон зайг бүрдүүлэх.

Стандарт 1

Засгийн газар, иргэний нийгэм болон бусад төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны орон зайг бүрдүүлэх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 1.1

Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөл болон шаардлагатай тохиолдолд бусад төрийн бус оролцогч талуудыг оролцуулж, тогтмол (зургаан сард дор хаяж нэг удаа) хуралддаг байнгын хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлсэн байна. Уг оролцооны үндсэн дүрэм, журам нь олон нийтэд нээлттэй байна.

Стандарт 2

НЗТ-ний гишүүний хувьд үйл ажиллагаа, хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг ил тод, хүртээмжтэй, цаг тухайд нь олон нийтэд түгээх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 2.1

НЗТ-ний гишүүний хувьд холбоотой мэдээлэлд зориулсан нийтийн хүртээлтэй цахим хуудсыг ажиллуулах.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 2.2

НЗТ-ийн үйл явцтай холбоотой баримт бичгийг (хамтран бүтээх үйл явц болон үүрэг амлалтын хэрэгжилтийг нотлох мэдээлэл, баримтыг багтаасан) нийтэд нээлттэйгээр “цахим баримтын сан” үүсгэж НЗТ-ийн цахим хуудсан дээр байршуулсан байна. Уг санг тогтмол шинэчлэх бөгөөд жилд дор хаяж хоёр удаа шинэчилсэн байна.

Стандарт 3

Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад олон нийтэд хүртээмжтэй, мэдээлэлд суурилсан оролцох боломжийг бүрдүүлэх

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 3.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаас дор хаяж хоёр долоо хоногийн өмнө хамтран бүтээх явцын ажлын хуваарь, оролцогч талуудад зориулсан оролцооны тоймыг НЗТ-ийн цахим хуудсан дээр нийтэлсэн байна.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 3.2

ҮЗ байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар оролцогч талууд руу чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, НЗТ-ийн талаар болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад хэрхэн оролцох талаар мэдээлэл хүргэнэ.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 3.3

ҮЗ байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар сонгосон оролцооны механизмд тохирсон хугацааны хүрээнд өргөн хүрээний оролцогч талаас санал авах механизмыг боловсруулсан байна.

Стандарт 4

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах явцад Засгийн газар болон төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцээг хангаж, гаргасан санал, оролцоонд үндэслэсэн үндэслэл бүхий хариу өгч байх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 4.1

ҮЗ байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад оролцогч талуудын гаргасан санал, оролцоог харгалзан үзсэн талаарх хариуг бичгээр боловсруулан баримтжуулах, нийтэд мэдээлэх эсвэл оролцогч талуудад тайлагнах ёстой.

Стандарт 5

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон хяналт-шинжилгээ хийх явцад олон нийтэд хүртээмжтэй, мэдээлэлд суурилсан байнгын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлэх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 5.1

ҮЗ байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар жил бүр иргэний нийгмийн байгууллагуудтай дор хаяж хоёр удаа уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар үр дүн танилцуулан санал, хүсэлт хүлээн авна.

Стандартын бүрэн хувилбар, түүний хамрах хүрээ, ач холбогдол, хүсэл зорилготой хэрэгжилтийн жишээ болон хэрэгжүүлэх арга замын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт**” хэсгээс үзнэ үү.

Мэдэхэд илүүдэхгүй

Хүсэл зорилготой байх нь нээлттэй засгийн шинэчлэлийн түлхүүр юм.



НЗТ-ийн жинхэнэ хүсэл зорилго нь зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангахаас илүү таван стандартыг бүрэн хэрэгжүүлэхэд оршдог. Зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангаснаар НЗТ-ийн гишүүн орон үр нөлөөтэй, өөрчлөлт авчрах нээлттэй засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх боломжтой болно. Дараах хэсгүүд нь НЗТ-ийн үйл явцын тодорхой үе шат руу гүнзгий орж, тухайн шат бүрд хамаарах дүрэм, шаардлагыг тайлбарлах, хэрхэн илүү үр дүнтэй, бүрэн хэмжээний хэрэгжилтэд хүрэх талаар зөвлөмж өгнө.



4 Үндэсний түвшинд хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэх нь

Гол зөвлөмж

- Стандарт 1-н дагуу, НЗТ-ийн бүх гишүүн орон Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөлөл хооронд байнгын яриа хэлэлцээ явуулах албан ёсны орон зайг бүрдүүлэх шаардлагатай.
- НЗТ-ийн бүх гишүүд ийм хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэх ба зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангах ёстой.
- Энэ стандартыг хэрэгжүүлэхэд олон арга зам байдаг бөгөөд гишүүн орнуудад уян хатан байдлыг олгодог. Хамгийн амжилттай жишээ нь Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулах юм.
- ҮЗ нь НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээнд Засгийн газар болон иргэний нийгэм хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг
- Гишүүн орнууд ҮЗ-ийг хүсэл зорилготой бүрдүүлэх, Стандарт 1-н бүрэн хэрэгжилтийг хангах, мөн ҮЗ-ийн үр дүнтэй, тогтвортой ажиллагааг хангахын тулд бусад хүчин зүйл, бүрдэл хэсгийг анхаарч үзэхийг зөвлөж байна.

УННМН
СҮДАЛГААНЫ САН



ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Стандарт 1-н дагуу НЗТ-ийн бүх гишүүн орон Засгийн газар болон иргэний нийгмийн төлөөлөл хооронд байнгын яриа хэлэлцээний албан ёсны орон зайг бүрдүүлэх шаардлагатай. Яриа хэлэлцээ нь НЗТ-ийн загварын үндэс суурь бөгөөд энэ нь итгэлцлийг бий болгох, хамтран асуудал шийдвэрлэх арга замыг дэмжих, иргэний нийгэмд нээлттэй засгийн үүрэг амлалтын боловсруулалт, хэрэгжилт, хяналт шинжилгээнд нөлөөлөх боломж олгох үүрэгтэй юм.

Стандарт 1

Засгийн газар, иргэний нийгэм болон бусад төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны орон зайг бүрдүүлэх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 1.1

Засгийн газар, иргэний нийгмийн төлөөлөл болон шаардлагатай тохиолдолд бусад төрийн бус оролцогч талуудын оролцоотой, тогтмол (зургаан сард дор хаяж нэг удаа) хуралддаг байнгын хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлсэн байна. Тус оролцооны үндсэн дүрэм, журам нь олон нийтэд нээлттэй байна.

Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-ын үнэлгээ

ХБТМ нь тухайн улс дараах гурван гол шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ.

- Олон талт оролцогчдын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх орон зай байна уу?
- Яриа хэлэлцүүлгийн орон зай нь зургаан сард дор хаяж нэг удаа хуралдсан уу?
- Яриа хэлэлцүүлгийн орон зайн талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байна уу?

ХБТМ-ын удирдамжийг **эндээс** үзнэ үү.

Байнгын яриа хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэхэд зориулсан тогтсон загвар, нэг жишиг байхгүй тул улс орон өөрсдийн нөхцөл байдалд тохируулан уян хатан байдлаар хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү стандартыг хэрэгжүүлэх олон арга зам байдаг. НЗТ-ийн гишүүн орны олон жилийн туршлагаас харахад хамгийн үр дүнтэй арга нь олон талт оролцогчдын форум эсвэл платформ байгуулах буюу **Үндэсний зөвлөл (ҮЗ)** загварыг хэрэгжүүлэх явдал юм.

ҮЗ-ийг институтчилсан байгууллага болгон зохион байгуулах, шийдвэр гаргах эсвэл зөвлөлдөх үүрэг бүхий байгууллага хэлбэрээр ажиллах, ажлын хэсэг, дэд хороо болгон зохион байгуулах эсвэл тухайн орны онцлогт тохирсон бусад хэлбэрээр ч ажиллуулж болно. ҮЗ-ийг тухайн улс орны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын болон иргэний нийгмийн оролцогчдын онцлогт тулгуурлан төлөвлөдөг. Энэ нь ҮЗ-ийн бүтэц, нээлттэй засгийн хүрээнд хэрэгжүүлж буй арга барилыг шууд тодорхойлдог байна. Ялангуяа үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах явцад онцгой ач холбогдолтой бөгөөд үүний тухай **“Үүрэг амлалт”** хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

НЗТ нь улс орныг энэ орон зайд Засгийн газрын бүх түвшин, салбарын оролцогч талуудыг өргөн хүрээтэйгээр хамруулах талаар сэтгэхийг уриалдаг байна. Үүнд орон нутгийн засаг захиргаа, парламент, шүүх эрх мэдэл, хараат бус байгууллагууд, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагууд болон бусад оролцогч талууд орно. Яриа хэлэлцээний орон зай нь нээлттэй засгийн шинэчлэлийг үр дүнтэй урагшлуулахад шаардлагатай бүх гол оролцогчдыг хамарсан байх ёстой. Гэхдээ ингэснээр Засгийн газар болон иргэний нийгмийн хооронд аль хэдийн бий болсон бусад харилцаа, хамтын ажиллагааны механизмтай давхардуулж болохгүй гэдгийг анхаарна уу.

Доорх хэсэгт, шаардлагатай яриа хэлэлцүүлгийн орон зайг “Үндэсний зөвлөл (ҮЗ)” гэж нэрлэсэн бөгөөд ийм орон зайг бий болгоход гол арга барил, анхаарах зүйлсийн тухай танилцуулсан болно.

4.1 ҮЗ-ийн үүрэг хариуцлага

ҮЗ-ийн зорилго нь нээлттэй засгийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар болон иргэний нийгэм хамтран ажиллах бүтэцтэй, хүртээмжтэй механизм бүрдүүлэхэд оршино. Хэдийгээр ҮЗ-ийн гол үүрэг, хариуцлага нь улс орон бүрийн нөхцөл байдал, хэрэгцээнээс хамааран харилцан адилгүй байж болох ч нийтлэг тохиолддог, үүгээр хязгаарлагдахгүй дараах чиг үүргийг агуулдаг.

- **Стратеги болон тактикийн төлөвлөлт:** Боломжит нөөц бололцоо, Засгийн газрын дотоод болон гадаадын тэргүүлэх чиглэл, улс төрийн нөхцөл байдал зэргийг харгалзан ҮЗ нь нээлттэй засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх хамгийн оновчтой арга зам бөгөөд үүнийг НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ болон стратегийн түвшинд тодорхойлж ажиллана. Ийнхүү ажиллахдаа үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх, шагналд нэр дэвшүүлэх, санхүүжилтийн хүсэлт гаргах, Нээлттэй засгийн сорилтод оролцох зэрэг багтана. Жишээлбэл, ҮЗ нь тухайн төлөвлөгөөний зорилго, стратегийн сэдвийг тодорхойлж нийгэм, улс төрийн хүрээнд гарч буй шинэ хэрэгцээ, боломжид хариу өгөхөд ашиглаж болно. Үүний зэрэгцээ, ҮЗ нь ил тод, нээлттэй засгийг дэмжих олон салбарын хамтарсан санаачлагыг уялдуулах, зохицуулах эсвэл санал хүсэлт хүлээн авах хэлбэрээр дэмжих боломжтой.

Тэмдэглэл: Танай улс дотооддоо НЗТ-ийн үйл явц ямар түвшинд байгааг үнэлэх зорилгоор “НЗТ-ийн шалгалтын асуулгын хуудас”-ыг бөглөхийг зөвлөж байна.

- **Оролцоо:** ҮЗ нь нээлттэй засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явцад Засгийн газрын дотоод болон гадаад оролцогч талуудыг хэрхэн татан оролцуулах арга замыг идэвхтэй эрэлхийлж санал болгодог. Үүнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх мөн бусад холбогдох санаачлагуудад оролцох боломжууд багтана. ҮЗ нь академик байгууллага, хувийн хэвшил зэрэг төрийн бус оролцогч талуудыг НЗТ-ийн үйл явцад оролцуулах боломжийг ч бий болгодог. Мөн тодорхой уулзалт, арга хэмжээнд биечлэн оролцох боломжгүй бүлгүүдийг хамруулах үүднээс цахим оролцооны боломжоор хангах зэргээр хүртээмжийг нэмэгдүүлдэг.
- **Харилцаа холбоо:** ҮЗ нь нээлттэй засгийн шинэчлэл болон тухайн улс дахь НЗТ-ийн үйл явцын талаар, жишээлбэл Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүнд хэрхэн оролцож болох талаарх мэдээллийг нээлттэй засгийн оролцогч талууд болон олон нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг. Мөн өөрийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэр, гаргасан үр дүнгийн талаар Засгийн газар болон иргэний нийгмийн оролцогч талуудад идэвхтэй мэдээлж тайлагнадаг.
- **Oversight.** Хяналт-шинжилгээ: ҮЗ нь тухайн улсын НЗТ-тэй холбоотой дотоод үйл явцад хяналт тавих үүрэгтэй бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх, бусад нээлттэй засгийн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх үйл явц мөн багтана. Жишээлбэл, ҮЗ нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлж байгааг үнэлэх, ирээдүйн мөчлөгүүдэд хэрхэн сайжруулж болох талаар шийдэл, арга замыг санал болгох орно. Түүнчлэн, улс орны гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-аас тайлан бэлтгэх үед ҮЗ нь тус үнэлгээний явцад хамтран ажиллаж мэдээлэл өгдөг (Дэлгэрэнгүй мэдээллийг “ХБТМ-ын зайлшгүй биелүүлэх шаардлагыг хэрхэн үнэлдэг тухай” хэсгээс үзнэ үү).

4.2 ҮЗ байгуулахад анхаарах гол хүчин зүйлс

ҮЗ нь Засгийн газар болон иргэний нийгмийг төлөөлсөн гишүүдээс бүрдэнэ. ҮЗ-ийн бүрэлдэхүүнийг дараах үндсэн зарчмыг харгалзан тодорхойлно.

- **Тэнцвэр:** ҮЗ-д Засгийн газар эсвэл иргэний нийгмийн аль нэг тал давамгайлахгүй, бүх тал оролцоотой байх ёстой. НЗТ-ийг хариуцсан ажлын алба нь иргэний нийгмийн төлөөлөлтэй зөвлөлдөж бусад төрийн байгууллага, оролцогч талуудын оролцоог тодорхойлж зохицуулдаг.

Үндэсний зөвлөл

- **Тэгш хүртээмж:** ҮЗ нь эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, LGBTQIA+ төлөөлөл, уугуул иргэд мөн орхигдсон бусад бүлгийн төлөөллийг идэвхтэй хамруулах шаардлагатай. Эдгээр бүлгүүд нь Засгийн газрын шинэчлэлийг боловсруулахад чухал үүрэгтэй бөгөөд тэдний өвөрмөц хэрэгцээ, үзэл бодол, туршлагыг харгалзаж, тэдний оролцоо нь бодлогын чанарт шууд нөлөөлөхийг анхаарч үзнэ.
- **Ялгаатай байдал:** ҮЗ нь өргөн хүрээний оролцогч талууд, ашиг сонирхол, бодлогын чиглэлийг төлөөлөх ёстой. Ялгаатай байдлын үнэлгээ хийх нь ҮЗ-д ямар бүлэг эсвэл ашиг сонирхол нөлөөтэй байна, аль нь нөлөөлөл багатай байгааг тодорхойлоход тусалдаг.

ҮЗ байгуулахад зориулсан тогтсон нэг загвар, заавал дагах хүрээ гэж байхгүй бөгөөд НЗТ-ийн гишүүн орны ҮЗ-ийн бүтэц, хамрах хүрээ, шийдвэр гаргах үйл явц нь улс орон бүрт мэдэгдэхүйц ялгаатай байдаг. Гэсэн хэдий ч аль ч загварыг ашигласан, дараах зарчмыг харгалзан үзэх нь үр дүнтэй, ач холбогдолтой хэлэлцүүлгийн орон зайг бий болгоход зөв чиглүүлэн тусалдаг.

- **Одоогийн бүтэцтэй уялдуулах:** ҮЗ-ийг байгуулахаас өмнө Засгийн газар болон иргэний нийгмийг нэгтгэдэг, одоо ажиллаж байгаа зөвлөл, хороо, бүлэг болон бусад хамтын ажиллагааны механизмыг тодорхойлох хэрэгтэй. Ийм бүтэц дээр тулгуурлах эсвэл тэдгээртэй уялдуулах нь шинэ давхардал үүсгэхгүйгээр ҮЗ-ийг нээлттэй засгийн шинэчлэлтэй уялдуулах, нэгдсэн бүтэц болгон бэхжүүлэх боломжийг бүрдүүлдэг байна.
- **Засгийн газрын төлөөлөл:** Нээлттэй засгийн бодлогыг хэрэгжүүлэх яам, агентлаг, хэлтсийн төлөөлөл ҮЗ-д заавал оролцох нь маш чухал. Мөн Засгийн газрын хэмжээнд зохицуулалт хийх чадамжтай яамдыг хамруулах нь үр дүнтэй байдаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх агентлагууд хэрэгжилтийн шатанд ҮЗ-тэй байнгын холбоотой байх, мэдээлэл солилцох, идэвхтэй оролцох шаардлагатай.
- **Иргэний нийгмийн төлөөлөл:** Иргэний нийгмээс ҮЗ-д оролцогчдыг сонгох арга нь улс орны нөхцөл байдалд тохируулан өөр өөр байж болно. НЗТ-аас санал болгож буй хамгийн зохимжтой арга нь өөрсдөө сонгон шалгаруулах явц юм. Энэ нь иргэний нийгмийн байгууллагууд өөрсдөө хоорондоо зөвшилцөн, хэн нь ҮЗ-д оролцохыг шийднэ гэсэн үг юм. Энэхүү үйл явц нь олон оролцогч талууд, түүний дотор хязгаарлагдмал боломжтой эсвэл гадуурхагдсан бүлгүүдэд хүрч ажиллах, оролцох сонирхолтой бүх иргэний нийгмийн байгууллагад мэдээлэл өгөх, өөрийгөө нэр дэвшүүлэх боломж олгох ёстой юм. Хэрэв Засгийн газар сонгон шалгаруулалтад оролцох бол үйл явц нь ил тод, бүх сонирхсон иргэний нийгмийн оролцогчдод нээлттэй, тодорхой дүрэм, шалгуурт үндэслэсэн байх шаардлагатай. Мөн ҮЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхой хугацаанд шинэчилж өргөтгөх, шинэ болон олон талын оролцогчдыг нэгдэх боломжтой болгох нь зүйтэй.
- **Бусад төлөөлөл:** Зарим НЗТ-ийн гишүүн оронд төрийн бусад шат, салбарын төлөөлөл, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл мөн ҮЗ-д хамрагддаг. Зарим тохиолдолд донор байгууллага, олон улсын байгууллагууд тодорхой чиглэлээр хувь нэмэр оруулах “ажиглагч”-ийн үүрэгтэй оролцож болдог. Гэхдээ эдгээр оролцоо нь иргэний нийгмийн төлөөлөлд зориулсан орон зайг хязгаарлах эсвэл орлуулах ёсгүй юм.
- **ҮЗ-ийн бүрэлдэхүүн:** ҮЗ нь Засгийн газар болон иргэний нийгмийг төлөөлсөн хангалттай тооны гишүүдтэй байх ёстой. Энэ нь тухайн улс дахь нээлттэй засгийн гол оролцогч талуудыг бүрэн хамруулах, хүртээмжтэй байдлыг хангахад чиглэнэ. Үүний зэрэгцээ ҮЗ нь хэт том бүрэлдэхүүнтэй биш, шийдвэр гаргалт болон үйл ажиллагаа хурдан, үр дүнтэй гүйцэтгэх чадвар бүхий хэмжээтэй байх шаардлагатай. ҮЗ-ийн нэг үндсэн үүрэг бол НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд

Үндэсний зөвлөл

гаднах оролцогч талуудыг татан оролцуулах явдал юм. ҮЗ нь НЗТ-ийн үйл явцад оролцож буй бүх талуудыг бүрэн төлөөлдөг байгууллага биш гэдгийг мөн ойлгох нь чухал.

- **Улс төрийн дэмжлэг:** Улс төрийн дэмжлэг, ялангуяа гүйцэтгэх засаглалын өндөр албан тушаалтны дэмжлэг нь ҮЗ амжилттай ажиллахад нэн шаардлагатай. Энэ дэмжлэгийг авахдаа тодорхой үйл ажиллагаанд өндөр түвшний албан тушаалтныг оролцуулах, тэдгээр албан тушаалтанд мэдээллийг тогтмол хүргэх эсвэл ҮЗ-ийн ажилд оролцуулснаар баталгаажуулж болно.
- **Хууль ёсны байдал:** Зарим тохиолдолд ҮЗ-ийн гишүүд нь хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг хууль эрх зүйн болон захиргааны үндэслэлтэй байж болно. Энэ үндэслэл нь гүйцэтгэх засаглалын тушаал, хууль ёсны тогтоол эсвэл одоо хэрэгжиж буй хууль тогтоомжийн хэлбэртэй байж болно. Бусад тохиолдолд албан ёсны болон албан бус гэрээ нь ҮЗ-ийн оролцогчдын хувьд хангалттай байж болно.

Дотоод болон гадаад хүлээлтийг удирдан зохицуулахын тулд ҮЗ нь үүрэг хариуцлагаа тодорхой тодорхойлж, яриа хэлэлцээр, хамтын ажиллагаа, хамтын бүтээлийн орон зай гэсэн байр суурийг илэрхийлэх хэрэгтэй. ҮЗ-ийн дор хаяж гурван төрлийн загвар байдаг. Гэсэн хэдий ч нөхцөл байдлаас хамааран эдгээр тохиргоо нь ихэвчлэн холилддог тохиолдол байдаг.

- **ҮЗ шийдвэр гаргах байгууллага:** Энэ загварт ҮЗ нь тодорхой нээлттэй засгийн бодлого, үйл явцын талаар заавал биелүүлэхийг шаардах шийдвэр гаргах эрх мэдэлтэй байна. Засгийн газар эдгээр шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээснээр ҮЗ-ийн удирдамжийг үйлдэл болгодог. Энэхүү зохицуулалт нь оролцогч талуудад ажил урагшлуулах эрх олгож, ҮЗ-д харагдахуйц бодит шинэчлэлийг хийх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, саадгүй хэрэгжилтийг хангах зорилгоор одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн болон захиргааны тогтолцоотой нягт уялдаатай байх ёстой.
- **ҮЗ зөвлөлдөх байгууллага:** Энэ загварт ҮЗ нь зөвлөх үүрэг гүйцэтгэнэ. Энэ нь эцсийн шийдвэр гаргах эрх мэдэл Засгийн газарт байсан ч ҮЗ нээлттэй засгийн санаачилгын талаар зөвлөмж гаргах юм. Энэ бүтэц нь Засгийн газарт хяналтаа хадгалах боломжийг олгохоос гадна илүү өргөн хүрээтэй оролцогч талуудын саналыг сонсож ашиг шим хүртэх боломж олгодог. Оролцогч талуудын итгэлийг хадгалж оролцоотой байхын тулд Засгийн газар нь ҮЗ-ийн зөвлөмжийг хэрхэн авч үзэж шийдвэрлэсэн тухай тодорхой, ил тодоор тайлагнах нь чухал юм.
- **Холимог загвар:** Энэ загварт шийдвэр гаргах болон зөвлөлдөх бүтэц хоёулаа багтана. ҮЗ нь нээлттэй засгийн тодорхой асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх бөгөөд мөн зөвлөмж хүргүүлдэг байна. Энэхүү уян хатан загварт ҮЗ нь тодорхой бодлогын чиглэлд шийдвэр гаргах боломж олгохоос гадна төөрөгдөлөөс урьдчилан сэргийлж үүрэг хариуцлагыг маш тодорхой зурах, ҮЗ болон Засгийн газар хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжих үүрэгтэй байна.




5

Мэдээллийн ил тод байдлыг хангах нь

Гол зөвлөмж

- НЗТ-ийн бүх гишүүн орон Стандарт 2-н дагуу үндэсний НЗТ-ийн цахим хуудас болон цахим баримтын санг байгуулах, байнгын ажиллагаатай байлгах шаардлагатай.
- Бүх НЗТ-ийн гишүүд НЗТ-ийн цахим хуудас болон цахим баримтын санг байгуулахтай холбоотой зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангаж, Стандарт 2-г хэрэгжүүлэхийн тулд цахим хуудасны загвар болон агуулгын шийдлийг өргөн хүрээнд авч үзэхийг уриалдаг.
- НЗТ-ийн цахим хуудас нь бие даасан цахим хуудас эсвэл Засгийн газрын цахим хуудаст дэд хуудсаар ажиллаж болно. Үүнд тухайн улсын НЗТ-ийн үйл явц, үр дүн, хэрэгжилттэй холбоотой бүх мэдээлэл нийтлэгдсэн байх шаардлагатай.
- Цахим баримтын сан гэдэг нь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй (үйл явц болон хэрэгжилтийг багтаасан) холбоотой нотолгоо, мэдээллийг хадгалдаг, төвлөрсөн цахим хуудас, платформ эсвэл фолдер юм. Энэ нь мэдээллийг нийтэд нээлттэйгээр хадгалах, шинэчлэх, түгээх зориулалттай.
- Мэдээллийн ил тод байдал нь НЗТ-ийн үйл явц дахь оролцоо, хяналт-шинжилгээ, хариуцлагын үндэс суурийг бүрдүүлдэг.



Мэдээллийн ил тод байдал

Ил тод байдал ба нийтийн хариуцлага нь НЗТ-ийн үндсэн зарчмуудын нэг бөгөөд зөвхөн [НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандартад](#) тусгаад зогсохгүй мөн НЗТ-ийн хариуцлагын хэрэгсэл болох Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-аар бататгадаг (Дэлгэрэнгүй мэдээллийг [“Хариуцлага ба суралцах явцыг ХБТМ-аар хангах”](#) хэсгээс үзнэ үү).

Ил тод байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг нь НЗТ-ийн үйл явц, түүнийг дагалдах үйл ажиллагаа мөн Засгийн газар үүрэг амлалтаа биелүүлж буй явцын талаарх мэдээлэлд хялбар, цаг тухайд нь нэвтрэх боломжийг хангах явдал юм. Гишүүн орон хоёр үндсэн платформтой байх шаардлагатай: НЗТ-д зориулсан цахим хуудас (Зайлшгүй биелүүлэх шаардлага 2.1) ба Цахим баримтын сан (Зайлшгүй биелүүлэх шаардлага 2.2). Эдгээр платформ нь өөр өөр зорилготой боловч харилцан бие биенээ нөхөж, НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандартын шаардлагыг хангахад мөн НЗТ-ийн ил тод байдлын зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

НЗТ-ийн гишүүн орон хамгийн дээд түвшинд ил тод байдлын зарчмыг баримтлах ёстой. Энэ нь холбогдох мэдээллийг урьдчилан, цаг тухайд нь, хамгийн хүртээмжтэй байдлаар, хамгийн тохиромжтой сувгаар олон нийтэд түгээх үйл явц юм. Энэхүү ил тод байдал нь хэд хэдэн чухал үүрэг гүйцэтгэдэг.

- Нийтийн хүртээл болсон мэдээлэл нь НЗТ-ийн үйл явц болон түүнд оролцох боломжийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлдэг.
- Нээлттэй мэдээлэлд чөлөөтэй хандах боломж нь иргэний нийгэм болон иргэдэд үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах, хэрэгжүүлэхэд бодитойгоор оролцох боломжийг олгодог.
- Ил тод байдлын баримтжуулалт нь оролцогч талуудад хэрэгжилтийн явцыг хянах, тулгарч буй сорилтыг тодорхойлох мөн нээлттэй засгийн үүрэг амлалтад хариуцлага тооцох боломжийг бүрдүүлдэг.

5.1 НЗТ-д ашиглах үндэсний цахим хуудас

Улс орны НЗТ-д ашиглах үндэсний цахим хуудас нь бие даасан цахим хуудас эсвэл Засгийн газрын цахим хуудас доторх дэд хуудас хэлбэртэй байж болно. Тус цахим хуудаст тухайн улсын НЗТ-ийн үйл явц, үр дүн, хэрэгжилттэй холбоотой бүх мэдээлэл нийтлэгдсэн байх ёстой.

Стандарт 2

НЗТ-д гишүүн орон холбоотой үйл ажиллагаа, ахиц дэвшлийн талаарх мэдээллийг ил тод, хүртээмжтэй, цаг хугацаанд нь олон нийтэд хүргэх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 2.1

Нийтэд нээлттэй НЗТ-ийн цахим хуудас байнгын ажиллагаатай байна.

ХБТМ-ын үнэлгээ

ХБТМ нь тухайн улс дараах хоёр гол шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ:

- Цахим хуудас тэгш хүртээмжтэй юу?
- Цахим хуудас байнгын ажиллагаатай бөгөөд хамгийн сүүлийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан уу?

ХБТМ-ын удирдамжийг [энд дарж](#) үзнэ үү.

Мэдээллийн ил тод байдал

Засгийн газраас нийтэд мэдээлэл түгээхдээ ашиглахад тохиромжтой, хэрэгтэй байлгахын тулд дараах үндсэн хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

- • **Хэл:** Засгийн газар нь НЗТ-тэй холбоотой гол мэдээлэл, баримт бичгийг улсын албан ёсны хэлээр нийтэлсэн байх ёстой.
- • **Тэгш хүртээмж:** Засгийн газар нь харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг илүү хүртээмжтэй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.
- • **Нээлттэй байдал:** Засгийн газар нь үйл явц болон үүрэг амлалтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, өгөгдлийг техникийн болон хууль эрх зүйн хувьд хэзээ ч, хаана ч, хэн ч чөлөөтэй ашиглах, түгээх боломжтой хэлбэрээр нийтэд нээлттэй болгох ёстой.

Гишүүн орны туршлагаас үзэхэд, НЗТ-ийн цахим хуудас нь дараах шинж чанартай байвал илүү үр дүнтэй, хүртээмжтэй байдаг. Үүнд;

- Мэдээллийг хялбархан хайж, олж авах боломжтой байх
- Мэдээлэл, баримт бичиг нь иргэдэд ойлгоход хялбар, техникийн бус, ойлгомжтой бичигдсэн байх
- Иргэд мэдээлэлд санал, сэтгэгдэл үлдээх боломжтой байх

Тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбар нь цахим хуудас дээр заавал нийтлэгдсэн байх ёстой. Үүнээс гадна дараах мэдээллийг мөн оруулахыг зөвлөж байна.

- НЗТ-д хариуцсан гол агентлаг болон хариуцсан ажлын албаны мэдээлэл, холбоо барих хаяг
- НЗТ-ийн үйл явцад оролцож буй бусад төрийн байгууллагуудын нэр, холбоо барих мэдээлэл
- НЗТ-ийн үйл явцын талаар болон иргэд хэрхэн оролцох боломжтой талаар мэдээлэл
- Үндэсний зөвлөл (ҮЗ) буюу түүнтэй дүйцэх хэлэлцүүлгийн орон зайд хуралдаанаар хэлэлцэх асуудал, хурлын тэмдэглэл
- ҮЗ буюу түүнтэй дүйцэх орон зайд оролцож буй иргэний нийгмийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын жагсаалт
- Хэрэв тухайн оролцооны хэлбэр сонгогдсон бол Зайлшгүй биелүүлэх шаардлага 2.2-т заасан цахим баримтын санг тусгайлан байршуулах (дараагийн хэсгийг үзнэ үү)
- Тухайн улсын нээлттэй засгийн үйл явцтай холбоотой бусад холбогдох баримт бичиг

5.2 Цахим баримтын сан

НЗТ-ийн зорилгоор ашиглах баримтын сан гэдэг нь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл болон нотолгоог (үүнд төлөвлөгөө боловсруулах үйл явц ба хэрэгжилт багтана) олон нийтэд зориулан төвлөрүүлсэн байдлаар хадгалдаг, зохион байгуулдаг, шинэчилдэг, түгээдэг цахим хуудас, платформ эсвэл фолдер юм.

Стандарт 2

НЗТ-ийн гишүүнийн хувьд үйл ажиллагааны болон үйл явцын талаарх мэдээллийг нээлттэй, тэгш хүртээмжтэй, цаг тухайд нь нийтлэн түгээх.

ЗАЙЛШГҮЙ БИЕЛҮҮЛЭХ ШААРДЛАГА 2.2

НЗТ-ийн цахим хуудас дээр олон нийтэд нээлттэй баримтын сан байршсан байна. Энэхүү сан нь НЗТ-ийн үйл явцтай холбоотой баримт бичгүүдэд нэвтрэх боломжийг олгох бөгөөд дор хаяж хамтран бүтээх үйл явц болон үүрэг амлалтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, нотолгоог агуулсан байна. Баримт бичгийн санг байнга шинэчилж байх бөгөөд жилийн хугацаанд дор хаяж хоёр удаа шинэчилсэн байх шаардлагатай.

ХБТМ-ын үнэлгээ

ХБТМ нь тухайн гишүүн улс дараах гурван гол шалгуурыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ:

- Баримтын сан цахим орчинд байршсан уу?
- Баримтын санг жилийн хугацаанд дор хаяж хоёр удаа шинэчилсэн үү?
- Баримтын сан дээр байршуулсан мэдээлэл нь НЗТ-ийн хамтран бүтээх үйл явц болон үүрэг амлалтын хэрэгжилттэй холбоотой байна уу?

ХБТМ-ын удирдамжийг [энд дарж](#) үзнэ үү.

Баримтын сан нь эгэх хариуцлагын хэрэгсэл болох зорилготой юм. Энэ нь Засгийн газрын НЗТ-тэй холбоотой үйл ажиллагааны нотолгоонд оролцогч талууд цаг тухайд нь, ил тод байдлаар нэвтрэх боломжийг олгодог энгийн, үр ашигтай арга хэрэгсэл юм. Тус сан нь НЗТ-ийн үйл явц болон үүрэг амлалтын хэрэгжилтийн бодит ахиц дэвшлийг нотлох мэдээллийг харуулдаг бөгөөд ингэснээр Засгийн газар болон иргэний нийгмийн аль алинд нь харилцан ашигтай оролцоог дэмждэг. Баримтын санг тухайн гишүүн улс үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавихад ашиглаж болно.

Үр дүнтэй баримтын санг бүрдүүлэхэд анхаарах гол хүчин зүйлс.

- Сангийн хүлээн авах мэдээллийн агуулга, төрлийг тодорхой зааж, холбогдох яам, агентлагуудад нээлттэй мэдээлэх. Энэ нь мета өгөгдөл, формат, шаардлагатай тохиолдолд агуулгын чанарыг хянах боломжийг бүрдүүлдэг.
- Үүрэг амлалтын хэрэгжилтийн явцыг хянах үүрэгтэй нэгж, албан тушаалтныг томилж, тэдгээр хүмүүс нотолгоо хэрхэн цуглуулах, санд байршуулах талаар бүрэн ойлголттой болох ёстой.
- Платформ нь үндэсний болон олон улсын өгөгдлийн бүтэц, аюулгүй байдал, нууцлал, хүртээмж, архивын талаарх зохицуулалтыг хангах шаардлагатай.

Зайлшгүй биелүүлэх шаардлагад нийцсэн цахим баримтын санг бүрдүүлэхэд хэд хэдэн арга зам бий.

- **НЗТ-ийн цахим хуудсын** нэг хэсэг болгон бүрдүүлэх
 - Хамгийн энгийнээр энэ нь цахим фолдерын цуврал байж болно. Үүнд үүрэг амлалт бүрт зориулсан фолдер, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явцад зориулсан фолдер багтсан байна. Тэгш хүртээмжийг сайжруулах үүднээс үүрэг амлалтын хэрэгжилт болон нотолгооны байдлыг хянах хүснэгтийг хавсаргаж болно. Зарим НЗТ-ийн гишүүн орон цахим хянах самбарыг ашиглан ахиц дэвшлээ ил тод харуулах боломжтой байдаг.
- **Бэлэн хэрэгсэл** ашиглан бүрдүүлэх
 - Google Drive эсвэл Dropbox зэрэг үүлэн хадгалалтын платформыг ашиглаж болно. Энэ сонголтыг хийх тохиолдолд тухайн улсын хууль, журмын дагуу, ялангуяа нууцлал ба мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангах ёстой. Үйл ажиллагааны төлөвлөгөөний үүрэг амлалт бүрт тусгай фолдер мөн төлөвлөгөө боловсруулах үйл явцын фолдер үүсгэх шаардлагатай. Фолдер нь олон нийтэд нээлттэй байх тохиргоотой мөн шинэ мэдээлэл гарсан даруйд байршуулах

Мэдээллийн ил тод байдал

шаардлагатай. Фолдеруудад хавсаргасан хянах хүснэгтийг ашиглан хэрэгжилтийг хянах боломжтой.

- **Нээлттэй эх сурвалжийг** ашиглан баримтын санг бүрдүүлэх
 - ∞ E-prints, DSpace, CONSUL зэрэг нээлттэй эх сурвалжийг ашиглан цахим баримтын сангийн платформ нь өртөг багатай бөгөөд олон төрлийн баримт бичгийн форматыг дэмждэг байж болно. Эдгээр систем нь агуулгыг хайлтын систем руу нэгтгэх, хялбар илрүүлэх боломжоор хангадаг тул үр ашигтай шийдэл болдог

Загвар, платформын сонголтоос үл хамааран баримтын сан нь дараах шаардлагыг хангах ёстой:

- Цахимаар чөлөөтэй нэвтрэх боломжтой байх буюу хэн ч хамаагүй баримтын санг хялбархан олж, нэвтрэх боломжтой байх ёстой. Нэвтрэхэд нууц үг эсвэл хэрэглэгчийн эрх шаардахгүй байх хэрэгтэй.
- Нотолгоонд тулгуурласан байх буюу баримтын санд байршсан мэдээлэл нь үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах болон хэрэгжүүлэх явцад юу болсон талаар тодорхой нотолгоо болох ёстой.
- Тогтмол шинэчлэдэг байх буюу баримтын санг жилийн хугацаанд дор хаяж хоёр удаа шинэчилсэн байх бөгөөд хамтран бүтээх үйл явцын мэдээлэл ба нотолгоо, үүрэг амлалтын хэрэгжилтийн мэдээлэл ба нотолгоог заавал агуулсан байна.

ХБТМ-аас гаргасан энэхүү **хураангуй гарын авлага** нь дээрх шаардлагыг нэг дор товчлон танилцуулдаг.



6

Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалт боловсруулах

Гол зөвлөмж

- Гишүүн орон НЗТ-ийн дүрэм, шаардлагын дагуу мөн Стандарт 3 ба 4-н хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй.
- Гишүүн орон хоёр жил эсвэл дөрвөн жилийн хугацаатай үйл ажиллагааны төлөвлөгөөний аль нэгийг сонгож болно. Дөрвөн жилийн төлөвлөгөө нь заавал шинэчлэх үйл явцтай байх ёстой.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой тодорхой дүрэм, шаардлага байдаг. Мөн цаг хугацааны төлөвлөлт, төлөвлөгөөг хүргүүлэх журам, хүргүүлэх хугацаа, засвар, нэмэлт оруулах нөхцөл, дөрвөн жилийн төлөвлөгөөг шинэчлэхтэй холбоотой тусгай шаардлагууд багтана.
- Стандарт 3 ба 4-г хэрэгжүүлж, хүсэл зорилготой төлөвлөгөө, үүрэг амлалт боловсруулахын тулд НЗТ-ийн гишүүн орон төлөвлөлтийн үе шат, оролцогч талууд руу чиглэсэн идэвхжүүлэлт, оролцооны ажиллагаа, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад санал хүсэлт хүлээн авч, үндэслэл бүхий хариу өгөх зэрэг хамтран бүтээх дөрвөн гол мөчлөг дээр төвлөрөх хэрэгтэй.
- НЗТ нь үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгад чиглэсэн гарын авлага мөн гишүүн орон өөрийн хэрэгцээнд тохируулан ашиглаж болох үүрэг амлалтын загвар маягт зэргийг ханган өгдөг.



НЗТ-ийн гол цөм нь үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг амлалт юм. НЗТ-ийн бүх гишүүн орон НЗТ-ийн шаардлагыг хангаж, цаг хугацаанд нь багтаан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хүргүүлэх үүрэгтэй (Дэлгэрэнгүй мэдээллийг [“НЗТ-ийн үндэсний гишүүдийн гол үүрэг, хариуцлага”](#) хэсгээс үзнэ үү). Үйл ажиллагааны төлөвлөгөө нь нээлттэй засгийн бодит шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг амлалтын багцыг агуулсан байдаг. Сүүлийн арван жилийн хугацаанд цугларсан НЗТ-ийн өгөгдөлд үндэслэсэн [судалгаанаас](#) харахад эрч хүчтэй, тэгш хүртээмжтэй хамтран бүтээх үйл явц нь сайн боловсруулсан, хүсэлт зоригтой үүрэг амлалттай шууд холбоотой болох нь батлагдсан.

Мэдэхэд илүүдэхгүй

НЗТ-ийн загварын тулгуур ойлголт болох хамтран бүтээх үйл явцын тухай



Засгийн газар, иргэний нийгэм болон бусад оролцогч талууд (жишээлбэл: иргэд, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил) хоорондын хамтын ажиллагаа нь НЗТ-ийн үйл явцын үндсэн цөм бөгөөд үүнийг “хамтран бүтээх” гэж нэрлэдэг. НЗТ-д оролцож буй Засгийн газар нь өргөн хүрээний үзэл бодол, төлөөлөл бүхий бүлгүүдийг бодитойгоор оролцуулж, үүрэг амлалтыг хамтран тодорхойлох боломжийг бүрдүүлэх үүрэгтэй. Хамтран бүтээх үйл явц нь НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээний үндэс суурь бөгөөд энэ нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг. НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт нь байнгын яриа хэлэлцээний орон зайг бий болгох, мэдээлэл, бичиг баримтыг цахим баримтын санд нийтэд нээлттэй байршуулах зэрэг тодорхой хүлээлт, шаардлагыг тогтоосон байдаг.

Энэ хэсэгт НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт болон зайлшгүй биелүүлэх шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тайлбарлана. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ба хүргүүлэх үйл явцыг зохицуулсан дүрэм, шаардлагыг танилцуулж, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгнө. Түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах үе шатыг төлөвлөх, төлөвлөгөөний агуулга, загвар маягт, нэмэлт хэрэгслийн албан ёсны заавар ч мөн багтсан болно.

6.1 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үеийн оролцоо, хамтран бүтээх стандартыг хэрэгжүүлэх

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үе шатанд улс орнууд бодит оролцоог хангахын тулд НЗТ-д оролцох ба хамтран бүтээх хоёр тодорхой стандартыг биелүүлэхийг зорих ёстой.

Стандарт 3

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад олон нийтэд хүртээмжтэй, мэдээлэлд суурилсан оролцох боломжийг бүрдүүлэх.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 3.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаас дор хаяж хоёр долоо хоногийн өмнө хамтран бүтээх үйл явцын ажлын хуваарь болон оролцогч талуудад зориулсан оролцооны боломжийн тухай тоймыг НЗТ-ийн цахим хуудсан дээр нийтэлсэн байна.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 3.2

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар НЗТ-ийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх мөн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцох боломжийн тухай мэдээлэх зорилгоор оролцогч талууд руу чиглэсэн сурталчилгаа, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулна.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 3.3

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар сонгосон оролцооны механизмаа хэрэгжүүлэхэд өргөн хүрээний оролцогч талаас санал авах механизмыг боловсруулсан байна.

Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-ын үнэлгээ

ХБТМ нь тухайн улс дараах гол шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг үнэлнэ:

- 3.1: Хамтран бүтээх үйл явцын ажлын хуваарь болон оролцох боломжийн талаарх мэдээлэл нийтэд нээлттэй байсан уу?
- 3.1: Энэ мэдээлэл үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахаас дор хаяж хоёр долоо хоногийн өмнө нийтлэгдсэн үү?
- 3.2: ҮЗ эсвэл Засгийн газар НЗТ-ийн үйл явцын талаар мэдлэг олгох, оролцох боломжийг таниулах зорилгоор оролцогч талууд руу чиглэсэн сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулсан уу?
- 3.3: Өргөн хүрээний оролцогч талаас санал авах механизм хэрэгжүүлсэн үү?
- 3.3: Уг механизм нь тухайн зорилгын хугацааны турш хэрэгжсэн үү?

ХБТМ-ын удирдамжийг **энд дарж** үзнэ үү.

Стандарт 4

Үйл ажиллагааны төлөвлөгөө хамтран боловсруулах явцад төр болон төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх боломжоор хангаж, санал хүсэлтэд үндэслэлтэй хариу өгөх.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 4.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад оролцогч талуудын гаргасан санал санаачлагыг хэрхэн харгалзан үзсэн талаарх бичгэн хариуг баримтжуулж, нийтэлж эсвэл тайлагнаж байх ёстой.

ХБТМ-ын үнэлгээ

ХБТМ нь дараах хоёр гол шалгуураар үнэлгээ хийдэг:

- Оролцогч талуудын гаргасан санал, оролцоог баримтжуулсан уу?
- ҮЗ эсвэл Засгийн газар тухайн саналуудын талаар үндэслэлтэй хариу өгсөн үү, мөн энэ нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үе шатанд хийгдсэн үү?

ХБТМ-ын удирдамжийг **энд дарж** үзнэ үү.

Олон нийтийн оролцоо бодитой, утга учиртай байхын тулд НЗТ-ийн гишүүн орон хамтран бүтээх үйл явцыг зорилготой, төлөвлөгөөтэйгээр загварчлах шаардлагатай. Энэхүү үйл явц нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн агентлагууд, орон нутгийн захиргаа, парламент, эрдэм шинжилгээний хүрээлэн, хувийн хэвшил гэх мэт оролцогчдоос санал, санаачилга гаргах, тэргүүлэх чиглэл тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтаах үүрэг амлалтыг санал болгох боломжоор хангах ёстой.

Үүний зэрэгцээ, оролцогч талуудын саналыг үндэслэлтэйгээр хүлээн авч, хариу өгч буй байдал нь үүрэг амлалтын хүсэл зорилго, хэрэгжилт, үр дүнтэй шууд хамааралтай болох нь тогтоогдсон. Нийт 170 гаруй ХБТМ-ын тайланд үндэслэсэн **нотолгоог** харахад үндэслэлтэй хариу өгдөг орнууд хамгийн хүчтэй, үр дүнтэй үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байдаг. Аль нэг санал, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааг төлөвлөгөөнд яагаад оруулсан эсвэл оруулаагүй талаарх тодорхой, үндэслэл бүхий хариулт өгөх нь эгэх хариуцлагыг дээшлүүлэх, санал нь дэмжигдээгүй оролцогч талын сэтгэл дундуур байдал эсвэл үл оролцох байдлыг бууруулах, эсэргүүцлийг даван туулахад тус болдог байна. Стандарт 3 ба 4-г хэрэгжүүлэх талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл **"НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт"** хэсгээс үзнэ үү.

Стандарт тус бүрийн "Хэрэгжүүлэх арга зам" хэсэгт зөвлөмж, шилдэг туршлагууд багтсан болно.

6.2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний дүрэм, журам

Энэ хэсэгт НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүргүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой гол дүрэм, журмыг танилцуулна. Үүнд үндэсний тэргүүлэх чиглэлтэй уялдуулах хугацааны шаардлага, хүргүүлэх үйл явц, хоцролттой холбоотой зохицуулалт, төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжууд зэрэг багтана. Дөрвөн жилийн хугацаатай үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан улс орны хувьд хоёр жилийн дараа шинэчлэх үйл явц заавал хэрэгжих ёстой бөгөөд энэ нь төлөвлөгөөний үр нөлөө, цаг үеийн ач холбогдлыг хадгалахад чиглэдэг.

6.2.1 Үйл ажиллагааны төлөвлөгөөний хугацаа

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад үндэсний тэргүүлэх чиглэл болон НЗТийн үйл явцтай уялдуулах цаг хугацааны төлөвлөлт чухал ач холбогдолтой юм. НЗТ нь төлөвлөгөөний хугацаа болон хэрэгжилтийн цаг үеийг сонгох уян хатан боломжийг улс орнуудад олгодог.

- **Үйл ажиллагааны төлөвлөгөөний хугацаа.** Улс орнууд дараах хоёр хувилбараас сонгох боломжтой:
 - **Хоёр жилийн төлөвлөгөө:** Энэ хувилбар нь богино хугацааны үүрэг амлалт бүхий төлөвлөгөө бөгөөд шинэчлэлд төвлөрөх мөн хурдан үр дүн харуулах нөхцөлийг бүрдүүлдэг.
 - **Дөрвөн жилийн төлөвлөгөө:** Энэ хувилбар нь илүү хүсэл зорилготой эсвэл нарийн төвөгтэй шинэчлэлийг урт хугацаанд хэрэгжүүлэхэд тохиромжтой. Гэвч энэ тохиолдолд төлөвлөгөөг хоёр жилийн дараа заавал шинэчлэх ёстой бөгөөд хэрэгжилтийн явцыг хянаж, шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцыг өрнүүлнэ (Дэлгэрэнгүй мэдээллийг “**Нэмэлт, өөрчлөлт**” хэсгээс үзнэ үү).
- **Төлөвлөгөөг хүргүүлэх хугацааны сонголт:** Улс орнууд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө НЗТ-д хүргүүлэхдээ хоёр өөр хугацааны аль нэгийг сонгож болно. Сонгосон хугацаа нь төлөвлөгөө дуусгавар болох албан ёсны огноог тодорхойлно.
 - **6 дугаар сарын 30-ны өдөр дуусах хувилбар:** Улс орнууд 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор НЗТ-д шинэ үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хүргүүлж болно. Хүргүүлсэн төлөвлөгөө нь хоёр эсвэл дөрвөн жилийн дараа 06 дугаар сарын 30-ны өдөр албан ёсоор дуусгавар болно.
 - **12 дугаар сарын 31-ний өдөр дуусах хувилбар:** Улс орнууд 07 дугаар сарын 01-ний өдрөөс дараа жилийн 02 дугаар сарын 28-ны өдрийн дотор төлөвлөгөөгөө хүргүүлж болно. Энэ тохиолдолд төлөвлөгөө нь хоёр эсвэл дөрвөн жилийн дараа 12 дугаар сарын 31-ний өдөр албан ёсоор дуусгавар болно.

Тайлбар: Хэрэв 01 дүгээр сар, 02 дугаар сар, 07 дугаар сар эсвэл 08 дугаар сард төлөвлөгөөгөө хүргүүлж байгаа бол дуусах хугацаа нь 6 дугаар сарын 30-ны өдөр эсвэл 12 дугаар сарын 31-ний өдрийн аль нэгэнтэй давхцаж болно. Тиймээс төлөвлөгөөг хүргүүлэхдээ дуусгавар болох огноог тодорхой зааж өгөх шаардлагатай.

- **Дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх хугацаа:** Өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөө дуусмагц, тухайн улс дараагийн төлөвлөгөөг өмнөх төлөвлөгөө дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор НЗТ-д хүргүүлэх ёстой.
- **Сунгалт:** Энэ хугацааг сунгах боломжгүй бөгөөд ямар ч нөхцөлд сунгалт олгогдохгүй
- **Дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулах:** Тогтвортой, тасралтгүй үйл явцыг хангахын тулд одоогийн хүчин төгөлдөр буй үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж дуусахын өмнөх саруудад дараагийн төлөвлөгөөг хамтран боловсруулах ажлыг эхлүүлэхийг НЗТ зөвлөж байна.

6.2.2 НЗТ-д илгээх

Үйл ажиллагааны төлөвлөгөөг бүрэн боловсруулсны дараа НЗТ-ийн Дэмжих нэгжид албан ёсоор хүргүүлэх ёстой. Мөн НЗТ-ийн гишүүн орон төлөвлөгөөний төслийг урьдчилан хуваалцаж санал, зөвлөмж хүлээн авах боломжтой.

- Үйл ажиллагааны төлөвлөгөөг тус улсыг хариуцсан НЗТ-ийн ажилтанд имэйлээр илгээнэ. НЗТ-ийн тус ажилтан хүлээн авснаа баталгаажуулж, НЗТ-ийн цахим хуудас дээр нийтэлнэ.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн улсын албан ёсны хэлээр болон Англи хэлээр НЗТ-д хүргүүлэх шаардлагатай. Хоёр хэл дээрх хувилбарыг нэгэн зэрэг хүргүүлэхийг зөвлөж байна. Англи хэл дээр хүргүүлснээр ХБТМ судалгаа, үнэлгээний үйл явцыг эхлүүлэх боломжтой болно.
- Төлөвлөгөөг хүргүүлмэгц эцсийн хувилбарыг хүлээн авсанд тооцно, төсөл хэлбэрээр хүргүүлэх боломжгүй. Дэмжих нэгж уг төлөвлөгөөг албан ёсны хувилбараар нь НЗТ-ийн цахим хуудас дээр нийтэлнэ.
- Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг “**Нэмэлт, өөрчлөлт**” хэсгээс үзнэ үү.
- Дээр дурдсанчлан, улс орон өмнөх үйл ажиллагааны төлөвлөгөө дууссан өдрөөс хойш нэг жилийн дотор дараагийн төлөвлөгөөг НЗТ-д хүргүүлэх ёстой.

6.2.3 Саатах

НЗТ-ийн Дэмжих нэгж нь бүх гишүүн орныг жигд бүтэцтэй үйл явцаар хангахын тулд ижил хугацааны шаардлагыг мөрддөг.

- Дэмжих нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх хугацаанд сунгалт олгох эрх мэдэлгүй болно.
- Хэрэв гишүүн улс орон өмнөх төлөвлөгөө дууссанаас хойш нэг жилийн дотор шинэ төлөвлөгөөгөө хүргүүлээгүй бол тухайн улс албан ёсоор хоцорсонд тооцогдож НЗТ-ийн үйл явцын эсрэг үйлдэл хийсэн гэж үзнэ (Дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-ийн хариуцлагын механизм**” хэсгээс үзнэ үү). Ийм тохиолдолд Дэмжих нэгжээс тухайн улсад хоцорсныг мэдэгдэх захидал илгээнэ. Захидлын хувийг Шалгуур, стандартын дэд хороонд мөн хүргүүлнэ. Энэ нь цаашдын дэмжлэг, арга хэмжээ авах шаардлагыг хэлэлцэхэд ашиглагдах юм. Захидлыг тухайн улсын НЗТ-ийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулах болно.
- Хоцорсон улс дараа оны 06 дугаар сарын 30-ны өдөр эсвэл 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлөвлөгөөгөө заавал хүргүүлэх ёстой. Хүргүүлэхгүй бол НЗТ-ийн үйл явцын эсрэг давтан үйлдэл хийсэнд тооцогдож, улмаар албан ёсны “Шийтгэлийн үнэлгээ”-нд хамрагдана (Дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-ийн хариуцлагын механизм**” хэсгээс үзнэ үү).

Мэдэхэд илүүдэхгүй

Улс төрийн шилжилтийн үед үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх тухай



НЗТ нь гишүүн орныг үйл ажиллагааны төлөвлөгөөгөө цаг хугацаанд нь хүргүүлэхийг уриалдаг ч, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэхийг мөн хүлээн зөвшөөрдөг. Улс төрийн шилжилт ба сонгууль нь төлөвлөгөөг цагаасаа өмнө боловсруулж, өндөр түвшний улс төрийн дэмжлэг авах, үүрэг амлалтыг тасралтгүй хэрэгжүүлэх үйл явцад тодорхой сорилт учруулж болзошгүй байдаг.

Ийм нөхцөлд улс орнууд дараах стратегийн аль нэгийг сонгож төлөвлөгөөгөө хүргүүлэх боломжтой. Өмнөх туршлагад үндэслэн дараах хувилбарыг авч үзэж болно: 1. Энгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хүргүүлэх. 2. Хязгаарлагдмал цар хүрээтэй үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хүргүүлэх

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах гарын авлагын 1.с хэсгээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

6.2.4 Нэмэлт, өөрчлөлт

- Улс орнууд үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлснээс хойш нэг жилийн дотор (тухайн төлөвлөгөөний дуусах хугацаанаас хамааран 06 дугаар сарын 30-ны өдөр эсвэл 12 дугаар сарын 31-ний өдөр) үүрэг амлалт эсвэл зорилтот үр дүнг өөрчлөх, устгах боломжтой. Эдгээр өөрчлөлтийг Үндэсний зөвлөл (ҮЗ)-ийн зөвшилцлөөр хийхийг зөвлөж байна.
- Улс орнууд үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж буй хугацаанд шинэ үүрэг амлалтыг нэмж оруулах боломжтой. Гэхдээ эдгээр шинэ үүрэг амлалтын бүх зорилтот үр дүнг төлөвлөгөө дуусах хугацаанаас өмнө бүрэн хэрэгжүүлсэн байх ёстой.
- ХБТМ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний анхны үнэлгээ нь Дэмжих нэгжид илгээсэн анхны хувилбар дээр үндэслэнэ. Харин ХБТМ-ын хэрэгжилтийн тайлан нь Дэмжих нэгжид албан ёсоор хүргүүлсэн хамгийн сүүлийн хувилбарт үндэслэнэ. Дөрвөн жилийн хугацаатай үйл ажиллагааны төлөвлөгөөний хувьд, хоёр жилийн дунд үеийн үнэлгээгээр шинэ болон өөрчлөгдсөн үүрэг амлалтыг ХБТМ тусгайлан үнэлнэ.
- Өөрчлөлт хийх, тохируулга оруулах, устгах эсвэл шинэ үүрэг амлалт нэмэх аль ч тохиолдолд шинэчилсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг Англи хэлээр болон тухайн улсын албан ёсны хэлээр боловсруулж, оруулсан өөрчлөлтийг нарийвчлан тусгасан байдлаар НЗТ-ийн Дэмжих нэгжид хүргүүлэх шаардлагатай.
- Энэхүү журам нь хоёр ба дөрвөн жилийн төлөвлөгөөний аль алинд нь адилхан хамаарна. Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёр дахь жилд заавал шинэчлэх бөгөөд одоогийн үүрэг амлалтыг шинэчлэх боломж мөн бүрддэг байна (Дэлгэрэнгүй мэдээллийг “Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө” хэсгээс үзнэ үү).

6.2.5 Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах улс орон хоёр дахь жил дээрээ заавал шинэчлэх үйл явц өрнүүлэх ёстой. Энэ шинэчлэх үйл явц нь тухайн улс хэрэгжилтийг дүгнэх, өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг үнэлэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг үлдсэн хугацаанд үр өгөөжтэй, ач холбогдолтой байлгахын тулд шаардлагатай бол тохируулга хийх боломж олгодог. Шинэчлэлд үүрэг амлалтыг засварлах, шинэ үүрэг амлалт нэмэх, бусад нөхцөл байдалтай холбоотой шинэчлэлт оруулах зэрэг өөрчлөлтүүд хамаарч болно.

Бусад зайлшгүй биелүүлэх шаардлагууд болох 1.1, 2.1, 2.2, 5.1 нь төлөвлөгөөний туршид хэрэгжих шаардлагатай байдаг бол, 3.1, 4.1 нь төлөвлөгөөг шинэчлэх үйл явцад хамаарах бөгөөд ХБТМ-аар тусгайлан үнэлэгдэнэ.

Стандарт 3

Үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх явцад олон нийтэд хүртээмжтэй, мэдээлэлд суурилсан оролцох боломжийг бүрдүүлэх.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 3.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх үйл явц эхлэхээс дор хаяж хоёр долоо хоногийн өмнө НЗТ-ийн цахим хуудсанд шинэчлэх хуваарь, оролцогч талуудад зориулсан оролцох боломжийн тухай тоймыг нийтэлсэн байна.

ХБТМ үнэлгээ

ХБТМ нь дараах хоёр гол шалгуурыг үндэслэн үнэлгээ хийнэ:

- Оролцох боломжийн тухай хамтран бүтээх үйл явцын хуваарь нийтэд нээлттэй байсан уу?
- Энэ мэдээлэл төлөвлөгөөг шинэчлэх үйл явц эхлэхээс дор хаяж хоёр долоо хоногийн өмнө нийтлэгдсэн үү?

ХБТМ-ын удирдамжийг **энд дарж** үзнэ үү.

Стандарт 4

Үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх явцад төр болон төрийн бус оролцогч талуудын хооронд байнгын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх орон зайг бий болгож, саналд үндэслэлтэй хариу өгөх.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 4.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх явцад оролцогч талуудын гаргасан санал, санаачлагыг хэрхэн харгалзан үзсэн талаарх бичгэн тайлбар, хариуг баримтжуулах, тайлагнах эсвэл нээлттэй нийтлэх ёстой.

ХБТМ үнэлгээ

ХБТМ нь дараах хоёр үндсэн шалгуурыг хянан үнэлнэ:

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

- Оролцогч талуудын гаргасан саналуудыг баримтжуулсан уу?
- ҮЗ эсвэл Засгийн газар тухайн саналын талаар үндэслэлтэй хариу өгсөн үү мөн энэ нь төлөвлөгөөг шинэчлэх үйл явцын хугацаанд хийгдсэн үү?

ХБТМ-ын удирдамжийг **энд дарж** үзнэ үү.

Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үйл явцын тухай Санамж бичиг нь төлөвлөгөөг шинэчлэх үйл явцад зориулсан тодорхой удирдамж, хугацааны хуваарь болон үндсэн алхмуудыг тусгасан байдаг.

Явцын үнэлгээ: Үндэсний зөвлөл (ҮЗ) нь төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад гарсан ахиц дэвшил, дутагдал, сорилт, гацаа мөн төлөвлөгөөний амжилтад нөлөөлж буй нөхцөл байдлыг тодорхойлсон дүгнэлт гаргана.

Сурталчилгаа ба мэдээлэл түгээх: ҮЗ нь үнэлгээний дүнг олон нийтэд мэдээлж, санал хүсэлт өгөх боломжийг оролцогч талуудад олгоно. Оролцогч талууд үнэлгээнд санал өгөх, үүрэг амлалтыг өөрчлөх санал гаргах, хэрэгжилтийг сайжруулах, дутагдлыг нөхөх, шинэ үүрэг амлалт санал болгох боломжтой.

Шинэчлэл хийх: Цугларсан санал хүсэлтэд үндэслэн ҮЗ нь оролцогч талууд болон шинжээчидтэй зөвлөлдөж, хэлэлцэсний үндсэн дээр үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна. Шинэчлэлд одоогийн үүрэг амлалтыг өөрчлөх (жишээлбэл, шинэ үйл ажиллагаа эсвэл зорилтот үр дүн нэмэх), шинэ үүрэг амлалт нэмэх зэрэг өөрчлөлтүүд хамаарна. Саналд хариу өгөх: ҮЗ нь оролцогч талуудын саналыг хэрхэн авч үзсэн талаарх үндэслэл бүхий хариуг нийтэлж, шинэчилсэн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй хамт олон нийтэд хүргэнэ. Энэ нь санал санаачлагыг хэрхэн тусгасан талаар ил тод байдлыг хангадаг.

Хүргүүлэх: Шинэчилсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг анхны төлөвлөгөөний хоёр жилийн хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор НЗТ-ийн Дэмжих нэгжид хүргүүлэх ёстой. Төлөвлөгөөнд шинэчлэх үйл явц, хийгдсэн бүх өөрчлөлт, нэмэлтийг тодорхой тусгасан байна.

Нэмэлт шаардлага:

- Шинэчлэх үйл явцын үе шат, оролцох боломжийн тухай багтаасан хуваарийг боловсруулж эхлэхээс дор хаяж хоёр долоо хоногийн өмнө олон нийтэд нийтэлсэн байх ёстой.
- Олон нийтийн зөвлөлдөх уулзалтын үр дүнг оролцогч талуудтай хуваалцаж, тэдний оруулсан санал санаачилга мөн тэдгээр нь шинэчлэлийн үйл явцад хэрхэн тусгасан талаарх мэдээллийг тоймлон хүргэх шаардлагатай.

ХБТМ-ын үнэлгээ буюу Төлөвлөгөөг шинэчлэх үйл явц ба шинэчилсэн төлөвлөгөө

ХБТМ нь дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж буй гишүүн орнуудад “дунд хугацааны үнэлгээ”-г гаргаж өгдөг. Уг үнэлгээ нь төлөвлөгөөг шинэчлэх үйл явц, шинэчилсэн болон шинээр нэмэгдсэн үүрэг амлалт, хэрэгжилтийн ерөнхий ахиц дэвшлийг хамардаг.

Дөрвөн жилийн шинэчлэлийн үйл явцын ХБТМ үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **ХБТМ-ын албан ёсны хуудаснаас** авна уу.

6.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалт боловсруулах

Энэ хэсэгт өмнө нь танилцуулсан НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандарт болон дүрэм, журмыг бодитой хэрэгжүүлэхэд зориулсан албан ёсны болон практик зааварчилгаа багтсан болно. Энэхүү удирдамж нь НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг амлалтыг

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

хүсэл зорилготой, ач холбогдолтой, үр нөлөөтэй болгоход чиглэнэ. Тухайлбал хамтран бүтээх үйл явцыг төлөвлөх, оролцогч талуудыг татан оролцуулах, санал хүсэлт авах, хариу өгөх үйл явц зэрэг гол үе шатуудыг хамарна. Мөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ямар мэдээллийг тусгах, ямар шилдэг туршлагад үндэслэх, үүрэг амлалтыг ямар бүтэцтэй, хир тодорхой, үр дүнтэй төлөвлөхөд ашиглаж болох НЗТ-ийн үүрэг амлалтыг тодорхойлох загвар маягтын талаар тайлбарлана. Энэ загвар нь үүрэг амлалтын оновчтой бүтцийг төлөвлөгөөний хугацаатай уялдуулахад тусалдаг байна.

6.3.1 Гол мөчүүд

Үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг амлалтыг боловсруулах явцад хамтран бүтээх үйл явц хэд хэдэн гол үе шаттай өрнөдөг. Эдгээр үе шат заримдаа давхцаж эсвэл уялдан үргэлжилж болох ч, хамтын ажиллагаа ба бодит оролцоог хангах онцгой үүрэгтэй тусдаа үе шат юм.

- **Хамтран бүтээх үйл явцыг төлөвлөх:** Энэ шатанд зорилго тодорхойлох, оролцогч талуудыг тодорхойлох, нөөц хуваарилах, төлөвлөгөөний хугацааг гаргах зэрэг ажлууд хийгдэнэ. Энэхүү үйл явцыг ҮЗ эсвэл Засгийн газар удирдан зохион байгуулж, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан, хамтран бүтээх үйл явц хэрхэн өрнөхийг тодорхойлно. НЗТ-ийн гол шаардлага болох хамтран бүтээх үйл явцын хуваарь олон нийтэд ил тод байх мөн нээлттэй цахим хуудаст байршуулах ёстой.
- **Оролцогч талууд руу чиглэсэн идэвхжүүлэлт ба оролцоог хангах:** ҮЗ эсвэл Засгийн газар нь нээлттэй засаг, НЗТ-ийн үйл явц, оролцох боломжийн талаар мэдлэг түгээж, олон талын оролцогчдыг идэвхтэй оролцуулахын тулд мэдээлэл түгээх болон санал цуглуулах механизмыг ашигладаг. Үр дүнтэй оролцоо нь тэгш хүртээмж, олон янзын дуу хоолойг төлөөлж, яриа хэлэлцээрээр дамжуулан бүх үйл явцын чанарт нөлөөлнө. Зохион байгуулалттай, төлөвлөлттэй хэлэлцүүлгийн арга нь бодит оролцоог хангах чухал хэрэгсэл болдог.
- **Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах:** Энэ үе шатанд оролцогч талуудын санал санаачилгыг тодорхой, хэрэгжихүйц үүрэг амлалт болгон хувиргах ажил хийгдэнэ. Засгийн газар болон иргэний нийгэм нь сорилтыг тодорхойлох, шийдэл санал болгох, НЗТ-ийн загвар маягтыг ашиглан үүрэг амлалтыг төсөл болгон боловсруулах зэрэг ажлыг хамтран хийнэ. Энэ шатанд ил тод байдал буюу олон нийтэд нээлттэй баримтын санг ажиллуулах, хариуцлага буюу санал өгсөн оролцогч талуудад хариу өгч, яагаад тус санал төлөвлөгөөнд орсон эсвэл ороогүйг тайлбарлах зарчмуудад анхаарна.
- **Санал хүсэлт болон үндэслэлтэй хариу өгөх үе шат:** Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахын өмнөх буюу эцсийн шатанд ҮЗ эсвэл Засгийн газар нь оролцогч талуудад санал хүсэлтийн хариуг хүргэх, тэдний гаргасан саналыг хэрхэн харгалзан үзсэн мөн үүрэг амлалтад хэрхэн нөлөөлсөн талаар тайлбарлан мэдээлнэ. Тодорхой, ойлгомжтой хариу өгснөөр итгэлцлийг бий болгох, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй.

Үндэсний болон орон нутгийн түвшний НЗТ-ийн гишүүн орны хамтран бүтээх туршлагад үндэслэн, НЗТ нь гишүүн орон болон оролцогч талуудад зориулсан практик зөвлөмж бүхий удирдамжийг нэгтгэн боловсруулсан байна. Дээр дурдсан бүх үе шатыг нарийвчлан тайлбарласан дэлгэрэнгүй удирдамжийг **“Хамтран бүтээх үйл явц ба Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах”** хэсгээс үзнэ үү.

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах



Үйл явцыг төлөвлөх

Хамтран бүтээх үйл явцыг эхлүүлэхийн өмнө анхаарах гол асуудал буюу төлөвлөгөөг хэрхэн боловсруулахыг тодорхойлох үе шат юм.



Оролцогч талууд руу чиглэсэн идэвхжүүлэлт ба оролцоо

Оролцогч талуудад НЗТ-ийн тухай, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явц, хэрхэн оролцох тухай мэдээлэл хүргэнэ. Мөн тэдний зүгээс ямар асуудлыг уг төлөвлөгөөгөөр шийдвэрлэхийг хүсэж байгааг тодорхойлох зорилгоор мэдээлэл цуглуулах үе шат юм.



Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Цуглуулсан мэдээлэл, саналд үндэслэн асуудлыг тодорхойлох, шийдлийг боловсруулах, асуудлаас шийдэл рүү шилжих замыг тодорхойлох, эцэст нь үүрэг амлалтыг төсөл хэлбэрээр боловсруулах үе шат юм.



Санал хүсэлт ба хариу өгөх

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явцын оролцогч талуудад өөрсдийн оролцооны үр дүн, гаргасан саналыг хэрхэн тусгасан тухай мэдээллийг хүргэнэ.

Мэдэхэд илүүдэхгүй

Хамтран бүтээх үйл явцыг үр дүнтэй зохион байгуулах стратегийн төлөвлөлт



Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагааг урьдчилан төлөвлөх нь маш чухал. Ингэснээр үйл явцын зорилго, оролцогч талууд болон тэдний үүрэг, боломжит нөөцийг тус тус тодорхойлох юм. Мөн үйл явцыг хэзээ, хэрхэн дуусгахыг харуулсан цаг хугацааны төлөвлөгөөг гаргана.

“Хамтран бүтээх үйл явц ба Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” удирдамжаас дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

6.3.2 Үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь Засгийн газрын үүрэг амлалт болон тэдгээрийг хэрхэн боловсруулсан үйл явцыг тодорхойлдог баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөө нь үндэсний болон орон нутгийн нөхцөл байдлыг тайлбарлах, өмнөх хүчин чармайлтуудыг эргэн харах, оролцогч талуудтай хамтран ажилласан байдлыг тодорхойлох, гол шинэчлэлийн чиглэлийг тодорхойлох зэрэг агуулгыг багтаадаг. Доорх тайлбар нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд ямар мэдээллийг багтаах, үүрэг амлалтыг боловсруулж танилцуулахаас өмнөх агуулгыг нарийвчлан боловсруулахад туслах асуултыг агуулсан болно.

Танилцуулга

Энэ хэсэгт тухайн улсын үндэсний болон орон нутгийн нөхцөл байдлыг товч тайлбарлаж, яагаад нээлттэй засгийн үйл ажиллагаа тухайн улсад чухал болохыг тодорхойлно. Мөн улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр зорьж буй шинэчлэлийн тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр шийдвэрлэхийг зорьж буй нийгэм, улс төр, эдийн засгийн гол асуудал, эдгээр асуудлыг сонгосон үндэслэл, шалтгааныг тусгасан байна.

Чиглүүлэх асуулт

- Танай улсын нөхцөл байдалд тохирсон нээлттэй засгийн урт хугацааны алсын хараа юу вэ?
- Засгийн газар дунд хугацаанд нээлттэй засгийн хүрээнд ямар зорилтуудыг биелүүлэхийг хүсэж байна вэ?
- Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь эдгээр зорилтод хүрэхэд хэрхэн хувь нэмэр оруулах вэ?
- Улс орон энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан нийгэм, улс төр, эдийн засгийн ямар гол асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна вэ мөн яагаад?

Одоог хүртэлх хэрэгжүүлсэн хүчин чармайлт

Энэ хэсэгт тухайн улсын нээлттэй засгийн гол санаачилга, ололт амжилтыг товч өгүүлэл хэлбэрээр танилцуулна. Ялангуяа, иргэний нийгэмтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, эдгээр санаачилгууд нь хамтран боловсруулсан үүрэг амлалттай хэрхэн уялдаж байгааг тайлбарлана. Шинэ төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөн дээр ямар байдлаар суурилж, нээлттэй засгийн шинэчлэлийг цаашид хэрхэн гүнзгийрүүлж байгааг тайлбарлана.

Чиглүүлэх асуулт

- Танай улс өнөөг хүртэл нээлттэй засгийн ямар гол амжилт, шинэчлэлийг хэрэгжүүлсэн бэ? (сүүлийн үеийн шинэчлэлийн жишээ)
- Засгийн газар болон иргэний нийгмийн хамтын ажиллагаа эдгээр шинэчлэлд ямар нөлөө үзүүлсэн бэ?
- Хэрэв өмнө нь үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан бол ямар шинэчлэлийг хэрэгжүүлсэн, ямар шинэчлэлийг биелүүлж чадаагүй, яагаад хэрэгжээгүй вэ?
- Шинэ үйл ажиллагааны төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөнд хүрсэн үр дүнд хэрхэн суурилж байгаа вэ? Нээлттэй засгийн шинэчлэлийг бэхжүүлэх бусад хүчин чармайлттай хэрхэн уялдаж байгаа вэ?

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явц

Энэ хэсэг нь үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн боловсруулсан тухай үйл явцыг тайлбарлах бөгөөд Засгийн газар нь иргэний нийгэм болон бусад оролцогч талуудтай хэрхэн хамтран ажиллаж төлөвлөгөөг боловсруулсан, хэлэлцсэн, эцэслэн баталсан талаар онцолж бичнэ. Мөн ҮЗ эсвэл Засгийн газар үйл явцыг хэрхэн төлөвлөсөн, ямар бүтэц зохион байгуулалттайгаар хэрэгжүүлсэн, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд хэрхэн сурталчилсан, үүрэг амлалтыг хэрхэн боловсруулсан, оролцогч талуудын өгсөн саналд хэрхэн үндэслэлтэй хариу өгсөн тухай тусгах шаардлагатай. Мөн НЗТ-д оролцох ба хамтран бүтээх стандартыг баримталсныг тодорхой дурдан, ялангуяа заавал биелүүлэх оролцооны шаардлагыг хангасан эсэхийг онцлон тэмдэглэх шаардлагатай. Дэлгэрэнгүй мэдээллийг **“НЗТ-д оролцох болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах удирдамж”** хэсгээс үзнэ үү.

Чиглүүлэх асуулт

- Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах хуваарийг хэрхэн боловсруулсан бэ? Үүнд хэн оролцсон, оролцогч талуудын санал хэрхэн туссан бэ?
- Оролцоог нэмэгдүүлэх сурталчилгааны арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан бэ? Олон нийтийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэхэд ямар арга замыг ашигласан бэ?
- Төлөвлөгөөг хамтран боловсруулахад Засгийн газар болон иргэний нийгмийн хамтран ажиллах орон зайг хэрхэн ашигласан эсвэл шинээр бий болгосон бэ? Төлөвлөгөөг боловсруулах үйл явц хэрхэн өрнөсөн бэ? Асуудлыг тодорхойлох, утга агуулга тогтох, шийдэл гаргах, үүрэг амлалтыг боловсруулах үе шатууд хэрхэн өрнөсөн бэ?
- Үндэслэлтэй хариуг яаж өгсөн бэ? Төлөвлөгөөг эцэслэхийн тулд ямар явц, алхам хийгдсэн бэ?

Үүрэг амлалт

Энэ хэсэгт үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах явцад хамтран боловсруулсан тодорхой үүрэг амлалтыг танилцуулна. Төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалт бүрт зориулан “Үүрэг амлалтыг тодорхойлох загвар маягт”-ыг ашиглана.

Чиглүүлэх асуулт

- “Үүрэг амлалтыг тодорхойлох загвар маягт” хэсгээс асуултыг **татаж авна уу**.

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

НЗТ-ийн туршлагаас харахад амжилттай үйл ажиллагааны төлөвлөгөө нь:

- Засгийн газрын одоогийн түвшнээс давсан, хүсэл зорилготой шинэчлэлийг дэмждэг үүрэг амлалт нь нээлттэй засгийн гол чиглэлд хамаарч бодлогын өөрчлөлт, институцийн шинэчлэлийг хуульчилан тогтворжуулах зорилготой байдаг. Энэ нь аливаа бодлого, төрийн байгууллага эсвэл иргэн ба төр хоорондын харилцаанд шинэлэг, тогтмол өөрчлөлт хийх боломжтой үүрэг амлалт байж болно.

ХБТМ нь үүрэг амлалтын хүсэл зорилготой байдлыг үр дүнд хүрэх боломжоор үнэлдэг (Дэлгэрэнгүй мэдээллийг “ХБТМ-ын зайлшгүй биелүүлэх шаардлагын үнэлгээ” хэсгээс үзнэ үү).

- Нээлттэй засгийн зарчимтай нийцүүлэн үүрэг амлалтыг уялдуулах: Үүрэг амлалт бүр нь тодорхой бодлого, байгууллага эсвэл шийдвэр гаргах үйл явцыг илүү ил тод, оролцоотой, хариуцлагатай болгоход чиглэсэн байх ёстой. Үүрэг амлалт бүр дор хаяж дараах гурван зарчмын аль нэгийг ахиулсан байх шаардлагатай.
 - Ил тод байдал:** Ил тод байдалд чиглэсэн үүрэг амлалт нь Засгийн газрын мэдээллийг идэвхтэй болгох, хариу арга хэмжээг ил болгох, мэдээлэл авах эрхийн тухай эрх зүйн болон институцийн орчинг сайжруулах, олон нийтэд хүрч буй мэдээллийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн шийдвэр гаргалт болон байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэхийг зорьдог.
 - Иргэдийн оролцоо:** Оролцооны үүрэг амлалт нь олон нийтийн зүгээс төрийн бодлого, хууль тогтоомж, шийдвэрт нөлөөлөх, мэдээлэл өгөх, хамтран боловсруулах боломжийг нэмэгдүүлэх, цөөнх, гадуурхагдсан болон төлөөлөл багатай бүлгийн оролцоог дэмжих механизмыг бий болгох эсвэл сайжруулах, иргэний нийгмийн оролцоог дэмжих эрх зүйн, бодлогын, институцийн болон практик нөхцлийг бүрдүүлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсах эрхийн хамгаалалтыг хангах, ялангуяа цахим орчин дахь хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээ авч, олон нийтийг бодит, найдвартай мэдээллээр хангах арга замыг бий болгодог.
 - Төрийн эгэх хариуцлага:** Эгэх хариуцлагын үүрэг амлалт нь Засгийн газрын албан тушаалтныг тайлагнах боломжийг нэмэгдүүлдэг, хуулийн, бодлогын эсвэл институцийн хүрээнд эгэх хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлдэг, энэ төрлийн механизм нь зөвхөн дотоод хяналт биш, олон нийтийн оролцоог хангах ёстой юм.

ХБТМ нь үүрэг амлалтыг нээлттэй засгийн зарчимд нийцэж байгаа эсэхийг өөрийн “Нээлттэй засгийн үзэл баримтлалын шалгуур” үзүүлэлтээр үнэлдэг (ХБТМ-ын үзүүлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг “ХБТМ-ын үйл явцын тухай гарын авлага” хэсгээс харна уу).

- “SMART” шалгуур хангасан үүрэг амлалтыг батлах.
 - Тодорхой: Хөндөж буй асуудлыг тодорхой зааж, хийх гэж буй үйл ажиллагаа болон хүлээгдэж буй үр дүнг ойлгомжтойгоор тайлбарласан байна.
 - Хэмжигдэхүйц: Үүрэг амлалт нь зорилтот үр дүн болон үйл явцын үе шатыг тодорхойлсон, эдгээр нь бодитоор хэмжигдэж, баталгаажих боломжтой байх ёстой. Хэрэв үүрэг амлалт хэд хэдэн дэд бүрэлдэхүүнтэй бол тус бүр нь хэмжиж болохуйц зорилтот үзүүлэлттэй байх шаардлагатай.
 - Хариуцлагатай: Гол хэрэгжүүлэгч байгууллага, хамтран ажиллах эсвэл дэмжих байгууллага (жишээлбэл: иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллага)-г тодорхой заасан байна.
 - Хамааралтай: Үүрэг амлалт нь НЗТ-ийн үндсэн зарчмууд болох ил тод байдал, хариуцлага, иргэдийн оролцоотой хэрхэн уялдаж байгааг тайлбарласан байна.
 - Хугацаатай: Үүрэг амлалт нь тодорхой дуусах хугацаатай, хэрэгжилтийг хянах үе шатанд зорилтот үзүүлэлт болон шалгуур үзүүлэлтийг агуулсан байна.

*ХБТМ нь үүрэг амлалтад туссан зорилго болон санал болгосон үйл ажиллагаа нь тодорхой эсэх, хэрэгжилтийг бодитоор баталгаажуулах боломжтой эсэхийг “Шалгаж баталгаажуулах” тусгай шалгуураар үнэлдэг (Дэлгэрэнгүй мэдээллийг “**Заавал биелүүлэх шаардлагын ХБТМ үнэлгээ**” хэсгээс үзнэ үү).*

- Чухал үүрэг амлалтыг тэргүүнд тавих: Олон сэдвийг хамарсан, 5–15 тооны, чанартай, хүсэл зорилготой үүрэг амлалтаас бүрдсэн үйл ажиллагааны төлөвлөгөө нь олон, сул, амлалт багатай төлөвлөгөөнөөс хамаагүй илүү үр дүнтэй байдаг. Иймд тоо бус чанарт суурилсан, бодлогын өөрчлөлтөд хүргэхүйц үүрэг амлалтыг түлхүү багтаахыг НЗТ уриалж байна.

6.3.3 Үүрэг амлалтын загвар

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалт бүр нь НЗТ-ийн үүрэг амлалтыг тодорхойлох загвар маягтыг дагах ёстой. Энэхүү загвар нь үүрэг амлалт тус бүрийг тодорхой, иж бүрэн бүтэцтэйгээр илэрхийлэх боломжийг олгож, улсын хэмжээнд нээлттэй засгийн нийтлэг зорилтуудтай үүрэг амлалт хэрхэн уялдаж байгааг ойлгоход тусалдаг.

- Үүрэг амлалтыг тодорхойлох загвар маягт нь дараах үндсэн хэсгээс бүрдэнэ: Асуудлыг тодорхойлох: Энэ хэсэгт үүрэг амлалт нь ямар асуудлыг шийдвэрлэх зорилготой болохыг тодорхой тайлбарлана. Үүнд хэн нөлөөлөлд өртөж байгаа, асуудал хаана гарч байгаа, ямар байдлаар нөлөөлж байгаа, хэзээ хамгийн хүчтэй нөлөөлдөг, асуудал хэзээ эхэлсэн, хэдий хугацаанд үргэлжилсэн, гол болон үндсэн шалтгаан юу байгааг багтаана. Шаардлагатай тохиолдолд аналитик арга хэрэгсэл ашиглан дүн шинжилгээ хийх боломжтой.
- Үүрэг амлалтын тодорхойлолт: Энэ хэсэгт асуудлыг шийдэхийн тулд өмнө нь хийсэн ажлууд болон тэдгээрийн амжилтыг дурдана. Дараа нь шинээр санал болгож буй шийдэл, өмнөх оролдлогоос юугаараа ялгаатай болох, энэхүү үүрэг амлалт нь асуудлыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэрхэн шийдвэрлэх талаар тайлбарлана. Мөн үүрэг амлалт хэрэгжсэнээр гарах үр дүн, мэдлэг, ур чадвар, чадавхи, зан төлөв, систем болон практикт гарах өөрчлөлтийг тайлбарлана.
- Үүрэг амлалтад дүн шинжилгээ хийх: Энэ хэсэгт үүрэг амлалт нь ил тод байдлыг хэрхэн дэмжих, төрийн эгэх хариуцлагыг хэрхэн нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог хэрхэн сайжруулах тухай хариулна.
- Үүрэг амлалтыг төлөвлөх: Энэ хэсэгт хүрэх үе шат, хүлээгдэж буй үр дүн, гол оролцогч талуудын тухай агуулгыг тусгана. Хүрэх үе шат нь үүрэг амлалтаар хүрэхээр зорьж буй үр дүнд хүргэх үйл ажиллагаа эсвэл үйл явдлын дарааллыг илэрхийлнэ. Хүлээгдэж буй үр дүн нь хийгдсэн үйл ажиллагааны шууд үр дүн, бодитоор баталгаажих боломжтой, хэмжигдэхүйц үзүүлэлтийг агуулна. Мөн үүрэг амлалтын дуусах төлөвлөгөөт хугацаа, хэрэгжүүлэх гол байгууллага, дэмжигч байгууллага, оролцогч талуудыг заавал тусгах ёстой.
- Нээлттэй засгийн сорилттой уялдаатай байдал (сонголтоор): Хэрэв үүрэг амлалт нь Нээлттэй засгийн сорилтын шаардлагыг хангаж байвал үүнийг сорилтод оролцох үүрэг амлалтаар нэр дэвшүүлж болох бөгөөд үүнийг өөрийн сонголтоор хийнэ. Сорилтод нэр дэвших үүрэг амлалт нь тогтсон **10 сорилтын чиглэл**ийн аль нэгтэй уялдсан байх шаардлагатай. Эцсийн шийдвэрийг НЗТ гаргаж, **дөрвөн шалгуураар** үнэлэн, үүрэг амлалтыг сорилтод хамруулах эсэхийг шийднэ. Жич: Сорилтод хамрах үүрэг амлалтыг үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс тусдаа оруулж болно. Дэлгэрэнгүй мэдээллийг “**Нээлттэй засгийн сорилтоор үүрэг амлалтаа өргөжүүлэх**” хэсгээс үзнэ үү.

Үүрэг амлалтыг тодорхойлох стандарт загвар маягтыг **татаж авах** боломжтой. Энэхүү загвар

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

нь санаа боловсруулах шатанд бус, харин төлөвлөлтийн илүү ахисан шатанд ашиглахад зориулсан. Загварыг дараах нөхцөлд үр дүнтэй ашиглаж болно:

- Асуудлыг тодорхойлж бүрэн ойлгосон үед
- Боломжит шийдлийг сайтар хэлэлцэн үнэлж, эрэмбэлсэн үед
- Үүрэг амлалт ямар хэлбэртэй байх нь тодорхой, улмаар зорилго, хүрэх үе шат, өөрчлөлтийн онолыг төлөвлөх боломжтой болсон үед.

Мэдэхэд илүүдэхгүй

Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зөвлөмж



Үүрэг амлалтыг тодорхойлох загвараас гадна, үйл ажиллагааны төлөвлөгөө нь танилцуулга, одоог хүртэлх Засгийн газрын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шинэчлэлийн тайлбар, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн боловсруулсан тухай дэлгэрэнгүй тайлбар зэргийг заавал агуулсан байх шаардлагатай. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Хамтран бүтээх үйл явц ба Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” удирдамжаас үзнэ үү.



7 Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалтыг хэрэгжүүлэх

Гол зөвлөмж

- НЗТ-ийн гишүүн орон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Стандарт 5-г дагаж, түүнтэй холбоотой зайлшгүй шаардлагыг биелүүлэх ёстой. Хэрэгжилтийн үеийн оролцогч талуудын оролцоо нь Засгийн газар болон хамтран хэрэгжүүлэгч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэхэд тусалдаг бөгөөд энэ нь үүрэг амлалтыг бүрэн хэрэгжүүлэх хэмжээг нэмэгдүүлж, илүү үр дүнд хүргэдэг.
- Иргэний нийгмийн байгууллага нь хэрэгжилтийн явцыг хянах, санал, шүүмж хүргүүлэх, талуудтай хамтран ажиллах зэргээр чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Талуудын идэвхтэй оролцоог хангаж, Стандарт 5-г хэрэгжүүлэхийн тулд хэрэгжилтийн төлөвлөлт хийх, оролцогч талууд ямар хувь нэмэр оруулах боломжтойг ойлгох, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг хүчин зүйлс чухал юм.



Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Сайн бүтэцтэй, хүртээмжтэй үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явц нь үүрэг амлалтын үр дүнтэй хэрэгжүүлэх суурь үндсийг тавьдаг. Үүрэг амлалт нь үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтаж батлагдсан эсвэл бие даасан үүрэг амлалтын хэлбэрээр (жишээлбэл: бусад түвшинд бүх салбарын оролцоотой) батлагдсан үед үйл явц нь төлөвлөлтөөс хэрэгжилт рүү шилжинэ ("[Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах болон Үүрэг амлалт боловсруулах](#)", "[Бусад түвшинд бүх салбарын оролцоо](#)") хэсгээс үзнэ үү).

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад гишүүн орон НЗТ-ийн оролцоо ба хамтран бүтээх Стандарт 5-г хангахыг хичээх ёстой. Энэ нь хэрэгжилтийн явцад бодит, утга бүхий оролцоог хангахад чухал нөлөөтэй.

Стандарт 4

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хяналтын явцад хүртээмжтэй, мэдээлэлтэй оролцооны боломжоор хангах.

Зайлшгүй биелүүлэх шаардлага 5.1

Үндэсний зөвлөл (ҮЗ) байгуулсан бол ҮЗ, байгуулаагүй бол Засгийн газар жил бүр дор хаяж хоёр удаа иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг танилцуулах, иргэний нийгмийн зүгээс санал, сэтгэгдэл авах боломжоор хангах үйл ажиллагааг гүйцэтгэх ёстой.

ХБТМ үнэлгээ

ХБТМ дараах хоёр гол үзүүлэлтийг шалгаж үнэлнэ:

- Үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжих явцад Засгийн газар нь иргэний нийгмийн оролцогчидтой уулзалт зохион байгуулсан уу эсвэл ҮЗ тогтмол хуралдсан уу?
- Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг танилцуулсан уу мөн иргэний нийгмийн төлөөллийг санал өгөх боломжоор хангасан уу?

ХБТМ-ын удирдамжийг [эндээс](#) үзнэ үү.

7.1 Оролцоог тогтворжуулах

Хэрэгжилт бол үргэлжилсэн, тасралтгүй үйл явц бөгөөд оролцогч бүх талуудын тогтвортой оролцоо, хяналт-шинжилгээ хийх идэвхтэй үйл ажиллагаа, хэрэгцээ гарвал хандлагаа өөрчлөх уян хатан байдлыг шаарддаг. Тогтмол оролцоо нь оролцогч талуудыг Засгийн газар болон хэрэгжүүлэгч байгууллагуудыг хариуцлагатай байх, зорилт, нөхцөл байдал өөрчлөгдөх үед залруулга хийх боломжийг бүрдүүлдэг. ХБТМ тайлан болон [НЗТ-ийн арван жилийн тайлангаас](#) үзэхэд хэрэгжилтийн явцад оролцогч талуудын оролцоо үргэлжилсэн тохиолдолд үүрэг амлалт биелэх түвшин өндөр, үр дүн илүү хүчтэй байдаг нь батлагдсан.

Амжилттай хэрэгжилтэд Засгийн газрын дотоод зохицуулалт сайтар хангагдсан байх, иргэний нийгэмтэй тогтвортой хамтын ажиллагаа үргэлжилж байх зэрэг хүчин зүйлс чухал байдаг. Засгийн газар нь байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, хэрэгжилтэд шаардлагатай нөөцийг хуваарилах, нээлттэй, ил тод харилцааг хадгалах, үүрэг амлалтыг байгууллагын үйл ажиллагаанд шингээх хэрэгтэй. Жишээлбэл, жилд дор хаяж нэг удаа сайд, дээд албан тушаалтнууд оролцсон уулзалт хийж, хэрэгжилтийн явцын үнэлгээ, саатал, сорилтод хариу өгөх хэлэлцүүлэг зохион байгуулах нь улс төрийн дэмжлэгийг хадгалахад чухал нөлөөтэй. ҮЗ эсвэл Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэ нөхцөл байдалд нийцүүлэн хариу үзүүлэх боломжтой. Гол нь тухайн үүрэг амлалтад багтсан хүрэх үе

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх

шат, зорилт нь төлөвлөгөө дуусах хугацаанаас өмнө биелэх шаардлагатай (Дэлгэрэнгүй мэдээллийг “[Нэмэлт, өөрчлөлт](#)” хэсгээс үзнэ үү).

Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) нь хэрэгжилтийн явцыг хянах, санал, шүүмж, зөвлөмж хүргүүлэх, хамтран хэрэгжүүлэгч талуудтай нягт хамтран ажиллах чиглэлд түлхүүр үүргийг гүйцэтгэдэг, ИНБ нь зөвхөн ажиглагч бус, бодитой хамтран оролцогч байх боломжтой бөгөөд тайлагналын үйл явцад хувь нэмэр оруулах, үүрэг амлалтыг боловсруулах үе шатанд байгуулсан сэдэвчилсэн ажлын хэсгүүдэд оролцон хэрэгжилтэд идэвхтэй оролцох боломжтой (Стандарт 3-г үзнэ үү).

Мэдэхэд илүүдэхгүй

НЗТ-ийн Дэмжих нэгжийн үүрэг



НЗТ-ийн Дэмжих нэгж нь бусад гишүүн орнуудтай хамтын ажиллагааг дэмжих, дотоодын оролцогч талуудыг ижил нөхцөлтэй улс орнууд болон түншүүдтэй холбож туршлага солилцох, тогтвортой оролцоог хадгалах, техникийн зөвлөгөө, мэргэшсэн дэмжлэг үзүүлэх, олон улсын шилдэг туршлагыг хуваалцах, хэрэгжилтийн хүчин чармайлтыг сайжруулах сургалт, семинарыг зохион байгуулахад туслах чиглэлээр гишүүн орнуудыг дэмждэг.

7.2 Хэрэгжилтийг төлөвлөх

Хэрэгжилтийн төлөвлөгөө нь тодорхой үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх нөөцийг тооцоолох, хариуцах этгээдийг тогтоох зэрэгт тусалж, үүрэг амлалтыг бодит ажил болгон хэрэгжүүлэх үндэс болдог. Үйл ажиллагааны төлөвлөгөөний үүрэг амлалтыг тодорхойлох загвар нь хүрэх үе шат болон хүлээгдэж буй үр дүнг тодорхойлдог бөгөөд “юу хийх ёстой вэ?” гэдгийг гол төвд нь тавьдаг. Харин хэрхэн хэрэгжүүлэх талаар буюу тодорхой алхам, үйл ажиллагааг заадаггүй. Иймд үүрэг амлалтад заасан оролцогч талуудын хамтаар хэрэгжилтийн төлөвлөгөө боловсруулах нь итгэлцэлтэй хамтын ажиллагааг бий болгох, үүрэг амлалтыг хэрэгжүүлэх бодит суурийг бүрдүүлэхэд тусалдаг. Хэрэгжилтийн төлөвлөгөөг үүрэг амлалт тус бүрээр боловсруулж болно.

Товчхондоо хэрэгжилтийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг багтаана:

- Хийх ёстой тодорхой үйл ажиллагаа
- Шаардлагатай нөөц, төсөв, хүний хүчин чадал
- Хугацаа, хуваарь, дуусах хугацаа
- Хүлээгдэж буй үр дүн
- Хариуцагч этгээд (хувь хүн, яам, агентлаг, бүлэг гэх мэт)
- Эрсдэл болон тэдгээрийг удирдах стратеги.

7.3 Хэрэгжилт дэх оролцогч талуудын үүрэг

Гол хэрэгжүүлэгч байгууллагуудыг хэрэгжилтийн явцад иргэний нийгэм зэрэг бусад оролцогч талууд дэмжих боломжтой. Сайн туршлагаас харахад ҮЗ нь нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, бусад оролцогч талуудтай тогтмол харилцаа холбоотой ажиллах нь үр дүнтэй байдаг. Эдгээр уулзалтаар хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэгжилтийн явцын шинэ мэдээлэл өгөх, иргэний нийгэм болон бусад оролцогчдын санал, асуултад хариу өгөх боломжтой болдог. Нэмэлт оролцогч талууд дараах байдлаар хэрэгжилтэд хувь нэмэр оруулж болно:

- Харилцаа холбоо, мэдээлэл түгээх: Шинэ буюу өөрчлөгдсөн хууль, бодлого, хөтөлбөр, үйлчилгээний талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх.
- Мэргэшсэн зөвлөгөө, дэмжлэг: Бодлого хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа, зөвлөгөө өгөх.
- Үйлчилгээний хэрэгжилт, хамтран бүтээх: Засгийн газартай хамтран бодлого хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх.
- Хэрэглэгчийн оролцоо ба санал авах: Хүлээн авагч иргэдийг шинэ бодлого, хөтөлбөр, үйлчилгээ ашиглахад дэмжих, тэдний санал хүсэлтийг хариуцсан байгууллагад хүргэх замаар хэрэгжилтийг сайжруулахад оролцох.

7.4 Хяналт, үнэлгээ

Хэрэгжилтийн хяналт, үнэлгээ хийх нь үүрэг амлалт тус бүрийн түвшинд явагдах ёстой бөгөөд харилцан яриа, хамтын ажиллагааны боломжийг багтаасан байх хэрэгтэй. Сэдэвчилсэн ажлын хэсгүүд нь тодорхой сэдэв, чиглэлээр оролцогч талуудыг хамруулан төлөвлөсөн үйл ажиллагаанд хяналт тавихад чухал үүрэгтэй. Тогтмол хугацаанд оролцогч талууд уулзаж, үүрэг амлалтын хэрэгжилтийн явцыг шалгах, сорилт, хүндрэлийг шийдвэрлэх, төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлт оруулах талаар хэлэлцэх хэрэгтэй. Эдгээр уулзалтаар хэрэгжүүлэгч байгууллагууд хүрэх үе шатны ахиц дэвшлийг тайлагнах, иргэний нийгэм болон бусад оролцогч талууд дараах байдлаар хувь нэмэр оруулж болно:

- Санал, шүүмж гаргах
- Эрсдэл, сорилтын талаар анхааруулга өгөх
- Хариуцлагыг дэмжих
- Цаашдын шийдлийн талаар хэлэлцэх.

Зөвхөн үүрэг амлалтыг хянахаас гадна, нийт үйл ажиллагааны төлөвлөгөө буюу стратегийг тодорхой хугацаанд нийтэд нь үнэлэх хэрэгтэй. Эдгээр үнэлгээ нь дараах боломжийг олгодог:

- Үүрэг амлалтын хэрэгжилтийг нийгмийн бүх талууд хамтдаа эргэн харж, дүгнэх
- Хүрсэн үр дүнг баталгаажуулах
- Хоцрогдол, доголдол гарсан тохиолдолд залруулга хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Зайлшгүй биелүүлэх шаардлага болох баримтын санг хөтлөх шаардлагыг хангахын зэрэгцээ, хэрэгжилтийн явц, саатал, бусад чухал өөрчлөлтийн талаар нийтэд нээлттэй самбарыг байршуулах, байнга шинэчлэх байдлаар хяналт, үнэлгээг илүү системтэй хийх боломжтой.

7.4.1 Өөрийн үнэлгээний тайлан

НЗТ-ийн гишүүн Засгийн газар үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан шинэчлэлийн үр дүнгийн эцсийн тайлбар, хэрэгжилтийн үеийн зөвлөлдөх уулзалт болон оролцооны үйл явц, сургамж авсан зүйлс, ирээдүйд анхаарах асуудал зэрэг агуулгыг хамарсан “Эцсийн үнэлгээний тайлан” боловсруулан гаргахыг уриалж байна. Эцсийн үнэлгээний тайлангийн загвар маягт нь “Нэмэлт материал” хэсэгт багтсаныг [эндээс](#) татан авч болно.



8

Хараат бус тайлагнах механизм (ХБТМ)-аар дамжуулан эгэх хариуцлага ба суралцах явцыг хангах нь

Гол зөвлөмж

- ХБТМ нь НЗТ-ийн хариуцлагын үндсэн хэрэгсэл бөгөөд гишүүн орны ахиц дэвшлийг хянах гол арга зам юм.
- ХБТМ нь бие даасан, нотолгоонд тулгуурласан, бодитой тайлагнал хийдэг бөгөөд НЗТ-ийн гишүүн Засгийн газрыг эгэх хариуцлагатай болгох, нээлттэй засгийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх зорилготой.
- ХБТМ нь гишүүн орнуудын хувьд Хамтран бүтээх товч тайлан, Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ, Дөрвөн жилийн төлөвлөгөөний дунд хугацааны үнэлгээ, Хэрэгжилтийн үр дүнгийн тайлан гэсэн дөрвөн төрлийн тайланг бэлтгэдэг.
- ХБТМ нь гишүүн орон Оролцоо ба хамтран бүтээх стандарт бүрийн зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлдэг.
- ХБТМ нь гишүүн орон НЗТ-ийн үйл явцын эсрэг үйлдэл хийж буй эсэхийг үнэлдэг ба энэ нь “**НЗТ-ийн журмын хяналтын бодлого**”-ын 3 шалгуурын 2-т үнэлгээ хийдэгтэй холбоотой.



НЗТ-ийн гишүүн орон бүр нь **Оролцоо ба хамтран бүтээх стандартыг** дагаж мөрдөн, зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангах, өөрийн үүрэг амлалтын хэрэгжилтэд ахиц дэвшил гаргаж буйгаа харуулах замаар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг (“**Гишүүнчлэлийн гол хариуцлага**” хэсгийг үзнэ үү). Эдгээр хариуцлагыг биелүүлж буй эсэхийг баталгаажуулахын тулд НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц нь хариуцлагын тогтолцоог агуулдаг. Энэ тогтолцооны гол хэрэгсэл нь ХБТМ юм. **ХБТМ** нь үйл ажиллагааны төлөвлөгөөний бүхий л үе шатыг хянаж, улс орны гүйцэтгэлийг үнэлэн, бодит нотолгоонд тулгуурласан тайлангаар дүн шинжилгээ, зөвлөмж өгдөг. Эдгээр тайлан нь зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангаж буй эсэх, шинэчлэлийн үүрэг амлалтын загвар, хэрэгжилт хэр зэрэг бодитой, үр дүнтэй байгаа эсэх мөн сайжруулах зөвлөмжийг тусгасан байдаг.

8.1 ХБТМ гэж юу вэ?

ХБТМ нь НЗТ-ийн хариуцлагын үндсэн хэрэгсэл бөгөөд гишүүн улс орны ахиц дэвшлийг хянах гол арга зам юм. ХБТМ нь бие даасан, нотолгоонд тулгуурласан, бодитой тайлан бэлтгэж, НЗТ-ийн гишүүн Засгийн газрыг хариуцлага хүлээлгэх, тэдний нээлттэй засгийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэхүү үүргийг ХБТМ нь үйл ажиллагааны төлөвлөгөөний мөчлөгийн гол үе шатад тайлан, үйлчилгээ, цаг үеэ олсон зөвлөмжөөр дамжуулан хэрэгжүүлдэг. ХБТМ нь НЗТ-ийн Дэмжих нэгжтэй хамтран ажилладаг ч түүнээс бүрэн бие даасан бүтэцтэй юм.

ХБТМ нь **Олон Улсын Шинжээчдийн Зөвлөл** (ОУШЗ)-д тайлагнадаг. ОУШЗ нь ХБТМ-ын хараат бус байдлыг баталгаажуулах, нийт үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж өгөх, ХБТМ-ын судалгааны арга зүйг чиглүүлэх, тайлангийн чанарыг хянах, баталгаажуулах үүрэгтэй: ОУШЗ-ийн гишүүд нь ил тод байдал, оролцоо, хариуцлагын чиглэлээр дэлхийд нэр хүндтэй мэргэжилтнүүдээс бүрдсэн бөгөөд ХБТМ-ын арга зүйн хөгжил, хэрэгжилтэд голлох үүрэгтэй. Одоогийн ОУШЗ-ийн гишүүдийн тухай болон чанарын баталгаажуулалтын хуралдааны товч мэдээллийг **эндээс** үзнэ үү.

Мэдэхэд илүүдэхгүй

НЗТ-ийг хариуцсан ажлын албаны үүрэг
ХБТМ-ын үйл явцад яагаад чухал вэ?



Үндэсний хэмжээнд ажилладаг ажлын албаны гол үүргийн нэг нь ХБТМ-тэй идэвхтэй хамтран ажиллах юм. Түүнчлэн тэд үүрэг амлалтыг хэрэгжүүлж буй байгууллагуудтай уялдаа холбоог зохицуулах голлох үүрэг гүйцэтгэдэг. ХБТМ-аас гаргадаг хоёр үндсэн тайлан болох Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ ба Хэрэгжилтийн үр дүнгийн тайланг нийтлэхээс өмнөх хувилбарт үнэлгээ, санал өгөх үйл явцыг мөн удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг “**НЗТ-ийг хариуцсан ажлын албаны үүрэг**” хэсгээс үзнэ үү.

8.2 ХБТМ хэрхэн ажилладаг вэ?

ХБТМ нь улс орны нээлттэй засгийн үйл явцыг үнэлдэг. Улс орны нээлттэй засгийн шинэчлэлийн явцыг үнэлэхийн тулд ХБТМ нь тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалт тус бүрийг нарийвчлан үнэлдэг. Мөн ХБТМ нь тухайн улсын НЗТ-д оролцож буй үйл явц нь НЗТ-ийн дүрэм, стандарттай нийцэж байгаа эсэхийг (жишээлбэл: **Оролцоо ба хамтран бүтээх стандарт**) үнэлдэг.

ХБТМ-аас гаргадаг үндсэн тайлангууд бол Хамтран бүтээх товч тайлан, Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ, Дунд хугацааны үнэлгээ – дөрвөн жилийн төлөвлөгөөтэй орнуудад, Хэрэгжилтийн үр дүнгийн тайлан юм. Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ болон Үр дүнгийн тайланг нийтлэхээс өмнөх хянах хугацаа болон олон нийтийн санал авах хугацаанд нээлттэй байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) хүлээн авна уу.

- **Хамтран бүтээх товч тайлан**

- Цаг хугацаа: Энэхүү тайлан нь шаардлагатай үед үйл ажиллагааны төлөвлөгөөний хамтран бүтээх үйл явц эхлэхээс өмнө бэлтгэгддэг. ХБТМ нь уг тайланг гаргахын тулд дор хаяж хоёр сарын өмнө урьдчилсан мэдэгдэл шаарддаг.
- Зорилго: Товч тайлан нь хамтран бүтээх үйл явц зайлшгүй биелүүлэх шаардлагыг хангах, тэгш хүртээмжтэй, үр дүнтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зөвлөмж өгдөг. Өмнөх ХБТМ тайлан, НЗТ-ийн бусад орны шилдэг туршлага мөн тухайн улсын нээлттэй засгийн нөхцөл байдалд тохирсон олон улсын харьцуулсан арга замыг тусгасан байдаг. Энэхүү товч тайлан нь тухайн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үнэлгээ өгдөггүй бөгөөд зөвхөн хамтран бүтээх үйл явц эхлэх үед тайланг хуваалцдаг байна. Товч тайлан болон загвар маягтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.

- **Үйл ажиллагааны төлөвлөгөөний үнэлгээ**

- Цаг хугацаа: Шинэ үйл ажиллагааны төлөвлөгөөг НЗТ-д хүргүүлсэн даруйд судалгаа, тайлан бэлтгэх ажил эхэлдэг.
- Зорилго: Энэхүү тайлан нь бие даасан, нотолгоонд тулгуурласан товч дүгнэлт гаргаж, төлөвлөгөөний давуу болон сул талыг илрүүлж, үүрэг амлалтын хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой. Тайлан нь хамтран бүтээх үйл явц, зайлшгүй биелүүлэх шаардлагын биелэлт зэрэгт үнэлгээ өгнө. Мөн ирээдүйтэй үүрэг амлалтыг нарийвчлан судлах зорилгоор сонгож онцолдог юм. Эдгээр үүрэг амлалтыг нээлттэй засгийн зарчимтай нийцэх байдал, баталгаажуулах боломж, хүрэх үр дүнгийн боломж, оролцогч талуудын тэргүүлэх чиглэл зэрэг шалгуураар сонгодог. Энэ тайланг үйл ажиллагааны төлөвлөгөө нийтлэгдсэний дараа хуваалцдаг. Тайлан болон загварын талаар дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.

- **Дунд хугацааны үнэлгээ (дөрвөн жилийн төлөвлөгөөтэй орнуудад)**

- Цаг хугацаа: Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй улсад шинэчлэгдсэн төлөвлөгөөг ирүүлсний дараа эсвэл шинэчлэгдээгүй тохиолдолд төлөвлөгөөний дундаж хугацаа өнгөрснөөс хойш 6 сарын дараа хийгдэнэ.
- Зорилго: Шинэчлэгдсэн үүрэг амлалт болон шинэчлэх үйл явцад үнэлгээ хийнэ. Мөн төлөвлөгөө хэрэгжиж буй хоёр дахь жилийн ерөнхий ахиц дэвшлийг тайлагнана.

Эгэх хариуцлага, суралцах үйл явц

- Үр дүнгийн тайлан
 - Цаг хугацаа: Судалгаа болон тайлан боловсруулах ажил нь үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжих хугацааны сүүлийн саруудад эхэлнэ.
 - Зорилго: Энэхүү тайлан нь үүрэг амлалтын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ гаргах, бодлогын түвшний үр дүнд төвлөрөх, шинэчлэл хэрхэн бий болсон тухай ойлголтыг гүнзгийрүүлэх зорилготой. Мөн тайлан нь НЗТ-ийн стандарт, шалгуурт нийцэж буй эсэхийг шалгаж, хариуцлагын тогтолцоо болон урт хугацааны сургамжийг дэмждэг байна. Түүнчлэн нээлттэй засгийг бий болгох үр дүнд түрүүлж хүрсэн үүрэг амлалтад онцгой анхаарал хандуулна. Энэ тайланг хэрэгжилтийн хугацаа дууссаны дараа хуваалцдаг. Тайлан болон загварын талаар дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) үзнэ үү.

Дээр дурдсан тайлангаас гадна ХБТМ дараах нэмэлт бүтээгдэхүүнийг гаргадаг:

- “Нээлттэй засгийн замнал” цувралд ХБТМ нь нээлттэй засгийн бэрхшээл, томоохон ололт амжилт, ирээдүйн чиг хандлагыг судалж, нээлттэй засгийн зарчмуудыг бодит нөхцөлд хэрхэн хэрэглэх талаарх сургамжийг хуваалцдаг. Энэ нь шинэчлэгч нарт зориулсан туршлага, суралцах боломжийн эх сурвалж болдог.
- Орон нутгийн тайлан нь НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үүрэг амлалтыг үнэлнэ. Орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн хамтын ажиллагааг мөн хянаж судалдаг. Түүнчлэн сургамжтай зүйлс, амжилттай жишээ, орон нутгийн нээлттэй засгийн шинэлэг арга барилыг тодруулдаг байна.

НЗТ-ийн цахим хуудас дахь улс тус бүрийн хуудсан дээрх “Эх сурвалж” хэсэгт тухайн улсын ХБТМ тайлангууд нийтлэгдсэн байдаг. Мөн бүх ХБТМ тайланг НЗТ-ийн “**Ерөнхий эх сурвалж**” хуудаснаас авах боломжтой.

ХБТМ нь Дэмжих нэгжийн хамтрагчидтай нийлж гишүүн улсуудад зориулсан үйлчилгээ үзүүлдэг. Үүнд тайлангийн дүгнэлтийг хэлэлцэх уулзалт, үүрэг амлалтыг төлөвлөх сургалт, семинар, ХБТМ хэрхэн НЗТ-ийн дүрэм, стандартыг үнэлдэг талаар хэлэлцэх уулзалт зэрэг орно. Эдгээр үйлчилгээ нь ХБТМ-ын зөвлөмжийг илүү үр дүнтэй ашиглахад чиглэдэг юм.

Мэдэхэд илүүдэхгүй

Тайланг санал, хамтын оролцоогоор сайжруулах нь



ХБТМ-ын тайлан боловсруулах үйл явц нь олон үе шаттай санал авах, хамтран ажиллах боломжийг агуулсан байдаг. Гол оролцогч талуудын санал, НЗТ-ийн хариуцсан ажлын алба, Үндэсний зөвлөлийн (ҮЗ) гишүүд зэрэг гол оролцогчид нь тайланг нийтлэлээс 21 хоногийн өмнөх хянах хугацаанд шууд санал өгөх боломжтой. Нийтийн санал авах үе шатанд 14 хоногийн хугацаанд ХБТМ тайлан дээр олон нийтийн санал авахад нээлттэй болгох, хүн бүр санал, сэтгэгдэл ирүүлэх боломжтой болгодог. Энэхүү хамтын ажиллагаанд тулгуурласан аргачлалыг ашигласнаар тайлан нь тухайн улсын нээлттэй засгийн шинэчлэлийн бодит ахиц дэвшлийг нарийвчлан, үнэн зөв тусгах нөхцөлийг бүрдүүлдэг.

8.3 ХБТМ шаардлагыг хэрхэн дүгнэдэг вэ?

НЗТ-ийн Оролцоо ба хамтран бүтээх стандарт нь НЗТ-ийн мөчлөгийн турш Засгийн газар болон иргэний нийгмийн хамтын ажиллагаанд тавигдах 5 үндсэн стандартыг тодорхойлдог. Стандарт бүр нь тодорхой, хэмжигдэхүйц, зайлшгүй биелүүлэх шаардлагатай бөгөөд НЗТ-ийн гишүүн орон бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх явцад эдгээр шаардлагыг хангах ёстой. ХБТМ нь эдгээр шаардлагыг хангасан эсэхийг үнэлдэг юм.

ХБТМ нь дараах хүчин зүйлийг харгалзан үзэж үнэлгээ хийнэ:

- Зайлшгүй биелүүлэх бүх шаардлагыг үйл ажиллагааны мөчлөгийн үед биелүүлсэн байх ёстой.
- Засгийн газар нь шаардлага биелүүлсэн гэдгээ нотлох баримт бүрдүүлэх үүрэгтэй. ХБТМ нь Засгийн газар болон иргэний нийгмийн ирүүлсэн бичиг баримтыг шалган, цахимаар судалгаа хийж, баримтын сан, цахим хуудаст буй мэдээллийг нягтална ("**Мэдээллийн ил тод байдлыг хангах**" стандартын шаардлага хэсгийг үзнэ үү).
- ХБТМ нь НЗТ-ийн үйл явцад оролцсон оролцогчдоос ярилцлага авна.

"**НЗТ-ийн үйл явцын эсрэг үйлдэл хийсэн**" гэж тооцогдох 2 шалгуурыг ХБТМ үнэлдэг. Энэ нь улс орон зайлшгүй биелүүлэх шаардлагыг бүгдийг нь хангаагүй ба Үйл ажиллагааны төлөвлөгөөний ямар ч үүрэг амлалтад ахиц дэвшил гаргаагүй тохиолдлыг хэлнэ. ХБТМ эдгээр шалгуурын аль нэгийг хангаагүй гэж үзвэл НЗТ-ийн Дэмжих нэгжид мэдэгдэл хүргүүлдэг.

Зайлшгүй биелүүлэх шаардлагын үнэлгээ хийхэд ХБТМ-ын харгалзан үзэх үндсэн шалгуур, нотолгоотой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ХБТМ-ын "**Зайлшгүй биелүүлэх шаардлагын үнэлгээний удирдамж**"-аас үзнэ үү.



9 НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН СОРИЛТООР АМЖИЛТАА АХИУЛАХ НЬ

Гол зөвлөмж

- Нээлттэй засгийн сорилт нь НЗТ-ийн гишүүн орныг нээлттэй засгийн 10 үндсэн чиглэлээр хүсэл зорилготой шинэчлэл хийхийг уриалдаг.
- НЗТ-д харьяалагддаг аливаа төрийн байгууллага (ямар ч шат, салбар байж болно) энэ сорилтод оролцох боломжтой.
- НЗТ-ийн гишүүн орон үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган, үүрэг амлалтаа бүртгүүлэх эсвэл бие даасан үүрэг амлалтаар оролцож болно.
- Сорилтод хамрагдах үүрэг амлалт бүр нь тодорхой шалгуур үзүүлэлтийг хангасан байх ёстой. Эдгээр шаардлагыг хангаснаар албан ёсоор бүртгэгдэнэ.



Нээлттэй засгийн сорилтыг 2023 онд Удирдах хорооноос санаачлан эхлүүлсэн бөгөөд бүх гишүүн орнуудад хандсан уриалга юм. Нээлттэй засгийн **10 үндсэн чиглэл**ээр хүсэл зорилготой шинэчлэл хийхийг урамшуулснаар ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах юм. Сорилт нь гишүүн орнуудыг НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах эсвэл түлхүүр шинэчлэлийг санаачлах замаар боломжит олон чиглэлээр бодит ахиц гаргахыг зорьдог.

Сорилтын чиглэл бүрд түлхүүр шинэчлэлийн санаачилгууд болон тухайн чиглэлд хамаарах шинэчлэлийн цар хүрээг тодорхойлсон байдаг. **Нээлттэй засгийн гарын авлага**д сорилтын чиглэл, тодорхой зөвлөмж, шинэчлэлийн жишээ, олон улсын стандарт, зааварчилгааг багтаасан юм. Энэхүү гарын авлага нь сорилтод бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай.

THE OPEN GOV CHALLENGE



9.1 Яагаад сорилтод нэгдэх хэрэгтэй вэ?

НЗТ-ийн гишүүн орон энэхүү сорилтод оролцсоноор дараах олон талын ашиг тусыг хүртдэг:

- Сорилтыг улс төрийн хөшүүрэг болгон ашигласнаар шинэчлэлийн үйл явцыг хурдасгаж, зорилгодоо илүү үр дүнтэй, богино хугацаанд хүрэх боломж бүрддэг.
- Шинэчлэгчид тухайн салбартаа итгэл хүлээсэн, нөлөө бүхий оролцогч болж, хамтрагч талууд болон олон нийт дэх нэр хүндээ нэмэгдүүлдэг.
- Сорилтыг дэмжиж буй түншүүдээс мэргэжлийн зөвлөгөө, нөөц, арга зүй, сургалт зэргээр шууд тусламж авч, амжилтад хүрэх боломжоо нэмэгдүүлдэг.
- Сорилтод хамтран оролцогч орнуудын дунд манлайллын ур чадварыг хөгжүүлэх, сүлжээ үүсгэх, өргөн цар хүрээтэй, хүсэл зорилготой шинэчлэлд хамтран ажиллах боломж нээгдэнэ.
- Сорилтын хүрээнд тусгай шагнал олгодог бөгөөд НЗТ-ийн арга хэмжээ, нийтлэл, харилцаа холбооны сувгаар амжилт, хувь нэмрийг албан ёсоор онцолдог.

9.2 Тавигдах шаардлага

НЗТ-ийн гишүүн орны бүх шат, салбарын төрийн байгууллагууд энэ сорилтод орох боломжтой. Хэрэв нэг улс доторх хэд хэдэн төрийн байгууллага ижил сорилтод оролцохоор хүсэлт гаргавал НЗТ-ийн Дэмжих нэгж эдгээр оролцогчдын хооронд уялдаа холбоог хангахыг зорих болно. Иргэний нийгмийн байгууллагууд болон бусад түншүүдэд сорилтыг хамтран бүтээх, дэмжихийг идэвхтэй уриалж байгаа боловч сорилтыг заавал төрийн байгууллага хэрэгжүүлэх ёстой юм (Өөрөөр хэлбэл, удирдлага, хариуцлага нь төрийн байгууллагад хамаарна).

Гишүүн орон дараах хэлбэрээр сорилтод оролцож болно:

- НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тухайн сорилтын чиглэлтэй уялдаатай үүрэг амлалтыг хамтран бүтээж тусгах эсвэл
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс тусдаа бие даасан үүрэг амлалтаар оролцох. Жишээлбэл, үйл ажиллагааны мөчлөгөөс гадуур шинэ боломж гарсан үед ҮЗ-д хараахан нэгдээгүй байгууллагууд оролцоход эдгээр сонголтууд нь хоорондоо харшлахгүй бөгөөд зэрэгцэн хэрэгжүүлж болно.

НЗТ-ийн гишүүн болон гишүүн бус орныг сорилтын чиглэлээр хийж буй ажлынхаа талаар түүх, туршлагаа хуваалцахыг уриалдаг. Эдгээр түүх нь албан ёсоор үнэлэгдэхгүй ч гэсэн сорилтыг сурталчлах, урам зориг өгөх зорилгоор ашиглагдана.

9.3 Сорилтын үүрэг амлалтын хүлээн зөвшөөрөгдөх байдал

Дараах бүх шалгуурыг хангасан үүрэг амлалт эсвэл үйл ажиллагааг сорилтод хамруулна:

- Сэдвийн уялдаа: Үүрэг амлалт нь сорилтын тодорхой чиглэлд нийцсэн зорилтыг дэмжих ёстой. НЗТ-ийн гишүүдийг бодлого, хууль тогтоомж, институцийн түвшинд тогтолцооны шинжтэй, гүнзгий шинэчлэл хийх, иргэн болон төр хоорондын харилцаанд шинэлэг өөрчлөлт авчрах, НЗТ-ийн гишүүдийн дунд анхдагч байр суурь эзлэхүйц санаачилга байх, хүсэл зорилготой үүрэг амлалт өгөхийг уриалж байна.
- Ирээдүйд чиглэсэн: Үүрэг амлалт нь одоо хэрэгжиж буй эсвэл төлөвлөгдсөн байх ёстой. Ирээдүйд биелэх, шалгаж баталгаажуулах боломжтой шинэчлэл багтсан байх шаардлагатай.
- Нээлттэй засгийн уялдаа: Үүрэг амлалт нь нээлттэй засгийн ил тод байдал, нийтийн эгэх хариуцлага, иргэдийн оролцооны зарчмын аль нэгтэй уялдсан байх ёстой.
- Төрийн байгууллага удирдах. Үүрэг амлалт нь НЗТ-ийн гишүүн орны аливаа шатны, салбарын төрийн байгууллагаар удирдуулсан байх ёстой. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх нь маш сайн дэмжигдэнэ.

9.4 Хүсэлт илгээх дүрэм

Гишүүд сорилтод орох механизмаас хамааран дүрэм журам нь өөр өөр байна:

- **Үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалтууд** нь үндсэндээ НЗТ-ийн Оролцоо ба хамтран бүтээх стандарт болон тайлагнах шаардлагыг даган мөрдөнө (үндсэндээ [“НЗТ-ийн Оролцоо ба хамтран бүтээх стандарт”](#) болон [“ХБТМ-аар дамжуулан Хариуцлага ба суралцах үйл явцыг хангах”](#) хэсгээс үзнэ үү). Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан хүргүүлсэн өргөдлийг ХБТМ үнэлгээний аргачлалаар хянаж үзнэ.
 - НЗТ-ийн үүрэг амлалтын загварыг өөрчилсөн бөгөөд үүгээр гишүүд сорилтын хүрээнд хэрэгжүүлж буй үүрэг амлалтаа тусгайлан тэмдэглэх боломжтой болсон.
 - Үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалт нь тухайн төлөвлөгөөний хэрэгжилтийн хуваарийг дагана. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө аль хэдийн хүргүүлсэн гишүүд тодорхой хугацааны хүрээнд “сорилтын үүрэг амлалт”-ыг нэмэх зорилгоор төлөвлөгөөг засварлах боломжтой.
- Бие даасан үйл ажиллагаа эсвэл үүрэг амлалтын маягыг ямар ч үед бөглөх боломжтой ([Англи](#), [Испани](#), [Франц](#) хэл дээр байдаг). Бие даасан үүрэг амлалт болон шагналын бүртгэлийн хувьд, тухайн сорилтын шалгуурт нийцсэн байх ёстой. Эдгээр үүрэг амлалтыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төлөвлөх, хэрэгжүүлэх болон/эсвэл үнэлэх үйл явцад оролцохыг зөвлөдөг.

Нээлттэй засгийн сорилт

- Сорилттой холбоотой завсрын болон эцсийн үнэлгээг ХБТМ хийдэг бөгөөд тухайн үеийн боломжит мэдээлэлд үндэслэн үнэлгээ хийнэ.


Сорилттой холбоотой үүрэг амлалтыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрхэн багтаах болон бусад мэдээллийг “[Сорилтын түгээмэл асуулт, хариулт](#)” хэсгээс үзнэ үү.



10 Засгийн газрын бусад түвшинд оролцоог дэмжих нь

Гол зөвлөмж

- НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь нээлттэй засгийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, нээлттэй засгийн зарчмуудыг хэвшүүлэхийн тулд төрийн байгууллагуудын бүх түвшинд, салбарын оролцоо маш чухал болохыг хүлээн зөвшөөрдөг.
- Орон нутгийн засаг захиргаа, парламент, шүүхийн байгууллагууд болон бие даасан байгууллагууд бүгд нээлттэй засгийг дэвшүүлэхэд өөр өөрийн чухал үүрэгтэй.
- НЗТ нь эдгээр дөрвөн бүлэг байгууллага тус бүрт зориулсан заавар, зөвлөмж боловсруулсан бөгөөд НЗТ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжтой.
- Эдгээр байгууллагууд НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцохдоо холбогдох дүрэм, шаардлага болон стандартыг мөрдөх ёстой.
- Орон нутгийн засаг захиргаа “[Орон нутгийн НЗТ](#)” нэртэй тусгай хөтөлбөрөөр дамжуулан НЗТ-д оролцож болдог.
- Парламент, шүүхийн байгууллага болон бие даасан байгууллагууд тодорхой тохиолдолд бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж оролцох боломжтой.
- НЗТ-ийн гишүүн орны дээрх дөрвөн бүлгийн аль нь ч нээлттэй засгийн сорилтод үүрэг амлалт гаргах эрхтэй.



Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө нь НЗТ-д оролцох үндсэн бүрэлдэхүүн хэвээр байгаа ч, НЗТ-ийн үйл ажиллагааны хүрээ нь төрийн байгууллагын түвшинд, салбар бүрийн оролцоог хангах нь нээлттэй засгийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлж, нээлттэй засгийн зарчмуудыг өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд нэн чухал болохыг хүлээн зөвшөөрдөг. Энэхүү оролцоо нь төрийн салбар хоорондын тэнцвэр, хяналт шалгалтыг бий болгоход зайлшгүй шаардлагатай.

10.1 Орон нутгийн засаг захиргаа

Орон нутгийн засаг захиргаа нь иргэдийн амьдралд шууд нөлөө үзүүлдэг бодлого, үйлчилгээний хариуцагч байдгаараа дэлхий нийтийн сорилтыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Тэд засаглалын шинэчлэл, инновацийн төв болж, эдгээр асуудлыг шийдвэрлэхээр тэргүүн шугаманд ажилладаг. Хамгийн гол нь орон нутгийн засаг захиргаа нь шинэчлэлийн лаборатори болж чаддаг юм. Энд нээлттэй засгийн санаачилгыг туршиж сайжруулан, үндэсний түвшинд өргөтгөн хэрэгжүүлэх боломжтой байдаг. Засгийн газар бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, нийтлэг сорилтыг шийдвэрлэхэд орон нутгийн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурладаг. Нөгөө талаас орон нутгийн байгууллагууд үндэсний түвшинд хамтын ажиллагааг дэмжсэн, инновацийн бодлогыг тусгасан, хэрэгжилтийг хангахуйц эрх зүйн болон бодлогын орчны хүрээнд ажиллах нь илүү үр дүнтэй байдаг.

Орон нутгийн засаг захиргаа нь нээлттэй засгийг дэвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг тул НЗТ тэдэнд зориулсан тусгай гишүүнчлэлийн түвшин бий болгон хамтран ажилладаг. Мөн орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагааны төлөвлөгөөний явцад оролцох, нээлттэй засгийн сорилтод нэгдэх хэлбэрээр НЗТ-д оролцох боломжтой.

10.1.1 Орон нутгийн түвшинд НЗТ-ийн гишүүнчлэл

[Орон нутгийн засаг захиргаа](#) НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрөөр дамжуулан НЗТ-д оролцох боломжтой. Энэхүү хөтөлбөр нь Засгийн газрын нэгэн адил төрийн бус оролцогч талуудтай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхэд чиглэдэг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг [“Орон нутгийн НЗТ-ийн гарын авлага”](#)-ын дагуу боловсруулдаг. Эдгээр төлөвлөгөөнд ХБТМ дүгнэлт хийдэггүй. Харин ХБТМ нь хоёр жил тутам гаргадаг Орон нутгийн тайланд орон нутгийн нээлттэй засгийн талаарх сургамж, амжилтын түүх, шинэлэг арга замыг тэмдэглэдэг.

НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#) авна уу.

10.1.2 Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн үүрэг амлалтыг тусгах

НЗТ нь үндэсний болон орон нутгийн түвшний стратегийн хамтын ажиллагааг дэмжин, бүх түвшинд шинэчлэл хийхийг зорьдог. Үүнд НЗТ-ийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явц ч мөн хамаарна.

Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан орон нутгийн түвшний үүрэг амлалт дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Засгийн газар болон иргэний нийгмийн хамтран оролцоотойгоор төлөвлөгөө боловсруулан хамтран бүтээгдсэн байх.
- Орон нутгийн цар хүрээтэй боловч үндэсний бодлого эсвэл улсын түвшний хөтөлбөрөөс урган гарсан байх. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө нь стратегийн ач холбогдолтой, хэрэгжилт ба үнэлгээний хувьд удирдах боломжтой байх үүднээс орон нутгийн засаг захиргаа хэрэгжүүлдэг үүрэг амлалт дараах зорилгод нийцсэн байхыг зөвлөж байна:

Бусад түвшний оролцоо

- Улсын хэмжээнд хэрэгжих нээлттэй засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах — зарим улс орнууд бүх институт болон засаг захиргааны түвшинг хамарсан нээлттэй засгийн стратегийг баталж, эдгээр түвшний хоорондын уялдаа холбоог шаарддаг.
- Орон нутгийн засаг захиргаа үндэсний бодлогыг орон нутагт хэрэгжүүлэхийг дэмжих, ялангуяа орон нутгийн түвшинд үндэсний зохицуулалтыг дагаж мөрдөх шаардлагатай үед энэ нь чухал бөгөөд орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг.
- Нээлттэй засгийн талаарх мэдлэг ойлголтыг орон нутгийн нөхцөл байдалд түгээн дэлгэрүүлэх. Жишээлбэл, мэдлэг солилцооны үйл ажиллагаа зохион байгуулах эсвэл үндэсний болон орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн хооронд туршлага, шинэ санаа солилцох сүлжээ байгуулах зэрэг болно.
- Орон нутгийн нээлттэй засгийн шинэлэг санаачилгыг онцлох, өндөр нөлөө үзүүлэх чадамжтай, бусад орон нутагт хэрэгжүүлэх боломжтой, хүсэл зорилготой санаачилгыг багтаах.
- Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд багтсан үүрэг амлалтыг ҮЗ тогтмол хянаж, НЗТ-ийн стандарт болон шаардлагын дагуу жилд хоёр удаа баримтын санд оруулах ёстой.
- Хэрвээ үүрэг амлалтыг НЗТ-ийн Орон нутгийн гишүүн, орон нутгийн засаг захиргаа хэрэгжүүлж байгаа бол энэ үүрэг амлалтыг орон нутгийн НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд давхардуулан оруулах ёсгүй.

Хэрвээ үүрэг амлалт нь дээр дурдсан шаардлагыг хангахгүй бол тэдгээр үйл ажиллагааг "Орон нутгийн нээлттэй засгийн нэмэлт санаачилга" гэсэн хэсэгт багтааж төлөвлөгөөнд тусгахыг зөвлөж байна. Эдгээр санаачилгыг албан ёсны үүрэг амлалт гэж тооцохгүй бөгөөд ХБТМ эдгээрийг бие даан үнэлэхгүй. Гэсэн ч тэдгээрийг төлөвлөгөөнд тусгасан тохиолдолд ХТБМ нь "Орон нутгийн нээлттэй засгийн нэмэлт санаачилга"-ын талаар үнэлгээндээ дурдан, тэдгээрийн ерөнхий онцлог, зорилго, тухайн төлөвлөгөө болон НЗТ-ийн үйл явцтай хэрхэн уялдаж байгааг товч тайлбарлана.

Үндэсний ба орон нутгийн хамтын ажиллагаа, хамтран ажиллах олон хувилбар, шийдлийн талаар ["Хамтын ажиллагаагаар урагшлах нь: Нээлттэй засгийг ахиулах үндэсний-орон нутгийн хамтын ажиллагаа"](#) хэвлэлд дэлгэрэнгүй мэдээлэл бий.

10.1.3 Нээлттэй засгийн сорилтод оролцох

НЗТ-ийн Орон нутгийн хөтөлбөрт нэгдсэн орон нутгийн засаг захиргаа болон НЗТ-ийн гишүүн орны бүрэлдэхүүнд багтдаг ч хараахан нэгдээгүй орон нутгууд нь үндэсний НЗТ-ийн үйл явцтай уялдсан эсэхээс үл хамааран, Нээлттэй засгийн сорилтод үүрэг амлалт гаргах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг [сорилтын хэсгээс](#) үзнэ үү.

10.2 Парламент

Парламент нь нээлттэй засгийг ахиулахад хууль санаачлах, хэлэлцэх, батлах болон шинэчлэлд шаардагдах төсөв батлах замаар чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн гүйцэтгэх засгийг хяналтдаа байлгах, өөрсдийн хяналтын үйл явцыг ил тод болгох замаар хяналтын механизм болдог. Түүнчлэн парламент нь өөрсдийн институцийн үйл ажиллагаандаа нээлттэй засгийн зарчмуудыг нэвтрүүлж, нам хоорондын яриа хэлэлцүүлгийг дэмжих замаар шинэчлэлийг тогтворжуулах боломжтой.

Парламентын оролцоо нь НЗТ үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн нээлттэй засгийн үзэл баримтлалын салшгүй хэсэг байсаар ирсэн. Учир нь шинэчлэлийг тогтворжуулах, иргэний

Бусад түвшний оролцоо

орон зайг дэмжих, ардчилсан үйл явцыг хамгаалах зэрэг олон зорилго нь парламентын дэмжлэгийг шаарддаг. Мөн парламент нь нээлттэй засгийн шинэчлэлийн хэлэлцэх асуудлыг тодорхойлох, нээлттэй засгийн орон зайг бүрдүүлэх чиглэлээр чухал үүрэгтэй.

Парламентын оролцоог, ялангуяа нээлттэй засгийн томоохон шинэчлэлийг ахиулахыг тууштай зөвлөж байна. Гэсэн хэдий ч, энэ нь НЗТ-д оролцоход заавал биелүүлэх шаардлага биш юм. [Парламентын оролцооны талаарх санамж бичиг](#)т парламентын оролцооны гурван үндсэн загварыг тодорхойлсон байдаг. Эдгээрээс Үндэсний НЗТ-ийн үйл явцад оролцох ба Парламентын бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах хоёр нь НЗТ-д парламент хэрхэн оролцож болох талаарх хувилбарууд юм. Үүнээс гадна парламент нь нээлттэй байдлыг дэмжих бусад төрлийн үйл ажиллагаанд ч оролцож болно. Жишээлбэл, Нээлттэй засгийн сорилт зэрэг санаачилгад нэгдэх боломжтой.

10.2.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох

[Судалгаанаас харахад](#) үндэсний болон орон нутгийн НЗТ-ийн үйл явц болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд шууд оролцох нь парламентад боломжит уялдаа холбоог илүү сайн судлах, нээлттэй засгийн өргөн хүрээний шинэчлэлийг ахиулахад илүү үр нөлөөтэй үүрэг гүйцэтгэх боломжоор хангадаг болохыг харуулж байна. Иймд НЗТ-ийн гишүүн орны парламент үндэсний үйл явцдаа шууд оролцох боломж эрэлхийлэхийг уриалж байна. Парламентын оролцооны талаарх [санамж бичиг](#) нь парламент үндэсний НЗТ-ийн үйл явцад оролцохтой холбоотой нөхцөл болон НЗТ-ийн Дэмжих нэгжээс парламент болон бусад оролцогч талуудад үзүүлж буй дэмжлэгийг тодорхойлдог. Үүнд дараах гол элементийн багц багтана:

- Үндэсний НЗТ-ийн үйл явцад оролцохоор шийдсэн парламент нь [НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт](#) мөн холбогдох ҮЗ-өөс тогтоосон дүрэм, журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.
- Парламентын үүрэг амлалтыг тухайн улсын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэгдсэн байдлаар багтаах, эхлэх болон дуусах хугацааг баримтлах шаардлагатай.
- Парламентын үүрэг амлалт нь тайлагнал, хяналт шинжилгээний механизмд нэгэн адил хамаарах бөгөөд ХБТМ-ын үнэлгээнд мөн хамрагдана. ХБТМ нь хамтран бүтээх үйл явцын ерөнхий үнэлгээнд төвлөрдөг.

Санамж бичгээс гадна НЗТ-ийн Дэмжих нэгж нь [сонголтын жагсаалтыг](#) санал болгож байгаа бөгөөд энэ нь олон НЗТ-ийн гишүүдийн хэрэгжүүлж буй арга барилыг багтаасан, парламент хэрхэн НЗТ-д оролцож, нээлттэй засгийн шинэчлэлд хамтран бүтээгч болон хэрэгжүүлэгч байж болохыг харуулдаг.

10.2.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх

[НЗТ-ийн парламентын үйл ажиллагааны төлөвлөгөөг](#) бие даан боловсруулах нь парламентад үндэсний НЗТ-ийн үйл явцад шууд оролцох боломжгүй (эсвэл хараахан боломжгүй) нөхцөлд түр зуурын шийдэл болох буюу үндэсний НЗТ-ийн төлөвлөгөөнд оролцож буй тохиолдолд нэмэлт алхам болгон хэрэгжүүлж болно. Энэ нь парламентын оролцогч талуудын хувьд шаардлагатай гэж үзсэн нөхцөлд хамаарна. Хэрэв парламент бие даасан төлөвлөгөө боловсруулахаар шийдвэл, боловсруулах үйл явц нь [НЗТ-ийн парламентын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах гарын авлагыг](#) заавал дагаж мөрдөх ёстой. Энэ гарын авлага нь үйл явцын зохион байгуулалт, зайлшгүй биелүүлэх шаардлага, зөвлөмж, загвар зэрэгт анхаарал хандуулсан бөгөөд парламентын үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран бүтээх болон хэрэгжүүлэхэд чиглэдэг. Гарын авлагын гол агуулгад дараах зүйлс багтдаг:

- **Хүлээн зөвшөөрөх байдал ба үйл явц:** Идэвхтэй НЗТ-ийн гишүүн орны парламент хэрхэн бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, ирүүлэх боломжтойг тайлбарлана.
- **Зайлшгүй биелүүлэх шаардлага:** Оролцооны үндсэн шалгуур болох НЗТ-д албан

Бусад түвшний оролцоо

ёсоор мэдэгдэл хүргүүлэх, төлөөлөгчийг томилох, олон нийтийн оролцоо, санал авах үйл явцыг хангах, үнэлгээний тайланг хугацаанд нь ирүүлэх зэргийг тодорхойлно.

- **Үүрэг хариуцлага:** Парламентын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явцад оролцох гол түлхүүр оролцогчид, тэдний уялдаа холбоо, хэрэгжилт, хяналт шалгалтын чиг үүргийг тодорхойлно.
- **Заавар ба хэрэгсэл:** Хамтран бүтээгчээр ажиллах, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэхэд зориулсан гарын авлага, загвар болон эх сурвалжийг багтаана. Үүнд үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг амлалтын загвар маягт орно.

10.2.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх

НЗТ-ийн гишүүн орны парламент Нээлттэй засгийн сорилтыг ашиглан бие даасан үүрэг амлалт гаргах эрхтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг [“Шүүхийн байгууллагын Нээлттэй засгийн сорилт”](#) хэсгээс үзнэ үү.

10.3 Шүүх байгууллага

Шүүх эрх мэдлийн байгууллага (ШЭМБ) нь нээлттэй засагт төлөвлөж буй үүрэг амлалттай холбоотой хууль зүйн асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн ил тод байдал, шударга шүүхэд хүрэх боломж болон шүүхийн байгууллагын шударга байдалтай холбоотой арга хэмжээнд оролцох, гомдлын болон маргаан шийдвэрлэх механизмын хүрээнд нээлттэй засгийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд хяналт тавих зэргээр оролцох боломжтой. [“Шүүх эрх мэдлийн байгууллага НЗТ-д оролцох”](#) баримт бичигт ШЭМБ нь НЗТ-д оролцох гурван үндсэн арга замыг тодорхойлсон байдаг.

10.3.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох

Энэ бол хамгийн зорилтот арга зам бөгөөд ШЭМБ нь НЗТ-д оролцож буй ихэнх улс орны хамгийн түгээмэл сонгодог загвар юм. ШЭМБ-ын үндэсний түвшний үйл явцад оролцох нь төрийн гурван эрх мэдэл хоорондын нээлттэй засгийн уялдаа холбоог судлах чухал боломжийг олгодог. Мөн нэгтгэсэн үндэсний үйл явц нь хамтран бүтээх болон зөвлөлдөх үйл ажиллагаанд зарцуулах цаг, нөөцийг илүү үр ашигтай ашиглах боломж олгож, иргэний нийгмийн зүгээс НЗТ-тэй холбоотой үйл ажиллагаанд оролцох зардлыг бууруулдаг.

ШЭМБ-ын төлөөлөгчид нь заавал [НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт](#), тухайн улсын ҮЗ-өөс тогтоосон дүрэм, журмыг дагаж мөрдөх ёстой. Үүнд НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний эхлэх ба дуусах хугацааг баримтлах, тогтмол тайлагнах, хяналт-шинжилгээний механизмд хамрагдах, ХБТМ-ын үнэлгээнд хамрагдах шаардлагатай.

10.3.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх

Энэ хувилбар нь хууль эрх зүй, улс төр болон практик шалтгаанаар шүүх эрх мэдлийн байгууллага бие даасан төлөвлөгөө боловсруулах нь илүү тохиромжтой тохиолдолд хэрэгжих боломжтой. Энэ нь иргэний нийгэмтэй хамтран бүтээх, өөрсдийн үйл ажиллагаа, системийг ил тод болгох үүрэг амлалтыг хэрэгжүүлэх мөн өөрсдийн хуваарь болон стратегийн зорилттой бүрэн нийцтэйгээр ажиллах боломжийг олгодог.

Энэ хувилбар нь зөвхөн дээд шатны шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөгчдөд хамаарна. Үүнд Дээд шүүх, өндөр түвшний шүүх болон шүүхийн зөвлөл ордог бөгөөд эдгээр байгууллага нь улсын хэмжээнд шийдвэр, стандарт, журам тогтоох болон хяналт тавих эрх мэдэлтэй байх ёстой. Энэхүү хувилбарыг авч үзэж буй ШЭМБ нь НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандартыг, ялангуяа стандарт 3, 4, 5-г мөрдөж өөрийн НЗТ-ийн үйл явцыг төлөвлөх хэрэгтэй.

10.3.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх

Гишүүн орны ШЭМБ нь Нээлттэй засгийн сорилтыг ашиглан өөрийн бие даасан үүрэг амлалтыг танилцуулах эрхтэй. Дэлгэрэнгүй мэдээллийг “[Нээлттэй засгийн сорилт](#)” хэсгээс үзнэ үү.

10.4 Бие даасан байгууллага

Бие даасан байгууллагууд (БДБ) болох Үндэсний аудитын байгууллага эсвэл Омбудсмен зэрэг байгууллага нь НЗТ-д бие даасан хяналт шалгалт хийх, өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд ил тод байдал, хариуцлагыг дэмжих, өөрсдийн институцийн чиг үүрэгтэй уялдсан үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр оролцож болно. “[Бие даасан байгууллага НЗТ-д оролцох](#)” баримт бичигт БДБ нь НЗТ-д оролцох гурван үндсэн арга замыг тодорхойлсон байдаг.

10.4.1 НЗТ-ийн үндэсний үйл явцад оролцох

Энэ нь хамгийн тохиромжтой бөгөөд БДБ нь НЗТ-д оролцож буй улс орны дунд хамгийн өргөн хэрэглэгддэг загвар юм. БДБ-ын үндэсний үйл явцад оролцох нь төрийн эрх мэдлийн байгууллага хооронд нээлттэй засгийн уялдаа холбоог судлах чухал боломжийг НЗТ-ийн оролцогч талуудад олгодог. Нэгтгэсэн үндэсний үйл явц нь хамтран бүтээх, зөвлөлдөх үйл ажиллагаанд зарцуулах цаг, нөөцийг илүү үр ашигтай ашиглах, иргэний нийгмийн зүгээс НЗТ-тэй холбоотой үйл ажиллагаанд оролцох зардлыг бууруулах боломжийг бүрдүүлдэг.

БДБ-ын төлөөлөгчид нь заавал [НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт](#), тухайн улсын ҮЗ-өөс тогтоосон дүрэм, журмыг мөрдөх шаардлагатай. Үүнд НЗТ-ийн үүрэг амлалтын төлөвлөгөөний эхлэх ба дуусах хугацааг баримтлах, тогтмол тайлагнах, хяналт-шинжилгээний механизмд хамрагдах, ХБТМ-ын үнэлгээнд хамрагдах зэрэг хамаарна.


10.4.2 НЗТ-д бие даасан төлөвлөгөө боловсруулж нэгдэх

Энэ хувилбар нь хууль эрх зүй, улс төр эсвэл практик нөхцөл байдлын улмаас бие даасан төлөвлөгөө боловсруулах нь илүү тохиромжтой тохиолдолд хэрэгжих боломжтой. Энэ нь иргэний нийгэмтэй хамтран үүрэг амлалт боловсруулах, байгууллагын үйл ажиллагаа, системийг илүү нээлттэй болгох алхмыг өөрсдийн ажлын хуваарь болон стратегийн зорилттой бүрэн уялдуулан хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Энэ нь гүйцэтгэх засаглалд хамаарахгүй, Үндсэн хууль болон хуулиар тогтоогдсон үндэсний байгууллагад хязгаарлагдана. Энэ хувилбарыг сонгохоор төлөвлөж буй БДБ нь НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт, ялангуяа стандарт 3, 4, 5-г мөрдөж өөрийн НЗТ-ийн үйл явцыг төлөвлөх ёстой.

10.4.3 Нээлттэй засгийн сорилтод нэгдэх

Гишүүн орны БДБ нь Нээлттэй засгийн сорилтыг ашиглан өөрийн бие даасан үүрэг амлалтыг танилцуулах боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг “[Нээлттэй засгийн сорилт](#)” хэсгээс үзнэ үү.



11 Нэмэлт материал

Энэ хэсэгт гарын авлагад дурдсан бүх зөвлөмжийн баримт бичиг, холбоос, нийтлэл, нөөц материал, загвар болон хэрэгслийг нэгтгэн оруулсан болно.

1. Үүсгэн байгуулсан зарчмууд

Нээлттэй засгийн тунхаглал: НЗТ-д нэгдсэн бүх гишүүн орны баталсан, ил тод байдал, иргэдийн оролцоо, нийтийн эгэх хариуцлага зэргийг дэмжих үндсэн зарчим юм.

НЗТ-ийн стратеги: 2023–2028 он хүртэлх таван жилийн стратеги нь нээлттэй засгийн шинэчлэгчдийн уялдаа холбоотой олон нийтийг бий болгох, нээлттэй засгийг бүх түвшний засаглалд төв байр суурьтай болгох, иргэний орон зайг хамгаалах, шинэчлэлийг түргэсгэх, шинэлэг санаа, түүхийг онцлон харуулах зорилготой.

НЗТ-ийн гишүүд: НЗТ-д оролцож буй бүх Засгийн газрыг хайх боломжтой жагсаалт.

Орон нутгийн НЗТ: Орон нутгийн засаг захиргаа НЗТ-д хэрхэн оролцдог талаарх мэдээлэл.



2. НЗТ-ийн гишүүнчлэл, засаглал ба үйл ажиллагааны хүрээ

Засаглалын баримт бичгүүд: НЗТ-ийн мандат болон бодлого, үүнд Удирдах хороо, НЗТ-ийн Дэмжих нэгж, ХБТМ-ыг багтаасан бүтцийг тодорхойлдог.

НЗТ-д нэгдэх: Засгийн газрууд НЗТ-д нэгдэхийн тулд хангах шаардлага, үүнд шийдвэрлэх шалгуур, шалгалт, иргэний нийгмийн оролцоо зэрэг багтана.

Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур: Улс орон НЗТ-д нэгдэхийн өмнө үнэлэгдэх дөрвөн үндсэн чиглэл.

НЗТ-ийн шалгалт: НЗТ-д нэгдэх хүсэлтэй улс орны хувьд V-Dem-ийн “Ардчиллын өгөгдлийн сан”-гийн хоёр үзүүлэлтэд үндэслэн хийгддэг үнэлгээ.

Хүлээн зөвшөөрөгдөх орнууд: Одоогоор НЗТ-д албан ёсоор нэгдээгүй ч нэгдэх боломжтой орнууд.

Засгийн газрын гишүүнчлэлийн хураамж: НЗТ-ийн гишүүнийн үйлчилгээ, улс төрийн оролцоо, сэдэвчилсэн санаачилгыг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн тогтолцоог тайлбарласан хэсэг.

НЗТ-ийн Дэлхийн дээд хэмжээний уулзалт: Нээлттэй засгийн туршлага хуваалцах, амжилтыг харуулах зорилготой төв арга хэмжээ.

Нээлттэй засгийн долоо хоног: Жил бүр зохион байгуулдаг кампанит ажил бөгөөд шинэчлэгчдийг хамтран бүтээх, нээлттэй засгийн шинэчлэлийг дэмжихэд чиглэдэг.

Удирдах хороо: НЗТ-ийн стратегийн чиглэлийг тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага.

НЗТ-ийн хамтран даргалагч: Удирдах хороог удирдан чиглүүлж, НЗТ-ийн стратегийн тэргүүлэх чиглэлийг дэмждэг дөрвөн хамтран даргалагч.

НЗТ-ийг хариуцсан албан тушаалтны гол үүрэг: Үндэсний үйл явцыг удирдан зохион байгуулахад хариуцах үндсэн үүргүүд.

НЗТ-ийн ажиллагааны хяналт: Оролцогч улс НЗТ-ийн үйл явцын шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг үнэлдэг, үүнд үүрэг амлалтыг цаг хугацаанд нь илгээх, хамтран бүтээх стандартыг дагаж мөрдөх, үүрэг амлалтын хэрэгжилтийг хянах орно.

НЗТ-ийн хууль ёсны хяналт: Гишүүн улс хоёр жил дараалан зайлшгүй биелүүлэх шалгуурт нийцээгүй тохиолдолд эхлүүлдэг бөгөөд нийцлийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

НЗТ-ийн хариу арга хэмжээний бодлого: Гишүүний үйл ажиллагаа НЗТ-ийн үнэт зүйлсэд ноцтой сөргөөр нөлөөлж, түншлэлийн нэр хүндэд эрсдэл учруулж буй онцгой нөхцөлд идэвхждэг.

НЗТ-ийн шуурхай хариу арга хэмжээний протокол: Үндсэн хариуцлагын механизмаар богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй ноцтой зөрчлийн тухай яаралтай гомдолд НЗТ шуурхай хариу арга хэмжээ авах боломжийг олгодог.

3. НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт

НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандарт: НЗТ-ийн үйл явцын бүх шатанд хамтын оролцооны удирдах таван стандарт байдаг ба тэдгээрт хамаарах заавал биелүүлэх шаардлагын цогц юм.

ХБТМ-ын үндсэн шаардлагыг үнэлэх зааварчилгаа: НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандартын дагуу нийцлийг үнэлэх шалгуур.

4. Үндэсний түвшинд хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэх нь: Үндэсний зөвлөл (ҮЗ)

Үндэсний түвшинд хэлэлцүүлгийн орон зайг бүрдүүлэх нь: Үндэсний зөвлөл (ҮЗ) НЗТ шалгалтын асуулгын хуудас: Улсын НЗТ тогтолцоо, форум, үйл явцыг үнэлэх хэрэгсэл.

5. Мэдээллийн ил тод байдлыг хангах нь

Ил тод байдлын шаардлагын товч тойм: НЗТ-ийн цахим хуудас болон баримтын санд тавигдах зайлшгүй биелүүлэх шаардлагыг товчоор харуулсан.

6. Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалт боловсруулах

Хамтран бүтээх болон үүрэг амлалт боловсруулах үйл явц: Оролцогч бүх талуудыг хамруулсан хамтын бүтээлийн үйл явцыг хэрэгжүүлэх практик алхмууд.

Үүрэг амлалтыг боловсруулах загвар: Өндөр чанартай, тодорхой, хянах боломжтой үүрэг амлалтыг боловсруулах загвар.

Дөрвөн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх санамж бичиг: Дөрвөн жилийн үүрэг амлалтад онцгой хамаарах шинэчлэх журам.

Нээлттэй засгийн зааварчилгаа: Бодлогын салбарын сэдэвчилсэн зөвлөмж буюу эрч хүчтэй үүрэг амлалтыг өдөөхөд зориулав.

НЗТ 10 буюу амьд үзүүлэлт: НЗТ-ийн хүрээнд оролцоо ба зоримог байдлын талаарх 10 жилийн өгөгдөл.

НЗТ хяналтын самбар: НЗТ-ийн үүрэг амлалттай холбоотой мэдээллийг хайж үзэх боломжтой платформ.

7. Үйл ажиллагааны төлөвлөгөө ба үүрэг амлалтыг хэрэгжүүлэх

Өөрийгөө үнэлэх загвар: Үүрэг амлалтад багтсан шинэчлэлийн эцсийн үр дүн, хэрэгжилтийн явцад хийсэн зөвлөлдөөн болон сургамжийг тайлагнах загвар.

8. Хараат бус тайлагнах механизмаар дамжуулан эгэх хариуцлага ба суралцах явцыг хангах нь

ХБТМ-ын тойм хуудас: НЗТ-ийн хариуцлагын хэсэг болон оролцогч орны ахиц дэвшлийг хянах үндсэн арга хэрэгслийн танилцуулга.

ХБТМ-ын үндсэн шаардлагыг үнэлэх зааварчилгаа: НЗТ-д оролцох болон хамтран бүтээх стандартын дагуу нийцлийг үнэлэх шалгуур.

ХБТМ-ын үйл явцын замнал: ХБТМ хэрхэн хугацаатай, зорилтот, загварчилсан суралцах явц болон хариуцлагын хэрэгслийг үүрэг амлалтын циклээр хангадаг тухай тайлбарласан.

ХБТМ-ын үйл ажиллагааны гарын авлага: ХБТМ-ын үнэлгээнд хэрэглэгдэх цогц арга зүй.

Чанарын баталгаажуулалтын хуралдааны ОУШЗ тойм: ХБТМ-ын мэргэжлийн багийн хяналтын үйл явцын тойм.

ХБТМ-ын хамтран бүтээх товч танилцуулга: Урьдчилсан ХБТМ-ын дүгнэлт болон дэлхийн нээлттэй засгийн практикт үндэслэн хамтын бүтээлийн үйл явцын хүртээмж, үр нөлөө, нийцлийг сайжруулах эхний зөвлөмжийг өгдөг.

ХБТМ-ын үүрэг амлалтын төлөвлөгөөний хяналт: Үүрэг амлалтын төлөвлөгөөний давуу тал, сорилтод бие даасан, нотолгоонд суурилсан шинжилгээ хийх бөгөөд хамтын бүтээлийн чанар, цаашид судлахаар сонгосон үүрэг амлалтыг онцгой анхаардаг.

ХБТМ-ын үр дүнгийн тайлан: Үүрэг амлалтын нийт хэрэгжилтийг үнэлж, бодлогын түвшний үр дүн, НЗТ-ийн стандартын дагуу нийцэл, хариуцлага болон суралцах үйл явцыг дэмжих мэдээллийг гаргадаг.

9. Нээлттэй засгийн сорилтоор амжилтаа ахиулах нь

Нээлттэй засгийн сорилтын цахим хуудас: Нээлттэй засгийн сорилтын тухай мэдээлэл авах, оролцох үндсэн төв.

Сорилтын салбарын тойм: Сорилтын 10 бодлогын салбарыг танилцуулсан.

Санал илгээх маягт: Сорилтуудад үүрэг амлалт илгээхэд зориулсан маягт.

Нийтлэг асуулт хариултын хуудас: Сайн санал илгээхэд зориулсан сорилтуудын чиглэл, удирдамж

10. Засгийн газрын бусад түвшинд оролцоог дэмжих нь

Орон нутгийн НЗТ: Орон нутгийн засаг захиргааны оролцооны мэдээлэл.

Орон нутгийн НЗТ-ийн гарын авлага: НЗТ-д оролцож буй орон нутгийн засаг захиргаанд зориулсан цогц гарын авлага.

Түншлэлийн хүрээн дахь ахиц дэвшил буюу Нээлттэй засгийг дэмжих үндэсний-орон нутгийн хамтын ажиллагаа: Нээлттэй засгийн үндэсний болон орон нутгийн хамтын ажиллагааны практик сургамж.

НЗТ дахь парламентын оролцоо буюу Баримтаас суралцах нь: Парламент НЗТ-ийн үйл явцад хэрхэн оролцож, хууль тогтоох ил тод байдал, хяналтын шинэчлэлтэд хувь нэмэр оруулахыг тайлбарласан.

Парламентын оролцооны санамж бичиг: Парламентыг НЗТ-ийн үйл явц, үүрэг амлалтад оролцуулах хүрээ, үндэслэлийг тодорхойлсон баримт бичиг.

Үндэсний НЗТ-ийн үйл явцад парламентын оролцоо буюу Сонголтын цэс: Парламент үндэсний НЗТ-ийн үйл явцад хэрхэн оролцон дэмжиж болох практик загвар, жишээг санал болгодог.

Нээлттэй парламентын төлөвлөгөө: Тусдаа бие даасан төлөвлөгөөг тодорхойлсон тайлбар үг.

НЗТ-ийн парламентын үүрэг амлалтын төлөвлөгөөний зааварчилгаа: Тусдаа бие даасан НЗТ төлөвлөгөө боловсруулж буй хууль тогтоох байгууллагад зориулсан заавар.

Шүүхийн салбарын байгууллагын НЗТ-д оролцоо: Шүүхийн байгууллага НЗТ-ийн үйл явцад оролцох заавар.

Бие даасан байгууллагын НЗТ-д оролцоо: Бие даасан байгууллага (жишээ нь: омбудсман, аудитын газар)-ын НЗТ-д оролцоход зориулсан зааварчилгаа.